

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 27
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	28 - 155
1. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	33 - 35
2. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	35 - 71
3. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	71 - 77
/үргэлжлэл/	80 - 86
4. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	77 - 78
/үргэлжлэл/	87 - 93
5. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	79 - 80
/үргэлжлэл/	93 - 98
6. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	98 - 120
7. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	120 - 141
8. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	141 - 142
9. Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	142 - 151
10. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	151 - 152
11. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	153 - 154
12. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	154 - 155

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 25-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 40 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 33 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, С.Ганбаатар, Г.Ганболд, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Б.Жавхлан, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Б.Жаргалмаа, Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан;

Тасалсан: Д.Батлут, Ж.Эрдэнэбат;

Хоцорсон: Э.Батиугар – 1 цаг 24 минут, Д.Ганбат – 1 цаг 21 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Г.Амартүвшин нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Г.Амартүвшин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Г.Ганболд, Э.Бат-Амгалан нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг.Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Боловсролын магадлан итгэмжлэлийн Үндэсний зөвлөлийн Ажлын албаны захирал Ж.Ариунболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нарантуяа, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дараагийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтов.

Уг асуудлыг 10 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох, мөн газрын ахлах шинжээч Ц.Намчинсүрэн, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл, Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Мөнхбат, Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Х.Баделхан, Ж.Сүхбаатар, Д.Сарангэрэл, Н.Ганибал, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Д.Сарангэрэл, Н.Энхболд, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Д.Ганбат нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд

нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Сайнхишиг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололлын санал хураалтыг түр хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их

Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Сайнхишиг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололлын санал хураалтыг түр хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Сайнхишиг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын

хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал хураалтыг түр хойшлуулахаар тогтов.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 22 минут үргэлжилж, 12 цаг 55 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 39 минутад эхлэв.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Нэг.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргсан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

4.5.Улсын Их Хурал тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас, шагналтай байна.

4.6.Улсын Их Хурлын оноосон нэртэй адил утга, агуулгатайгаар нэр, нэрийн товчлолыг зөвшөөрөлгүй ашиглахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.8 дахь хэсэг нэмэх:

“4.8.Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “хэлэлцэх нийт хугацааг тогтоох” гэснийг “хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.25 дахь хэсгийн “үл хүндэтгэсэн үйлдэл гэж үзнэ.” гэснийг “үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалтын “бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг” гэсний өмнө “халдашгүй байдал,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.12 дахь хэсэг нэмэх:

“27.12.Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “хянан шалгагч томилох, бичиг баримтад дүн шинжилгээ хийх зэрэг” гэснийг “хянан шалгагч, шинжээч томилох, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, гэрчээс мэдүүлэг авах зэрэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.5.3 дахь заалтын “яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар” гэснийг “яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15

Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 28.6, 28.11 дэх хэсэг нэмэх:

“28.6.Тухайн ээлжит чуулганы хугацаанд хоёр хүртэл хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хянан шалгах түр хороо байгуулах саналыг дараагийн ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэнэ.

28.11.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.4, 29.13 дахь хэсгийн “12” гэснийг “10” гэж, мөн зүйлийн 29.4, 29.9 дэх хэсгийн “12-оос” гэснийг “10-аас” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.3.Бүлэг даргаа гишүүдийн олонхын саналаар сонгож, бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрийн жагсаалтыг бүлгийн дарга Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлгийн эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “Бүлэг” гэсний дараа “бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаандаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.5.4 дэх заалтын “Хууль тогтоомжийн тухай хуульд” гэсний өмнө “энэ хуулийн 36 дугаар зүйл,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай хоёр дахь өгүүлбэр нэмэх:

“Энэ журам нь Төрийн албаны тухай хуулийн 54.2, 55.2-т заасан журмаар зохицуулах харилцаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39

59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39

59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.9, 24.10 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн “зардлыг” гэсний өмнө “үйл ажиллагааны” гэж, 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсгийн “ба” гэсний дараа “түүнээс” гэж тус тус нэмж, 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “зардлыг санхүүжүүлнэ.” гэснийг “үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулна.” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “зааснаас” гэснийг “заасны дагуу томилогдсоноос” гэж, 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийн “хууль тогтоомжийн” гэснийг “хуулийн” гэж, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийн “Энэ зүйлд” гэснийг “Энэ хуулийн 36 дугаар зүйлд” гэж, 44 дүгээр зүйлийн 44.4.1.6 дахь заалтын “кампанит ажилд” гэснийг “сурталчилгаанд” гэж, 46 дугаар зүйлийн 46.5.17 дахь заалтын

“мэдээллийн сан бүрдүүлж гишүүдэд үйлчлэх” гэснийг “мэдээллийн сан бүрдүүлэх” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “тогтоох асуудлыг” гэснийг хасах.

3.Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын болон тэдгээрт авсан эшлэлийн дугаарлалтыг өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар найруулгын санал дэмжигдлээ.

2.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.1.16 дахь заалт нэмэх:

“44.1.16.гишүүн нь бүрэн эрхийн хугацаандаа иргэд, сонгогчдод тайлангаас бусад эд зүйлс тараах, аливаа хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлдэл, үйл ажиллагаа хийхгүй байх.” гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хоёр.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ЖУРМЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “тус тус өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁶.2-т” гэснийг “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52.2-т” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасаж, төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2 дугаар зүйл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.“ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР:

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, “Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дэх заалтын “-ийг энэ тогтоолын” гэснийг “гэснийг “Улсын Их Хурлын гишүүний тойрогт ажиллах унааны лимит” гэж өөрчлөн энэ тогтоолын” гэж, төслийн 2 дахь заалтын “28 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 2, 3, 4, 5 дахь” гэснийг “28 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 2, 3, 4 дэх” гэж тус тус өөрчилж, уг тогтоолын 2 дугаар хавсралтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Улсын Их Хурлын гишүүний төсөв зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.2.4, 2.2-т “сонгогдсон тойрогтоо” гэснийг “тойрогт” гэж тус тус өөрчилж, мөн журмын 1.2.5-д “гэрээний үндсэн дээр ажиллуулах” гэснийг хасах.

2.Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн заалт, хавсралт болон тэдгээрт авсан эшлэлийн дугаарлалтыг өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар найруулгын санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Нэг.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЪЁОЛОЛ

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “хэлэлцэх хугацааг” гэсний дараа “хэлэлцүүлгийн үе шат бүрээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.7.Гишүүн хуралдаанд байр сууриа илэрхийлж үг хэлэх /цаашид “үг хэлэх” гэх/ хугацаа 4 минутаас илүүгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.14 дэх хэсгийн “программ, эсхүл санал хураах хуудсаар явуулна.” гэснийг “программ ашиглан явуулна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг хасах саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийн “хуулийн” гэснийг “хууль, тогтоолын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “зааснаас” гэснийг “заасан болон олон улсын гэрээ соёрхон батлахаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсгийн “энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийн “Энэ хуулийн 37.1-д” гэснийг “Энэ хуулийн 37.1, 37.2, 37.3-т” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсгийн “тайлбарлаагүй” гэснийг “бичээгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 115 дугаар зүйлийн 115.2.6 дахь заалтын “жил бүр” гэсний дараа “, Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг 2 жил тутам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 115.2.18 дахь заалт нэмэх:

“115.2.18.хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг Төсвийн байнгын хороо жил бүр” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 115 дугаар зүйлийн 115.3 дахь хэсгийн “тайланг” гэснийг “мэдээллийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 16

Бүгд: 39

59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“115.4.Энэ хуулийн 115.2, 15.3-г заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулж, энэ хуулийн 115.2-г заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“120.3.Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	16
Бүгд:	39

59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 134 дүгээр зүйлийн 134.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	16
Бүгд:	39

59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “хуралдаанд оруулж” гэсний дараа “, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын

саналаар” гэж, 121 дүгээр зүйлийн 121.6 дахь хэсгийн “121.1-д” гэсний өмнө “энэ хуулийн” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “дуусахаас” гэснийг “хаахаас” гэж өөрчлөх, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “9.16-д” гэснийг “9.15-д” гэж, 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсгийн “буюу” гэснийг “, эсхүл” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “хоног” гэснийг “өдөр” гэж, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “53.1-д” гэснийг “52.1-д” гэж, 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсгийн “50.2-т” гэснийг “52.2-т” гэж, мөн зүйлийн 53.6 дахь хэсгийн “38, 39, 40, 41, 42, 43 дугаар” гэснийг “39, 40, 41, 42, 43, 44 дүгээр” гэж, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн “27 дугаар” гэснийг “28 дугаар” гэж, 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсгийн “90.2-т” гэснийг “95.2-т” гэж, мөн зүйлийн 95.9 дэх хэсгийн “95.7-д” гэснийг “95.8-д” гэж, 98 дугаар зүйлийн 98.4 дэх хэсгийн “86, 87” гэснийг “85, 86” гэж, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийн “26 дугаар” гэснийг “24 дүгээр” гэж, 117 дугаар зүйлийн 117.9 дэх хэсгийн “120.6-д” гэснийг “117.6-д” гэж, 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсгийн “126.6-д” гэснийг “129.1-д” гэж, 123 дугаар зүйлийн 123.3 дахь хэсгийн “127.5-д” гэснийг “126.5-д” гэж, 127 дугаар зүйлийн 127.2 дахь хэсгийн “7 дугаар” гэснийг “17 дугаар” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “багтаан” гэснийг, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийн “, эцэслэн” гэснийг тус тус хасах гэсэн найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39

56.4 хувийн саналаар найруулгын санал дэмжигдлээ.

2.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Л.Мөнхбаатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.18 дахь хэсэг нэмэх:

“9.18.Улсын Их Хурлын гишүүн тойрогт ажиллаж иргэдийн гаргасан санал, хүсэлт, гомдлын талаар 4 минутаар 2-оос дээшгүй удаа нэгдсэн хуралдаанд үг хэлж болох ба Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэлээ бичиж ирүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	23
Бүгд:	39

41.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 20
Бүгд: 39
48.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Хоёр.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 41.4 дэх хэсгийн “шаардлагатай гэж үзвэл” гэсний дараа “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу” гэж нэмж, 4.6 дахь хэсгийн “багтаан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Нэг.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “байгуулалтын” гэсний дараа “болон энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтын “жил бүр” гэсний дараа “, төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг 2 жил тутам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг үг хэлэв.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	16
Бүгд:	39

59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн ард 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.18 дахь заалт нэмэх:

“15.1.18.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг жил бүр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	14
Бүгд:	39

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4, 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.3.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурлын хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор мэдээллийн нэгдсэн сан болон Улсын Их Хурлын цахим хуудаст нийтэлж, байршуулна.

15.4.Энэ хуулийн 15.1-д заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.

15.5.Байнгын хороо энэ хуулийн 15.1-д заасан тайлан, илтгэл, мэдээллийг энэ хуулийн 15.4-т заасан дүн шинжилгээ яаманд хэлэлцэн, шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн төсөл боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	14
Бүгд:	39

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “7-31” гэснийг “7-15” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.3 дахь хэсэг нэмж, 33.3, 33.4, 33.5, 33.6, 33.7 дахь хэсгийн дугаарыг 33.4, 33.5, 33.6, 33.7, 33.8 гэж өөрчлөх:

“33.3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргээ хавсран гүйцэтгэж байгаа гишүүн түр хорооны бүрэлдэхүүнд ажиллахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийг “Тайлбар” болгон доор дурдсанаар өөрчилж, 38.9, 38.10, 38.11, 38.12, 38.13, 38.14 дэх хэсгийн дугаарыг 38.8, 38.9, 38.10, 38.11, 38.12, 38.13 гэж өөрчлөх:

“**Тайлбар:** Энэ хэсэгт заасан “хүндэтгэн үзэх шалтгаан” гэдэгт хорио цээрийн дэглэм тогтоогдсон, гамшиг тохиолдсон, албан томилолттой байгаа, эрүүл мэндийн шалтгаантай, мэдэгдэх хуудас хүргүүлэхээс өмнө гадаад улсад байгаа зэрэг хувь хүнээс өөрөөс нь үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.12 дахь хэсгийн “холбогдох төрийн байгууллага” гэснийг “төрийн болон нутгийн захиргааны холбогдох байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “Хувь хүн нь” гэснийг “Шинжээч, хянан шалгагчийг сонгож авах,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “төсвийн хяналт, шинжилгээний” гэсний өмнө “Тамгын газрын” гэж, төслийн 35 дугаар зүйлийн 35.7.5 дахь заалтыг “даргалах” гэсний дараа “, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах” гэж, төслийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “хадгалах” гэсний дараа “, сонгох” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн” гэснийг “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, /цаашид “хууль, тогтоомж” гэх/-ийн” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 12.6, 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн” гэснийг “хууль тогтоомжийн” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “бодлогын баримт бичгийн” гэснийг “бодлого, төлөвлөлтийн” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “Асуудал хариуцсан” гэснийг “Холбогдох” гэж, мөн хэсгийн “танилцуулж болно.” гэснийг “танилцуулна.” гэж, төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “энэ хуулийн 54.1-д” гэснийг “энэ хуулийн 48.1-д” гэж, төслийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “хэвлэл мэдээллийг” гэснийг “хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг” гэж, төслийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “хэн бүхэн” гэснийг “оролцогч” гэж, төслийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “санал, дүгнэлтийг” гэснийг “санал, дүгнэлт, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төслийг” гэж, төслийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн “, Зөрчлийн тухай, эсхүл бусад хуульд заасан хариуцлага оногдуулна.” гэснийг “болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага оногдуулна.” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.12 дахь хэсгийн “Байнгын хорооноос байгуулах” гэснийг, төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “заавал” гэснийг, төслийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн “хөөж” гэснийг тус тус хасах гэсэн найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	15
Бүгд:	39

61.5 хувийн саналаар найруулгын санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Отгончимэг, А.Отгонцэцэг, Б.Ундрах, Шүүхийн сахилгын хорооны гишүүн О.Номуулин, Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний танхимын тэргүүн

Г.Алтанчимэг, Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны дарга Л.Санжрагчаа, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

“Монгол Улсын Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Байнгын хорооны дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Сүхбаатар, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ц.Сандаг-Очир, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Н.Отгончимэг, А.Отгонцэцэг, Б.Ундрах нар хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар М.Давааогтох, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Л.Сүх-Очир, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн М.Ганбагана нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Д.Тогтохсүрэн, М.Оюунчимэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Д.Ганбат нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар М.Даваатогтох, Д.Дуламсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	19
Татгалзсан:	19
Бүгд:	38

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	18
Бүгд:	39

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	18
Бүгд:	39

52.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Найм. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	17
Бүгд:	38

55.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга Э.Тэмүүжин, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны хуульч Б.Өлзийбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, хуулийн төслийн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Тогтохсүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нэг.ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасаж, 3 дугаар зүйлийн дугаарыг 2 гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 18
Бүгд: 37
51.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нэг.НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасаж, 3 дугаар зүйлийн дугаарыг 2 гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 17
Бүгд: 37
54.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 18
Бүгд: 37
51.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 12 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 43 минут үргэлжилж, 72 гишүүнээс 44 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 33 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүдийн амрыг эрье.

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

Өнөөдөр 18 асуудал хэлэлцэнэ.

Нэг. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Засгийн газар өргөн мэдүүлсэн. Соёрхон батална.

Хоёр. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газар өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Гурав. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Лхагвын Мөнхбаатар, Ганзоригийн Тэмүүлэн нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг явагдана. Зарчмын зөрүүтэй 24 саналтай.

Дөрөв. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Анхны хэлэлцүүлэг хийгдэнэ. Зарчмын зөрүүтэй 25 санал хураагдана.

Тав. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Анхны хэлэлцүүлэг хийгдэнэ. Зарчмын зөрүүтэй 12 саналтай.

Зургаа. Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ.

Долоо. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газрын өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг нь хийнэ.

Найм. “Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газрын өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Ес. Биеийн тамир спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газар өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг хийнэ.

Арав. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Анхны хэлэлцүүлэг хийнэ. Зарчмын зөрүүтэй 48 саналтай.

Арван нэг. Гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл.

Засгийн газар өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг хийнэ. Зарчмын зөрүүтэй 1 саналтай.

Арван хоёр. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл.

Засгийн газрын өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Арван гурав. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Арван дөрөв. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл хэлэлцэнэ.

Арван тав. “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх

23 дахь илтгэл, 2023 оны эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Арван зургаа. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”.

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн нарын 7 гишүүн өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Арван долоо. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Арван найм. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газрын өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Эдгээр 18 асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Ганибалын Амартүвшин нараас албан бичгүүд ирсэн байна. Эдгээрийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга
Гомбожавын Занданшатар Танаа,

Миний бие 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн чуулганы хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно уу.

Улсын Их Хурлын гишүүн
Бөхчулууны Пүрэвдорж гэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын дарга
Гомбожавын Занданшатар Танаа,

Хүсэлт хүргүүлэх тухай.

Миний бие Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн чуулганы хуралдаанд асуудал нэмэх үг хэлэх тул зөвшөөрөл олгоно уу.

Улсын Их Хурлын гишүүн
Ганибалын Амартүвшин гэсэн байна.

Эдгээр хүсэлтийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлье.

Б.Пүрэвдорж: (16-дугаар тойрог, Ховд аймаг)

Монгол Улс 2019 онд уул уурхайн бүтээгдэхүүнийг дотооддоо нэмүү өртөг бий болгодог нийтдээ 92 үйлдвэртэй байсан.

Үүнээс өнөөдрийн байдлаар энэ давхардуулсан АМНАТ_[ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр] авдаг энэ хуулийг 2019 онд баталснаас хойш өнөөдөр тэдгээр үйлдвэрээс 50 нь л үлдсэн байна.

Тэгээд тэд нар нь маш алдаг оног ажиллаж байгаа.

Уг нь эдгээр компаниуд 2019 оноос хойш жилдээ 60 орчим тэрбум төгрөгийн татвар хураамж орон нутгийн болон улсын төсөвт төлдөг.

Ийм үйлдвэрүүд 1500 гаруй хүмүүс ажилладаг байсан. Гэвч энэ хугацаанд давхардуулсан АМНАТ авснаас хойш 50 тэрбум төгрөгийн өртэй болсон байна. 40 гаруй компани зогссон байна.

Эдгээр компаниуд АМНАТ-аас гадна нийтдээ 10 гаруй төрлийн татвар хураамж төлдөг байсан бол тэр бүгдээрээ зогссон байгаа.

Жишээ нь, Дарханы Б.Азжаргал Засаг дарга энэ хэдэн баяжуулах үйлдвэр, угаах үйлдвэрүүд байсан.

Тэд нар энэ орон нутгийн төсөвт маш их мөнгө хийдэг байсан. Одоо бүр огт байхгүй боллоо гээд ярьж байсныг бид бүхэн харж байгаа.

Тэгээд дээрээс нь одоо ингээд ороход бэлэн болчихсон 20 гаруй үйлдвэр энэ АМНАТ-ыг давхардуулж авахыг болиулах бидний өргөн барьсан хуулийг хүлээгээд байж байна.

Хэрвээ энэ хууль батлагдлаа л бол ашиглалтад ороход бэлэн. Түрүүчийн зогссон 20 гаруй үйлдвэр, дахиад шинээр ашиглалтад орох 20 гаруй үйлдвэр ингээд ажиллахад бэлэн байж байна.

Тэгэхээр ер нь эдгээр компаниуд өндөр агууламжтай төмрийн хүдэр ч юм уу, жонш ч юм уу, нүүрс ч юм уу тэрийг өндөр агууламжтай бол компаниуд нь шууд экспортолчихож байгаа.

Гэтэл бага агууламжтай уул уурхайн бүтээгдэхүүнийг угаагаад, баяжуулаад гаргах юм бол илүү нэмүү өртөг бий болж, илүү ажлын байрыг бий болгох боломжтой юм л даа.

Одоо жишээ нь, Чойр, Сайншанд дээр маш бага агууламжтай нүүрс зүгээр наранд түлэгдээд л байж байна шүү дээ. Эдгээр нүүрсийг чинь яадаг вэ гэхээр угаагаад баяжуулаад л гаргадаг л ийм үйлдвэрүүд байсан. Гэвч харамсалтай нь энэ хуулиас болоод гацаад байгаа.

Тэгэхээр энэ хуулийн хүрээнд яаж байна вэ гэхээр бид зөвхөн Эрээнд байдаг жоншны 2 үйлдвэр, хүдрийн 5 үйлдвэр, Баяннуурт байдаг 10 нүүрсний баяжуулах, угаах үйлдвэрт л бүх бүтээгдэхүүнээ борлуулдаг түүхий эдийн экспортлогч орон болж хувираад байгаа юм.

Тэгэхээр бид дотооддоо нүүрсийг жишээ нь, угаагаад хагас коксжуулаад л гаргамаар байна. Хүдрийг баяжмал болгоод, хорголжин болгоод, ширэм болгоод гаргамаар байна.

Жоншоор манай Монгол дэлхийд 4-т ордог. Жоншийг 600 мянган тонныг бид экспортолж байгаа юм. Тэндээсээ 20 сая доллар жилдээ олдог.

Гэтэл энэ 600 мянган тонныг хилийн цаахан гаргаад баяжуулаад 120 сая доллар болгож байна. 120 сая доллар болгож байна.

Түүнийг нь цаашаа аваачаад Шиньжэнд кальцийн фтор болгоод 1.2 тэрбум доллар болгож байна шүү дээ.

Одоо жишээ нь хоёрхон шат дээр л ийм сайхан баялгийг бүтээж байна.

Тэгэхээр бид ийм боломжийг хааж, зөвхөн түүхий эдийн экспортлогч орон байна гэдэг бол үнэхээр муу зүйл.

Ер нь компани, аж ахуйн нэгжүүд, дэлхийн худалдаа ч гэсэн нэлээн сайн төрөлжсөн. Хаа сайгүй түүхий эдээ борлуулах боломжтой болсон энэ тохиолдолд дотооддоо баяжуулаад, цаашдаа бүтээгдэхүүн хийгээд гаргах тэр шат дарааллын энэ АМНАТ гацааж хойш нь татаж байна.

Тийм учраас энэ АМНАТ-ыг давхардуулж татвар авдгийг болиулах энэ хуулийн төслийг Т.Энхтүвшин гишүүн бид хоёр өргөн барьсан.

Гэвч харамсалтай нь өнгөрсөн долоо хоногийн Эдийн засгийн байнгын хороо Банкны хууль дээрх асуудлаасаа болоод хуралдсангүй.

Тийм учраас энэ хууль нь татварын асуудал яригдаж байгаа учраас ирэх долоо хоногийн Эдийн засгийн байнгын хорооноос болиулаад Төсвийн байнгын хороогоор шийдвэрлэх ажлыг зохион байгуулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Одоо Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин үг хэлье.

Г.Амартүвшин: (17-р тойрог, Хан-Уул дүүрэг)

Баярлалаа.

Монгол Улсын иргэн болгон цалингийн зээлтэй. Зээлгүй аж ахуйн нэгж гэж байхгүй болсон.

Өөрөөр хэлбэл бид банкны салбараас 100 хувь хамааралтай болсон.

2021 онд бид энэ банкны монополийг задлах гэж Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталж байсан.

Тэр хуулиар нэгдүгээрт, банкнуудын хувьцааг олон нийтэд гаргах.

Хоёрдугаарт, эзэмшлийг нь задлах. 20 хувиас илүү эзэмшихгүй байх тийм гол гол заалтуудыг бид баталж байсан.

Гэтэл өнөөдөр тэр 20 хувийн асуудал гацаастай хэвээрээ байна.

01 сарын 01-нээс хойш энэ асуудлыг ерөөсөө хэлэлцэхгүй. Яагаад. Яагаад үүнийг бид хэлэлцэхгүй байна аа?

Энэ дээр маш их том лобби явж байна шүү.

2021 оны тэр хуулиас хойш ерөөсөө л намайг энэ хэвлэл мэдээллээр харлуулах үйл ажиллагаа бүтэн явсан. Бүр би тэр асуудлынхаа дагуу шалгууль гээд бүр шүүхээр хүртэл явсан.

Одоо энэ асуудлыг бид нэг тийшээ болгох хэрэгтэй байна.

Өнөөдөр нэг дундаж бизнес байгаа бүх барьцаагаа банканд тавиад жилийн 20 хувийн хүү төлдөг.

Гэтэл банкнуудын эх үүсвэрийн өртөг нь ерөөсөө бодлогын хүүгээс хэтрэхгүй байгаа. 11 хувьтай.

Өөрөөр хэлбэл бараг 9 юм уу, 10 хувийн ийм хүүгийн зөрүүн дээр банкууд амьдарч байгаа байхгүй юу.

1 их наядын цэвэр ашиг хийсэн. Би 2020 онд Их Хуралд дэвшээд гарч ирж

байхад банкны хүү, зээлийн хүүг бууруулна гэж гарч байсан.

Одоо би энэ ажлаа дуустал хийнэ. Энэ ажлаа бид хийхийн тулд энэ Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хянах хэрэгтэй байна.

Тийм болохоор би өчигдөр Их Хурлын даргад албан тоот өгсөн.

Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хянах ажлын хэсэг байгуулья.

Ажлын хэсэгт миний бие ахлаад Т.Энхтүвшин гишүүн, Х.Ганхуяг гишүүн, Ч.Ундрам гишүүн, Т.Доржханд гишүүн.

Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулаад Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хянаад Монголбанкныханд хариуцлага тооцох хэрэгтэй.

Монголбанк чинь арилжааны банкнуудыг хянаж байх хэрэгтэй. Зохицуулдаг байгууллага нь.

Яагаад энэ банкуудын удирдлагууд нь Банкны тухай хуулиа хэрэгжүүлэхгүй, хуулиа зөрчөөд явж байхад нь хариуцлага тооцдоггүй юм бэ? Хуульд нь бүх хэрэгслүүд нь маш тод бид оруулж өгсөн шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлыг нэг талдаа гарга.

Банкнуудыг асуудлыг бид сонгуулийн өмнө нэг тийшээ болгох шаардлагатай байна.

Тийм болохоор миний өгсөн хүсэлтийг Их Хурлын дарга шийдэж өгнө үү. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гишүүд үг хэллээ.

Бөхчулууний Пүрэвдорж гишүүний ярьсан асуудлын хувьд Бөхчулууны Пүрэвдорж, Т.Энхтүвшин гишүүн нар 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан өргөн барьсан байгаа.

Уг асуудлыг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх эсэхийг нь эхэлж шийдэж байж чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулна.

Тийм учраас маргаашийн даргын зөвлөл дээр энэ асуудлыг Эдийн засгийн байнгын хороогоор орох уу, Төсвийн

байнгын хороо руу орох уу гэдгээ эцэслэн шийдээд хариуг нь өгье.

Г.Амартүвшин гишүүний хувьд энэ Банкны хуульд оруулах өөрчлөлтийн асуудал байгаа.

Энэ асуудал дээр ажлын хэсэг байгуулах талаар хүсэлтээ өгсөн байгаа юм байна.

Тэгэхээр тодорхой ажлын хэсэг гараад уг хуулийн хэрэгжилтийг хянах, шалгах ийм ажлын хэсэг гарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн,
соёрхон батлах/

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Монгол Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг 2024 оны 04 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

2019 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар батлагдаж, эхний 20 орон нэгдэн орсноор 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хүчин төгөлдөр болсон Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дээд боловсролын салбарыг хамарсан анхны дэлхий дахины дэлхийн хэмжээний гэрээ юм.

2024 оны 03 сарын байдлаар Япон, Франц, Норвег, Швед, Их Британи зэрэг дэлхийн 28 улс энэхүү гэрээнд нэгдэн ороод байна.

Энэхүү конвенцод нэгдэн орсноор улс орнуудын их, дээд сургуулиудын боловсрол, сургалтын үр дүн зэрэг цолыг ил тод шударгаар хүлээн зөвшөөрөх, суралцагчдад бусад орны их дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэх зайн хэлбэрээр суралцаж эзэмшсэн мэргэжлээ хүлээн зөвшөөрүүлэх боломжийг олгодог.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий танхимын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс дэлхийн улс орнуудтай дээд боловсролын салбарт хамтран ажиллах бүс нутаг хоорондын инновацыг дэмжих, дээд боловсролын салбар дахь олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монголын дээд боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрөгдөхөд хувь нэмрээ оруулахаас гадна дээд боловсролын салбарт чанарын баталгаажуулалтын тогтолцоо, соёлыг төлөвшүүлж, чанарын баталгаажуулалтын найдвартай байдал, уялдаа холбоо, чадавхыг бэхжүүлэх боломж бүрдэнэ.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар шинэчлэгдэн батлагдсан Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг баталгаажуулах, бүртгэх, олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд боловсролын зэрэг, баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх, судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байх чиг үүргийг боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага хариуцан ажиллана.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхийг дэмжиж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Л.Энх-Амгалан сайдад баярлалаа.

Одоо хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцын соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцод нэгдэн орсон улсууд харилцан бие биеийнхээ боловсролын үнэлгээг хэрхэн хүлээн зөвшөөрөх, харилцан ямар туслалцаа, дэмжлэг үзүүлэх, энэ талаарх тодорхой туршлага, бодит жишээ байгаа эсэхийг асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан тухайн конвенцод нэгдэн орсноор дэлхийн улс орнуудын дээд боловсролд хамаарах эрдмийн зэрэг, хэсэгчилсэн сургалтыг халиан харилцан хүлээн зөвшөөрч байгаагаас гадна дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийн хамрагдсан хэсэгчилсэн сургалт ба эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөхөөр заасан дүрвэгсдийг хүлээн авахыг зөвшөөрдөггүй манай улсад нөлөө үзүүлэх эсэх талаар анхаарах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн болно.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж эцэслэн батлуулахыг дэмжье гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Б.Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг оруулсан уу? Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг маргааш өглөө буюу Баасан гарагийн 10.00 цагт явуулна.

Дараагийнхаа асуудалд орёе. **10:53**

Хоёр.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Монгол Улсын Их Хурлын дэд дарга,

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн 2-т Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, Улсын Их Хуралд өргөж, гаргасан шийдвэрийг биелүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох. **“Алсын хараа-2050”** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний зорилгод олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлэх, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа, хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчныг бүрдүүлэхээр заасан билээ.

Монгол Улсын Их Хурлаас анх 1998 онд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг 2006 онд хуулийн шинэчилсэн найруулгыг батлан мөрдүүлж, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны эрх зүйн харилцааг зохицуулж ирсэн хэдий ч өнөөдрийн эрчимтэй хувьсан өөрчлөгдөж байгаа шинжлэх ухаан, технологийн хөгжил, бодлого, чиглэл, түүний үйл ажиллагааны удирдлага, менежмент, хатуу болон зөөлөн дэд бүтэц, хүний хүний нөөцийг удирдахад энэхүү хуулийн хүрээн дэх эрх зүйн зохицуулалт, хэм хэмжээний заалт бүрэн хамарч чадахгүйд хүрсэн байна.

Энэ хугацаанд хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой олон тооны бодлого, эрх зүйн баримт бичгийг Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас батлан хэрэгжүүлсэн боловчиг хөрөнгө санхүү, хүний нөөцийн хомсдолд салбарын удирдлага, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо оновчгүй байгаа.

Шинжлэх ухаан, технологийг зөвхөн нэг салбарын асуудал мэтээр зохицуулж ирсэн нь тус салбарын үр дүн нийгэм, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хязгаарласан хөгжлийн урт, дунд хугацааны баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, зорилт үр дүндээ хүрэхгүй байх гол шалтгаан гэж дүгнэж байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалт, Монгол Улсын Их Хурлаас баталсан дунд, урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан дээр дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн дагуу Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Анхдагч хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төсөл болон дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хамт боловсруулж, Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороогоор хэлэлцүүлэн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим уг үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хувийн

хэвшлийн оролцоо, төрийн дэмжлэг, хүний нөөцийн хөгжил, санхүүжилт, хөрөнгө оруулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан шинжлэх ухаан, технологийн бодлого урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт шинжлэх ухаан, технологийн инновацыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх хууль эрх зүй бүрдэхийн зэрэгцээ шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогчдын эрх үүргийн хуваарилалтыг оновчтой тогтоож, удирдлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хувьд олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх замаар шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тогтолцоог системтэйгээр бүрдүүлж, нийгэм, эдийн засаг, хүний амьдралын чанарын үзүүлэлт дээшилж дэвшил гарна гэж үзэж байна.

Үүний зэрэгцээ шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн түншлэл нэмэгдэж, салбар дундын болон салбар дамнасан хамтын ажиллагаа өргөжиж, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоо оновчтой, олон эх үүсвэртэй болж, ил тод байдал хангагдаж, санхүүжилт болон үр дүнг уялдуулан хяналтыг сайжруулах боломж бүрдэнэ.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Инновацын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хүчингүй болсонд тооцох тухай хуулийн

төсөл, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Л.Энх-Амгалан сайдад баярлалаа.

Төслийн талаарх Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: (24-р тойрог, Сүхбаатар дүүрэг)

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Шинжлэх ухаан, технологийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хувийн хэвшлийн оролцоо, төрийн дэмжлэг, хүний нөөцийн хөгжил, санхүүжилт, хөрөнгө

оруулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон асуудлуудыг тусгажээ.

Хуулийн төсөл батлагдсанаар шинжлэх ухаан, технологийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ гэж хууль санаачлагч үзжээ.

Хууль санаачлагч улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж үзсэн бөгөөд хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед

- Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Шинжлэх ухаан, технологийн сангийн бүрэлдэхүүнийг хэрхэн бүрдүүлэх, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн даргын томилгооны талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Шинжлэх ухаан, технологийн сангийн хүний нөөцийн талаар боловсролын багц хуультай хэрхэн уялдуулсан талаар, их сургууль болон шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн хоорондын холбоог хэрхэн тусгасан талаар, салбарын ажилчдын цалин, нийгмийн баталгааны талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан хууль батлагдсанаар улсын төсөв хэрхэн нэмэгдэх талаар, хөдөө орон нутгийн төрөлжсөн ахлах сургууль байгуулагдах эсэх талаар, Шинжлэх ухаан, технологийн

сангийн үйл ажиллагаа одоогийн байдлаар ямар түвшинд байгаа, цаашид хэрхэн үр дүнтэй ажиллах талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Шинжлэх ухаан, технологийн үндэсний хороо хөтөлбөртөө эрдэм шинжилгээний ажилчдын ёс зүйн асуудлыг тусгах талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир цаг уур, байгалийн онцгой нөхцөл байдлаас үүссэн хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын асуудал хувьсан өөрчлөгдөж байгаатай холбогдуулж тус салбарын эрдэм шинжилгээний хүрээлэн оновчтой зөвлөгөө өгч ажиллахгүй байгаа талаар асуулт асууж санал хэллээ.

Шинжлэх ухаан, технологийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд

боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай өөрчлөлт оруулах тухай, Тогтоолын хавсралд нэмэлт оруулах тухай, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ц.Мөнхцэцэг даргад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны Төрийн нарийн бичгийн дарга Ханджавын Батжаргал, Боловсрол, шинжлэх ухааны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Доржготовын Баттогтох, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Дүгэрийн Рэгдэл, Боловсрол, шинжлэх ухааны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Цэен-Ойдовын Намчинсүрэн, Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Сономдаржаагийн Мөнхбат, Шинжлэх ухаан, технологийн сангийн

захирал Доржгочоогийн Одгэрэл нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Н.Ганибал.

Л.Энх-Амгалан сайд өөрөөсөө асуух юм уу?

Асуулт асуух зүйл шүү дээ. Л.Энх-Амгалан сайд аа.

Б.Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асуултаа асууя.

М.Оюунчимэг: (25-р тойрог, Чингэлтэй дүүрэг)

Улс орны хөгжилд хамгийн чухал хууль маань ингээд хаврын чуулганы бөгсөн дээр жоохон яаравчлан орж ирж байгаад жоохон харамсаж байна.

Гэхдээ орж ирж байгаа нь сайн юм даа.

Энэ бол үнэхээр цаг алдалгүй гарах ёстой хууль. Уг нь би боловсролын багц хуулийн дараа шууд энэ хууль орж ирнэ гэсэн итгэлтэй байсан. Салбарын сайд ч гэсэн бас энэ хууль дээр ажиллаж байна гэсэн.

Яагаад гэвэл өнөөдөр манай улсад бүх юм яагаад асуудал тулгараад байна гэхээр аливаа юманд шинжлэх ухаанчаар, судалгаатайгаар хандахгүйгээс болоод бүх юм араасаа асуудал дагуулж байна.

Өнөөдөр бүгдээрээ ярьж байна шүү дээ. Нийслэл Улаанбаатар хот дээр л гээд

ярихад энэ түгжрэл, энэ утаа, хөрсний бохирдол гээд л ярихад эрдэмтэн, судлаачдын судалгаа уг нь гарсан.

Гэвч тэр нь үр дүнд хүрдэггүй. Тэр нь дуу хоолой нь болж ашиглагддаггүй. Үүний үр дүн ямар гарч байгааг бид өнөөдөр ингээд хараад байгаа л даа.

Үнэхээр харамсалтай нь одоо жишээ нь 2024 оны төсөв хэлэлцэх үед бид бас энэ КОВИД-ын үед Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын канцлер “Бид эрдэмтэддээ итгэдэг. Үүний хүчинд бид үүнийг амжилттай даван туулж байна” гээд ярьж байсан.

Гэтэл бид эрдэмтдээ ямар судалгаа яаж хийж байгаа юм, байр сав, төсөв хөрөнгө гээд дан асуудалтай.

Одоо л гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний 0.11-хэн хувийг эзэлж байна гэж байгаа байхгүй юу.

Би тэгээд Л.Энх-Амгалан сайдаас одоо энэ хуулийг хэрэгжүүлж эхлэхэд сая хэлж байна л даа. Санхүүжилт энэ тэрийг дотроосоо зохицуулах бололцоотой гээд.

Энэ том салбарыг үр дүнтэй, үндэслэл судалгаатай, бусад улс орон хиймэл оюун ухаан ярьж байгаа энэ үед бид шинжлэх ухаан, технологийн салбараа эрс хөгжүүлэхэд хөрөнгө мөнгө одоохондоо шаардахгүйгээр зохицуулалт хийчих гэж ярих нь буруу болов уу гэж бодож байгаа.

Мэдээж төсөвлөсөн байх. Салбарын сайд болон салбарын яамныхан энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөхийг хүсэж байна.

Одоо бид нэг зүйлийг харж байгаа байхгүй юу.

- Хүнсний лаборатори,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн лаборатори,
- Мал эмнэлгийн лаборатори

гээд лабораториуд нь бүгд тусдаа болчихсон.

Энэ лабораториуд хамгийн хоцрогдсон. Бараг XIX, XX зууны тоног төхөөрөмжтэйгөө.

Тэгээд энэ тоног төхөөрөмжийг шинэчлэх, хөрөнгө мөнгийг нь улсын төсөвт жил болгон суулгая гээд л ярьдаг. Суулгаж байтал ямар нэгэн шалтгаанаар хасагдчихдаг. Эсвэл сайдын багцаас нь хасагдчихна. Эсвэл нөгөө төрийн хэмнэлтийн хууль ч гэдэг юм уу. Ямар нэгэн зүйлээс болоод хүний нөөцөд сургах болоод энэ технологийн дэвшил, технологио шинэчлэх зүйл яг энэ шинжлэх ухааны салбар дээр манайх хоцрогдчихоод байгаа юм.

Түүнээс биш бие биетэйгээ үл нийцэх, зохицохгүй янз янзын тоног төхөөрөмжүүд янз янзын улс орнуудаас авчирчихдаг. Тэр нь тэгээд бие биетэйгээ уусаж хүртэл чадахгүй байгаа тухай. Одоо жишээ нь, эрүүл мэндийн салбар, манай энэ хүнсний аюулгүй байдлын лабораторийн салбарынхан хэлж байсан л даа.

Хамгийн сүүлийн жишээ одоо энэ эм, эмнэлгийн хэрэгслийн лаборатори гэхэд 5 тэрбумаа суулгаж чадахгүй. Харин С.Чинзориг сайд овоо энэ дээр анхаарал хандуулж, одоо тэр Дэлхийн банктай хамтраад энэ лабораторийг шинэчлэх ажил хийх гэж байгаа юм билээ.

Багаж хэрэгсэлгүй нүцгэн гартай эрдэмтэд маань юу ч хийх билээ дээ. Тийм ээ.

Тийм учраас бид эхний ээлжид “саалиа бэлдэхэд саваа бэлд” гэдэг шиг энэ дэд бүтэц, тоног төхөөрөмж энэ тэрээ шинжлэх ухааны яг бусад улс орон хөгжиж байгаа түвшинд, ялангуяа хүний эрүүл мэнд, хүний аюулгүй байдал, хүнсний асуудал дээр шийдэхгүй бол одоо яг үнэнийг хэлэхэд хавдрын өвчлөлөөр, бид одоо ходоодны хорт хавдар болон бусад халдварт өвчнөөр Монгол Улс дэлхийд толгой цохиж эхэлж байна шүү дээ.

Энэ юу юм гэхээр бид хөрсний бохирдлыг сүүлийн хэдэн жил ярилаа.

Энэ чинь үнэхээр харанга дэгдэх түвшинд хүрчихсэн байна шүү. Малчдын хэрэглэж байгаа савыг өөрчилье, нийслэл Улаанбаатар хотод ус зөөж байгаа савыг өөрчилье. Үүнийг шинжлэх ухаанчаар хандъя. Энд үйлдвэр байгуулъя гээд л яриад байдаг.

Тэгээд л төсөв хэлэлцэх үед эд нар нь хасагдчихдаг. Эсвэл тухайн салбар дээр энэ нь өөрөө явж өгдөггүй.

Тийм учраас яг энэ дээр хуулийн заалтуудыг өчигдөр уншиж судаллаа. Яг энэ чиглэл дээр ялангуяа тоног төхөөрөмжийг цогц багцаар нь, бие биетэйгээ уусах, зохицох тал дээр нь яаж төсөвлөж орж ирж байгаа вэ? Хэдэн оноос хэдийг суулгах юм? Тэр нь яаж хэрэгжих юм? Хэдэн лаборатори байх юм гэдэг энэ төлөвлөгөөний талаар би товч мэдээлэл авахыг хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

М.Оюунчимэг гишүүнтэй санал нэг байна.

Тэгээд яах вэ, өнгөрсөн хугацаанд бид нарын гаргасан бодлогын алдаа, сургамж дээрээ л дүгнэж бид ирээдүйнхээ бодлогыг төлөвлөх ёстой л доо.

Үндсэн хуульд бүр цагаан дээр хараар Үндсэн хуулийн 38.2-т нэг ийм заалт байгаа юм билээ. М.Оюунчимэг гишүүн ээ.

Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого батлагдаж байж дараа нь улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл батлагдана.

Тэгээд нийгмийн үндсэн чиглэл дээр үндэслэж тухайн жилийн улсын төсвөө баталж, Улсын Их Хуралд оруулж энэ шийдвэрүүдийг хэрэгжүүлэх энэ үүргийг Монгол Улсын Засгийн газарт олгосон ийм Үндсэн хуулийн заалттай улс байхгүй юу. Бид нар.

Гэтэл харамсалтай нь үе үеийн Засгийн газар ерөөсөө Үндсэн хуулийнхаа энэ заалтыг биелүүлээгүй л юм билээ.

Шинжлэх ухаан, технологийнхоо нэгдсэн бодлогыг ерөөсөө бид баталсан тохиолдол байхгүй.

Тэгээд шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого байхгүй болохоор нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл нь шинжлэх ухаангүйгээр батлагддаг. Улсын төсөв нь өөрөө шинжлэх ухаанд зарж байгаа, шаардлагатай байгаа санхүүжилтийнхээ тогтолцоог дэмжсэн улсын төсөв батлуулж чадахгүй явсаар л өнөөдрийг хүрчихсэн юм байна л гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр Үндсэн хуулиа бид хэрэгжүүлж чадаагүй байна. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Ямар санаатай, ямар үндэслэлээр Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “шинжлэх ухааны аюулгүй байдал” гэсэн энэ хэсгийг нь 2012 онд аваад хаячихсан юм билээ. Байхгүй болгочихсон. Тийм ээ.

Тэгээд Үндэсний аюулгүй байдлынхаа зөвлөмж дээр шинжлэх ухааныхаа талаарх бодлогоо аваад хаячихсан. Үндсэн хууль дээр тусгасан энэ заалтаа бид хэрэгжүүлж чадаагүй учраас л яг таны хэлж байгаа шинжлэх ухаанд нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх хэмжээний зардлыг зарна гээд л. Энэ нь лоозон болоод үлдчихсэн байхгүй юу.

Хий дэмий лоозон. Хэзээ ч хэрэгждэггүй.

Харин ч сүүлийн жилүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар, дэмжлэгээр, бодлогоор Ерөнхий сайд байхад нь шинжлэх ухаанд бараг сүүлийн 60 жилд оруулсан хамгийн том хөрөнгө оруулалт буюу “Шинжлэх ухааны нэгдсэн цогцолбор”-ыг 150.0 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр бид барьж байгуулж байна. Барьж байгуулж байна.

Бид энэ намар, ирэх хавар гэхэд Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн цогцолбор буюу Монгол Улсад “шинжлэх ухааны парк” хэлбэрээр ажиллах энэ том бүтээн байгуулалтын ажлуудыг бид хийж дуусгана.

Энэ бол манай шинжлэх ухаанд оруулж байгаа хамгийн томоохон хөрөнгө оруулалтын нэг гэж үзэж болно.

Хоёр дахь асуудал бол таны нөгөө санхүүжилтийн тогтолцооны асуудлыг хөндөж ярьж байх шиг байна.

Өнөөдрийг хүртэл бид ерөнхийдөө шинжлэх ухааныхаа тогтолцооны санхүүжилтийг бүтэн циклээр ер нь санхүүжүүлж ирж байгаагүй ийм л улс. Тийм ээ.

Сүүлийн 10 жилд Шинжлэх ухаан, технологийн санд 180 орчим, 190 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 4500 орчим л судалгаа хийсэн байдаг байхгүй юу.

Нэг судалгаанд ногдож байгаа зардал 20 сая төгрөг гэсэн үг. Тэгээд 20 сая төгрөгөөр бид нар.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гүйцээгээд хариулчихъя. 1 минут.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

20 сая төгрөгөөр хийсэн судалгаанаас бид үр дүн нэхнэ гэдэг бол хэцүү зүйл л дээ.

Тийм учраас шинэ хуулиар оруулж ирж байгаа. Бид энэ

- судалгаа хөгжүүлэлт,
- инновацын хөгжүүлэлт,
- бизнесийн хөгжүүлэлт

гэсэн яг бүтэн циклээр нь санхүүжүүлдэг санхүүжилтийн тогтолцоог л бид санал болгож оруулж ирж байгаа юм.

Цаашаа энэ тогтолцоонд шилжихгүй бол өнөөдөр хүртэл манай мэргэжлийнхний ярьдгаар Монгол Улсад

хийж байгаа судалгаа, шинжилгээ дандаа үхлийн хөндийд орчхоод байдаг нэг ийм л тогтолцоотой болсон байхгүй юу.

Тэгээд үүнийгээ нэгдүгээрт засъя.

Хоёрдугаар асуудал бол та нөгөө лабораторийн асуудлуудыг хөндөж тавих шиг боллоо.

Тэгэхээр Монгол Улс анх удаа ер нь бид нар лабораторийнхоо тооллогыг хийсэн. М.Оюунчимэг гишүүн ээ.

Ингээд нийт Монгол Улсын хэмжээнд 350 орчим лаборатори байдаг юм байна. Байдаг юм байна.

Зарим 5 сая долларын өртөгтэй лабораторийг бид худалдаж авчхаад ямар ч судалгааны эргэлтэд оруулахгүйгээр хадгалагдаж байсан. Тоосонд дардаад өнөөдөр технологи нь хоцрогдчихсон нөхцөл байдлууд байна.

Тийм учраас их сургуулиуд дээр байгаа лабораториуд, шинжлэх ухаан, технологийн хүрээлэнгүүд дээр байгаа лабораториудыг бид дундын лаборатори, нээлттэй лаборатори болгож ашиглах ийм боломж, үндэсний чадавх өнөөдөр байгаа байхгүй юу.

Хамгийн гол нь их дээд сургуулиуд, шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагаанууд энэ чиглэл рүү хандлага, сэтгэлгээгээ жаахан өөрчлөх ийм хэрэгцээ шаардлагууд өнөөдөр үүссэн байна.

Тийм учраас бид нарт нөөц байна. Нөөц байна. Лабораториудынхаа нөөцүүдийг ашиглах. Цаашаа лабораторийн менежментүүдээ шинэ шатанд гаргах юм бол өнөөдөр хүртэл нөгөө “чамлахаар чанга атга” гэдэг шиг өөрсдөө байгаа одоо энэ лабораториуд

дээрээ тодорхой судалгаа, шинжилгээнүүд хийж, үр дүнг нь хүртэх боломж бид нарын өмнө байна л гэж харж байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Тодруулах юм уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: (25-р тойрог, Чингэлтэй дүүрэг)

Сая салбарын сайд өөрөө ч хүлээн зөвшөөрч байна шүү дээ.

Дэлхийн улс орнууд “цахиурын хөндий” ярьж байхад бид “үхлийн хөндий”. Одоо хүртэл шинжлэх ухаан, технологийн маань салбар оршсоор байгаа нь үнэхээр харамсалтай байхгүй юу.

Тийм учраас л бид хөгжихгүй байгаа.

Өнөөдөр хотын дарга ТҮК_[тохижилт, үйлчилгээний компани]-ийн ажилтнууд, нийтийн тээврийн ажилтнуудын цалинг доод тал нь 3 сая ба түүнээс дээш болгоно гэдгээ зоригтой зарлаад, хүүхэд багачуудыг нь сургана гээд ярьж байна шүү дээ.

Яг үүн шиг энэ салбар, эрдэмтдээ цалингийн доод босгыг нь тийм болгоно, яг ийм түвшинд технологио хүргэнэ. Дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь гэдэг чинь бага шүү дээ.

Үүнийгээ л өнөөдрийг хүртэл баталж чадахгүй. Төсөв батлах үед яагаад үүнийг бид ярьж үүнийг нь 2 хувьд нь суухгүй бол та Үндсэн хуулиа зөрчиж байна гээд Үндсэн хууль зөрчсөн салбарыг нь, тэр дэмжихгүй байгаа сайдад арга хэмжээг нь хүртэл аваад явах бүрэн хууль эрх зүйн акт нь байхад одоо хүртэл хэрэгжүүлж ирээгүй байна гэдэг бол өөрөө

ямар ч хяналтын механизм байхгүй байна гэсэн үг л дээ.

Сая Та хэллээ. У.Хүрэлсүх Ерөнхий сайдын үед харин тийм том бүтээн байгуулалтын ажил эхэлсэн гэж байна.

Одоо энэ дээр үнэхээр Үндсэн хуулиа биелүүлэхгүй бол.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Үг хэллээ. Санал хэлчихлээ дээ.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан асуултаа асууя.

Х.Баделхан: (2-р тойрог, Баян-Өлгий аймаг)

Баярлалаа. Хуулийн төслийг дэмжиж байгаа.

Цаг үе олсон хуулийн төсөл орж ирсэн гэж бодож байгаа.

Би Шинжлэх ухааны академиас асуумаар байна л даа. Гурван асуулт асуумаар байна.

Нэгдүгээрт, бүтэц, бүрэлдэхүүний хувьд Шинжлэх ухааны академи гэдэг бол маш том байгууллага.

Ер нь Боловсролын яамны, нэг яамны харьяа байх нь зөв үү?

Ер нь бусад бидний ижил түвшний хөгжлийн улс орнуудад шинжлэх ухааны байгууллага ямар бүтэц, ямар зохион байгуулалттай байдаг юм бол? Ер нь цаашдаа ямар байна? Энэ хуулийн төсөлд ямар өөрчлөлт оруулсан бэ гэсэн нэг асуулт байна.

Хоёр дахь нь, ер нь манай улсад аль ч салбар илүү хөгжиж байгаа вэ? Олон

улсын түвшинд зэрэгцэх хэмжээний түвшинд хүрсэн.

Тэгээд ийм салбарыг бид онцгой анхаармаар байна. Яг манай нөхцөлд. Аль ч салбар илүү хөгжиж байгаа. Тэгээд цаашдаа хөгжих төлөвтэйгээс. Энэ тал дээр ямар бодлого байдаг юм байна гэсэн хоёр дахь асуудал байна.

Гурав дахь нь, тэр “шинжлэх ухааны сан” гэж. Энэ бол төсвөөс зохих хэмжээгээр мөнгө ордог байх. Бас хүрэлцэхгүй л байдаг байх.

Энэ хууль өргөн барьснаар ер нь бүх юм цаашдаа мөнгөөр хөдөлнө шүү дээ. Энэ дээр ямар өөрчлөлт орсон юм бэ гэсэн.

Тэгээд энэ шинжлэх ухааны байгууллага өөр өөрсдөө тийм орлого олох боломж байдаг уу?

Дээр үед социализм үед. Би сайн мэдэж байгаа. Яам, салбар болгон нь өөр өөрсдийн хөгжлийн институттэй байсан шүү дээ. Зургийн товчоотой, институттэй. Салбарын бодлогоо явуулдаг тийм боломжтой байсан.

Одоо бол “**шинжлэх ухаан, технологи**” гэж яриад байгаа. Бид нар. Эндээ техник, технологи хоёрыг салгаж болохгүй л дээ. Техник нь ингээд хаягдсан.

Энэ тал дээр ер нь хуулийн төсөл дээр ямар өөрчлөлт оруулсан бэ гэсэн асуулт байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Х.Баделхан гишүүний асуултад хариулъя. Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч Д.Рэгдэл гуай хариулъя. Хэддүгээр микрофон байна? Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье.

Д.Рэгдэл: Ерөнхийдөө дэлхийн шинжлэх ухааны академиудын хөгжлийн чиг хандлагатай бид аль болохоор л ойр явъя, чиг баримжааг нь алдалгүй явъя гэдэг зорилгын доор л ажилладаг.

Бэрхшээл тоочвол зөндөө юм бий. Тэрийг яриад яах вэ.

Өнөөдөр дэлхийн улс орнуудад 140 орчим шинжлэх ухааны академи байна. 140 орчим улсад.

Үүнээс 80 улсын шинжлэх ухааны академи бүтэц, зохион байгуулалтын хувьд манай Монгол Улсын Шинжлэх ухааны академитай төстэй бүтэц, зохион байгуулалттай. Харьцангуй бие даасан, өөрийн удирдах ёсыг хэрэгжүүлдэг ийм байгууллагын хэлбэрээр ажилладаг.

Дэлхийн шинжлэх ухааны байгууллагуудыг нэгтгэсэн хоёр том холбоонд манайх гишүүнээр явдаг.

Тэр дээр нэмээд ер нь энэ Бүс, замын орнуудын шинжлэх ухааны байгууллагуудыг нэгдсэн холбооны удирдах зөвлөлд ажилладаг.

Тэгэхээр яах вэ, үйл ажиллагааны хувьд бид чиг баримжаагаа алдахгүй явж байгаа.

Болдоггүй юм нь юу вэ гэхээр сая М.Оюунчимэг гишүүн бас ярьж байна.

Ерөнхийдөө санхүүжилт хэт бага. Хэт бага л гэж хэлэхээс өөрөөр хэлэхэд хэцүү ийм байдалтай.

Зүгээр яах вэ, шүүмжлэл байдаг. Монгол Улсын шинжлэх ухааны академи Оросын Холбооны Улсын шинжлэх

ухааны академитай адилхан бүтэц, зохион байгуулалттай явдаг гэдэг.

Тэгэхдээ тэр бол ортой гэж хэлэхэд хэцүү. Яагаад гэвэл Оросын шинжлэх ухааны академи бол угаасаа Францын шинжлэх ухааны академийн бүтэц, зохион байгуулалтаар 1724 онд байгуулагдсан. Францын академи шиг зохион байгуулалттай. Тэр нь манайд ингэж байдаг.

Тэгэхээр 80 оронд явж байгаа учраас бид бүтэц, чиг хандлагыг зөв гэж боддог.

Байгууллагын төсвийн хувьд бид Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад явдаг.

Ер нь манай Шинжлэх ухааны академийн урсгал төсөв 2024 оны байдлаар 42.0 тэрбум төгрөг байна. 75.0 хувь нь цалин, нэмэгдэл цалин энэ тэрд явж байгаа. 25 хувь нь үндсэндээ үйл ажиллагаандаа урсгал зардал болж явдаг.

Байгууллагыг хөгжүүлэх зардал энэ дундаас гаргахад хэцүү. Гэлээ ч гэсэн бид гадаад харилцаагаа ашиглаад одоо энэ Бүс, замын орнуудын хэмжээнд Хятадаас байгуулах 100 лабораторийн анхны лабораторийг Монгол Улсад байгуулчихсан.

Одоо 07 сарын 26-нд албан ёсоор Монголд нээлтээ хийнэ.

Тэгээд сая сайдын ярьдаг Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолборт байрлуулж ажиллуулахаар төлөвлөж байгаа.

Ер нь нийт лабораторийн. Одоо сайдын сая хэлдэг тэр 300 гаруй лабораториудын хувьд академийн

лабораториуд тоног төхөөрөмжийн хувьд үнэхээр ХХ зууны сүүлийн хагасын түвшиндээ 80 хувь нь байна. 20 хувь нь бага багаар шинэчлэгдэж байгаа.

Хүрээлэнгүүд.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Хариулт хангалттай юу? Д.Рэгдэл гуай гүйцээгээд хариулчихъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье. Дараа нь Л.Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

Д.Рэгдэл: Тэгээд орлого олох боломж ерөнхийдөө их байгаа.

Зүгээр одоо бол хуулиар хаалттай байгаад байдаг. Бид нөгөө Тендерийн хуульд түрүүхэн өнгөрсөн оны 6 дугаар сард өөрчлөлт оруулахад нь энэ эрдэм шинжилгээний байгууллагуудаар төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниуд судалгаа, боловсруулалтын ажлаа шууд захиалгаар хийлгэж болох тухай заалт оруулж Та бүхэн маань баталж өгсөн.

Тэгээд энэ заалт маань 6 сар үйлчлээд шинэ нэмэлт, өөрчлөлт орсон хууль батлагдахад хасагдчихсан юм байгаа юм.

Тэгээд энэ хооронд хүрээлэнгүүд, манай төрийн өмчит үйлдвэрийн газрууд хоорондоо хэд хэдэн гэрээ байгуулаад, тэгээд үндсэндээ Шинжлэх ухааны академийн хэмжээнд 2023 онд төсвийн гадуур орох орлого 18 тэрбум төгрөг дээр очиж байгаа юм. Үндсэн улсын төсвийнхөө бараг 50 хувь руу.

Тэгэхээр энэ боломжийг Тендерийн хуулиар нээгээд өгөх юм бол бид улсын төсвөөс гадна өөрийгөө санхүүжүүлж явах төсвөө олох хүний нөөцийн болоод лабораторийн боломж байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийг одоо энэ Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа ийм заалтыг бас нэг тусгах тал дээр манай гишүүд анхаараад өгвөл одоо энэ салбарт маш том дэм болохоор байна. Их баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Хариулт хангалттай юу? Одоо Ж.Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: (25-р тойрог, Чингэлтэй дүүрэг)

Шинжлэх ухаан, технологийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл орж ирж байна л даа.

Тэгээд яах вэ, ер нь үе үеийн олон парламентууд дээр шинжлэх ухаан, технологийн талаар, боловсролын салбартай холбоотой асуудлуудын талаар их ярьдаг.

Улс орны хамгийн гол баялаг хүн. Тэр дотроо хамгийн гол үнэт зүйл нь боловсрол гэж байгаа.

Тэгээд яах вэ, ер нь шинжлэх ухаан, технологийн. Бид одоо нэг л юмыг яаж байгаа. Д.Рэгдэл гуай ч гэсэн өөрөө олон юман дээр тайлбар хийж байсан.

Одоо нэг ийм л юм үүсчхээд байна шүү дээ. Өгөөж. Үр өгөөж.

Бид Монгол Улсын хувьд өнөөдөр тулгамдаад байгаа асуудлуудыг шийдэхэд ямар инновацын тийм шийдлүүд, шинэлэг алхмууд хэрэгтэй юм бэ гэдэг нэг ийм асуудал байгаа. Тулгамдаад байгаа асуудал.

Хоёрдугаарт, Монгол Улсын хөгжлийг хурдасгуур нь яах юм бэ? Энэ дээр яаж хувь нэмрээ оруулах юм бэ?

Сая Канадын Засгийн газар шинжлэх ухаан, технологийнхоо чиглэлээр хөрөнгө оруулалтын хэмжээг үлэмж нэмэгдүүлэхээр тавьж байх жишээтэй.

Ер нь дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын гол үзүүлэлт сүүлийн үед шинжлэх ухаан, технологийнхоо чиглэл дээр, боловсролын салбар дээрээ хөрөнгө оруулалтыг хэн хэрхэн нэмэгдүүлж байна гэдэг асуудал их анхаарал татаж байгаа юм.

Тэгэхээр бид нарын хувьд юу яаж байгаа юм. Одоо ингээд л Засгийн газрын тухайд ярихаар ИТ [Information technology]. Н.Учрал сайд байж байна. Ерөнхий сайд хэлж байна. Эстонийн асуудлыг ярьж байна.

Жижиг улс, газар зүйн хязгаарлагдмал нөхцөлтэй улс орон юмыг давж гарах, олон хана хэрэм, саад бартааг давж гарах юм бол ИТ юм байна. Хиймэл оюун ухаан ярих ёстой юм.

Бид нарт ахадсан гэж бодож болохгүй байгаад байгаа байхгүй юу.

Эстони Улс манай улсаас хүн амаараа бараг хоёр дахин бага хүн амтай. Тэгэхэд одоо ингээд яах вэ Европт байдаг давуу тал байгаа байх.

Гэхдээ бодлого нь энэ дээрээ сууриалаад явчихсан.

Манайд өнөөдөр Улаанбаатар гэхэд утаа, түгжрэл, хөрсний бохирдлын асуудал гээд явж байгаа.

Тэгэхээр сан гэдэг чинь юу юм бэ гэхээр төсөл, хөтөлбөр, тэр **“стратегийн инноваци”** [strategic innovation]¹ гээд байгаа юм.

“Стратегийн инноваци”-ын чиглэлээр сангийн үйл ажиллагааны загвар яах юм? Та хэд маань Оросынхтой арай биш гэж байна.

Тэгвэл Шинжлэх ухаан, технологийн сан чинь. Л.Энх-Амгалан сайд аа.

Бид аль загварыг авч үзэх юм?

Хүчин чадал багатай гээд байдаг. Багатай байвал одоо энэ хууль гарлаа гэхэд хүчин чадлаа сайжруулах ёстой шүү дээ. Потенциалаа сайжруулах ёстой. Мөнгөө нэмэхээс гадна хүний нөөцөө тавьсан уу? Хүн олдохгүй бол гадаадад байгаа зарим монгол хүмүүсээ тусгай өндөр контрактаар авмаар байна шүү дээ.

Тэгээд Монгол Улсын тодорхой тийм төслүүдийг санхүүжүүлмээр байна.

Сая **“Үндэсний баялгийн сан”**-г бид гаргалаа. Түүн дээр **“Хөгжлийн сан”** гэж байгаа.

Энэ хөгжлийн сангууд том төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ийм инновацийнх нь тэр чиглэлд нь ч гэдэг юм уу, **“стратегийн инноваци”** гээд сан гээд зарим нь гаргаад байх шиг байна.

Би нарийн чиглэлийн хүн биш. Гэхдээ нэг тийм олон юм руу биш. Мэдээж

¹ **strategic innovation** нь бизнесийн өсөлтийг хангах, компани, үйлчлүүлэгчдэд үнэ цэн, өрсөлдөөний давуу талыг бий болгох зорилгоор байгууллагын стратегийг дахин бодох, дахин төлөвлөх үйл явц.

“Хүнсний хувьсгал”, хүнс, хөдөө аж ахуй гээд явж байгаа юм бий.

Тэгэхээр энэ чиглэлийг Засгийн газрын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг, тэгээд өөрсдөө энэ дээрээ нэг оролцдог ийм өгөөжийг энэ юм чинь бий болгох ёстой болохоос.

Ингээд хэд хэдэн удаа л энэ хууль өөрчлөгдсөн юм. Одоо миний мэдэхээр.

Тэгээд л яах вэ манайхан өгөөж нь хаана байгаа юм, практик юм нь хаана байгаа юм. Тэгээд хэдэн цөөн улсууд суудаг. Зовлон жаргалаа яриад сууж байна.

Энэ хууль одоо гарвал саяын тэргүүлэх чиглэл, хандлага, хөрөнгө оруулалт, хүн хүчний нөөц гэдэг юм уу, энэ юмаа одоо яг яах юм бэ?

Тэгээд түрүүн Д.Рэгдэл гуай хэлж байна.

Ер нь манай энэ загвар чинь тэгээд альныг барьж байгаа юм бэ? Альныг барьж байгаа юм?

Бид том том улс Япон, Солонгос, Хятад гээд өндөр хөгжилтэй орнуудыг яриад байна. Тэгвэл тэр жижиг амжилттай хөгжиж байгаа улсуудын шинжлэх ухаан, технологийн чиглэлээр явуулж байгаа сангийнхаа үйл ажиллагааг яаж явуулж байна? Энэ талаар ямар нөхцөл, боломжуудыг энэ хууль бий болгох юм бэ?

Ер нь явж явж тэгээд л хүний сэтгэлгээ, арга барил. Өнөөдөр Монгол Улсад бүх шатад хүний менежерүүд л дутагдаж байна шүү дээ. Чадвартай хүн байхгүй.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Асуултад хариулъя. Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ж.Сүхбаатар гишүүн маш чухал асуудлыг хөндөж тавьж байгаа юм.

Яах вэ, ер нь манайхан нийгмээрээ шинжлэх ухаанд оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж гэж ярьдаг. Эндээс их хүлээлт байдаг.

Тэгсэн мөртлөө өөрсдөө яг зарцуулж байгаа санхүүжилттэй нь уялдуулахад өнөөдөр гарч байгаа өгөөжид би их сайн өгөөж өгч байна л гэж би харж байгаа.

Хэд хэдэн ийм үзүүлэлтүүд байдаг. Одоо бид жишээ нь 1 сая хүнд ногдож байгаа эрдэмтдийнхээ тоогоор даруй ижил төстэй хөгжлийн загвартай улсуудаас бид чинь 3 дахин бага байгаа шүү дээ. Ж.Сүхбаатар гишүүн ээ.

Одоо үндсэндээ хамгийн бага, хөгжил дорой гэж болох улсууд чинь л бараг 1 сая хүнд ногдож байгаа эрдэмтдийн тоо нь 1500 хүрчихсэн л юм билээ. Одоо манайх чинь 300-аас 400. Даруй гурав, дөрөв дахин бага байгаа.

Тэгээд ямар ч байсан шинжлэх ухаанд зарцуулж байгаа мөнгөнүүдээс, энэ судалгаануудаас тодорхой үр дүнгүүд гарсан байна.

Би хоёр үр дүнг бүр онцолж хэлэхийг хүсэж байгаа юм.

Нэгдүгээрт нь, **“Дархан-144”** дүгээр сорт гэдгийг “Шинжлэх ухаан, технологийн сан”-гийн санхүүжилтээр хийсэн судалгаа. Их олон жил хийсэн судалгаа.

Энэ халуун ганд тэсвэртэй ийм сортыг бий болгосноор өнөөдөр газар тариалангийн салбар жилд 10 тэрбум, сүүлийн 6 жил 61 тэрбум төгрөгийн нэмүү өртөг, ашиг олсон ийм тооцоо байгаа.

Энэ чинь бараг үндсэндээ 1, 2 тэрбум хүрэхгүй санхүүжилтээр л хийсэн судалгаа шүү дээ. Газар тариалангийн салбарын өрсөлдөх чадварт маш их хувь нэмэр оруулсан.

Хоёрдугаар асуудал бол манай Ж.Чинбүрэн гишүүний ахалж хийсэн, санаачилж хийсэн “элэг шилжүүлэн суулгах мэс заслын технологи, судалгаа”-нууд бас “Шинжлэх ухаан, технологийн сан”-гаас санхүүжүүлэгдсэн.

Тэгэхээр жил бүхэн дунджаар сүүлийн жилүүд чинь 8-аас 16 тэрбум төгрөгийн гадагшаа урсах үргүй зардлуудыг багасгасан байна. Олон зуун мянган хүний амь насыг аварсан байна.

Гэх мэтчилнээр “Шинжлэх ухаан, технологийн сан”-гаас санхүүжүүлэгдэж байгаа судалгаанууд тодорхой үр дүнд хүрч байгаа. Хүрч байгаа.

Хоёрдугаар хэмждэг үзүүлэлт бол энэ олон улсын нэр хүндтэй сэтгүүлүүдэд хэвлэгдсэн өгүүллүүдийн тоо, эндээс эшлэгдсэн өгүүллүүдийн тоогоор манай чинь сүүлийн 10 жилд манай эрдэмтэд Азидаа нэлээн дээгүүр үнэлэгдэж байгаа ийм судалгаа, ийм өгүүллэгүүд хэвлэгдэж гарч байгаа.

Нийт 1200 орчим өгүүллүүд энэ нэр хүндтэй сэтгүүлүүдээр хэвлэгдэж гарсан. Үүнээс 20 мянга орчим эшлэгдэж байна гэдэг бол манай монголч эрдэмтдийн мэдлэг инновац шинжлэх ухааны мэдлэг инновацийн эргэлтэд орж байна гэж бид

хэмжиж болно. Энэ бол маш том үзүүлэлтүүд. Маш том үзүүлэлтүүд.

Тийм учраас энэ сангийнхаа эх үүсвэрүүд болсон олон салбарт олон эх үүсвэрээс санхүүждэг энэ тогтолцоог л бид нэвтрүүлэх нь зүйтэй байна. Ганцхан улсын төсвийн ганц эх үүсвэр хараад ингээд суух илүү тийм дутмаг ядуу сэтгэлгээ юм. Эндээсээ бид салах ёстой, шинэ тогтолцоонд шилжих ёстой л гэж харж байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл асуултаа асууя.

Д.Сарангэрэл: (29-р тойрог, Хан-Уул дүүрэг)

Баярлалаа. Би Л.Энх-Амгалан сайдтай санал нэг байгаа юм.

Одоогийн төсвөөс олгогдож байгаа санхүүжилтийн хэмжээнд манай Д.Рэгдэл даргатай Шинжлэх ухааны академи, хүрээлэнгүүд сайн ажиллаж байгаа.

Санхүүжилтийнхээ бололцоогоор өөрсдийнхөө судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг зарим нь бодит амьдрал болгож хэрэгжүүлээд явж байгаа.

Санхүү байхгүйн улмаас хавтсанд өчнөөн олон ажил хэрэг болох, үр дүнгээ өгөх ийм судалгаа, шинжилгээний ажлууд байгаа.

Бид академи дээр, хүрээлэнгүүд дээр очиж ажиллаж байсан. Одоо энэ салбарыг зах зээлд шилжүүлэх болсон байна. Бүх салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлье гээд зөндөө их ярьсан. Газар дээр нь очсон.

Тэгээд харамсалтай нь энэ олон жилийн хугацаанд энэ ажлууд хийгдээгүй.

2006 оноос хойш шинжлэх ухаан, технологийн чиглэлийн хууль эрх зүйн орчинд өөрчлөлт ерөөсөө ороогүй.

Гэтэл цаг хугацаа харвасан сум шиг өнгөрч байна. Энэ амьдрал ахуй чинь өдөр тутамдаа маш хурдацтай өөрчлөгдөж байгаа учраас бид дандаа хоцроод байгаа юм.

Харин Л.Энх-Амгалан сайд маань Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг 2006 оноос хойш гар хүрээгүй хуулийг шинэчлээд оруулаад ирсэн байна.

Энд нэг маш анхаарал татсан заалт орсон байна лээ. Энэ салбарыг Ерөнхийлөгчийн түвшинд, Засгийн газрын түвшинд Шадар сайдын дэргэд Үндэсний зөвлөл байгуулж бодитоор дэмжиж ажиллах ийм заалтыг оруулсан нь бий.

Эрх биш олон жил ярьсан яриагаа ажил хэрэг болгох ийм боломж бүрдэх болов уу гэж бодож байна.

Хэрвээ санхүүжилтийнх нь асуудлыг шийдээд өгчих юм бол өчнөөн олон ажил хийх бололцоотой. Байгаа хэмжээндээ хийсээр ирсэн гэдгийг сая сайд жишээгээр авлаа.

Тухайлбал, тэр “элэг шилжүүлэн суулгах технологи”-ийг нэвтрүүлснээр өнөөдөр Улсын 1 дүгээр төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв манай Ж.Чинбүрэн гишүүн эмнэлгийн дарга байхдаа үүнийг хийж байсан юм.

Элэгний хавдартай хүнд элэг шилжүүлэн суулгах тэр мэс заслийг анх удаа хийсэн шүү дээ.

Одоогийн байдлаар 16 тэрбум төгрөгийн гадагшаа урсах урсгалыг

зогсоож чадсан ийм том амжилтыг гаргасан.

Түүнээс гадна коронавирусийн үед одоо энэ Японы тэр их сургуулиудад ажиллаад байдаг эрдэмтэн байдаг юм. Би уулзаж байгаагүй юм. Сошиалаар мэднэ.

Тэр Дашцоодолын Нямбаяр гээд. Мөн Н.Хүрэлбаатар захиралтай Анагаахын шинжлэх ухааны их сургуулийнхан “шүлснээс корона вирус илрүүлэх” ийм оношлуурыг хийж чадсан шүү дээ.

Мөн л санхүүжилт дутагдалтай байсан учраас бүх хүнд хүртээмжтэй байхаар бас хийж чадаагүй.

Энэ мэтчилэн хэрвээ бид санхүүжилтийнх нь хувьд дэмжээд, зах зээлийн зарчим руу нь оруулаад, энэ эрдэмтдийнхээ судалгаа, шинжилгээний ажлыг үнэлгээтэй болгоод ингэх юм бол Монгол Улс бүх салбартаа хэн нэгэн хүний зүгээр нэг гэнэтийн ухаан гэдэг юм уу, цочмог шийдлээр биш шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх ийм бололцоо нь бүрэн байгаа юм.

Миний хэлэх гээд байгаа нь та нар маань энэ хуулийн төсөлдөө одоо байгаа, олон улсад бол шинжлэх ухаандаа дотоод нийт бүтээгдэхүүнийхээ 4-өөс 5 хувийг зарцуулж байна. Манайх 0.1. Үүнийг яаж өөрчлөх гэж байгаа юм бэ? Энэ хуульд энэ л заалт орох юм бол амин сүнс нь бараг болох гээд байгаа учраас үүнийг хэлж өгөөч ээ гэж би нэгдүгээрт хүсээд байна.

Хоёрдугаарт, энэ салбарынхаа эрдэмтэн мэргэдийнхээ гадаад дотоодод сурах, туршлага солилцох тэр бололцоонууд нь үнэхээр их хаалттай байна.

Маш их хаалттай байна. Яагаад гэвэл энэ томилгооны зардал байхгүй. Гаднаас эрдэмтдийг уриад хамтран ажиллах бололцоо нь бас хаалттай. Ийм прагматик үйлдлүүдийг, ийм прагматик шийдлүүдийг бид гаргах юм бол шинжлэх ухааныхаа салбарыг бодитоор хөгжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх ийм боломжууд нь бүрдэх юм.

Тэгэхээр саяын миний хэлсэн чиглэлүүдээр хуульд ямар заалтууд оров гэдэг талаар би тодруулга аваад, дараа нь нэмэлт асуултаа асууя. Миний цаг дуусаж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Сарангэрэл гишүүн их чухал асуудал хөндөж тавьж байгаа.

Өөрөө эрүүл мэндийн сайдаар ажиллаж байхдаа ерөнхийдөө Шинжлэх ухаан, технологийн сангаас эрүүл мэндийн салбарт хийж байсан олон судалгаа, олон үр дүнг нэвтрүүлэхэд нэлээн улс төрийн манлайлал гаргаж ажилласан сайд гэж би боддог.

Ингээд гол нь энэ санхүүжилтийн тогтолцооны асуудал. Энэ хуулийн бараг үндсэндээ амин сүнс нь энэ санхүүжилтийн тогтолцоог л шинэчилж байгаа асуудал байгаа юм. Д.Сарангэрэл гишүүн ээ.

Одоо бид Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилт ганцхан улсын төсвөөр хийгддэг байсан бол одоо бид цаашдаа олон эх үүсвэрдийг гаргаж ирье.

Хувийн хэвشلүүд ерөнхийдөө сүүлийн үед энэ шинжлэх ухаан, технологи, судалгаа, хөгжүүлэлт рүү нэлээн хөрөнгө оруулдаг болсон. Үүнийг бид дэмжих ёстой.

Ер нь бусад улс орнууд, одоо Израйль гэдэг юм уу шинжлэх ухаанаа түлхүү хөгжүүлж хөгжсөн улс орнууд энэ шинжлэх ухаан, технологийнхоо сангийн санхүүжилт 60 хүртэл хувь нь хувийн хэвشلээс хийгддэг юм билээ.

Тийм учраас бид энэ хувийн хэвшилд хийгдэж байгаа, хувийн хэвشلээс хийгдэх гэж байгаа хөрөнгө оруулалтуудыг дэмжсэн ийм эрх зүйн орчнуудыг бид бий болгож өгөх ёстой гэж харж байгаа.

Хоёрдугаар асуудал бол энэ төрийн өмчит улсын үйлдвэрийн газрууд дээр маш их тийм боломжууд байгаа юм. Маш их том төсвүүд явдаг.

Харамсалтай нь, манай шинжлэх ухааны хүрээлэнгүүд түүнд нь орж чаддаггүй. Дундын нөгөө цүнхний компаниуд ингээд зуучилдаг нэг ийм тогтолцоотой болчихсон. Нөгөө тендерийн хонгил гэдэг шиг нэг ийм тогтолцоотой болчихсон.

Эрдэнэт дээр жишээ нь юу гэдэг юм зэс боловсруулах үйлдвэрт шаардлагатай байгаа 3 тэрбумын тендер зарлагдаад байхад хүрээлэнгүүд орж чаддаггүй.

Тэгэхэд хувийн компаниуд ороод тэрийг аваад манай хүрээлэнгүүдээр гүйцэтгүүлдэг нэг ийм цүнхний ченжийн тогтолцоонд орчихсон байсан.

Энэ тогтолцоог бид арилгахын тулд түрүүн тэр Тендерийн худалдан авалтын

тухай хуульд заалт оруулсан боловч тэр нь хасагдсан.

Гэхдээ бид өнөөдрийн өргөн барьж байгаа энэ хуулиар Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа худалдан авах хуулиар зохицуулагдахгүйгээр Засгийн газар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд үндэсний судалгаа, хөгжүүлэлтийн төсөл, суурь хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг шууд авдаг болох энэ тогтолцоо руу нэвтрүүлэх нь илүү их тийм шинжлэх ухаанаа дэмжсэн ийм санхүүжилт болох болов уу гэж бодож байна.

Хоёр дахь асуудал бол бид залуу эрдэмтдээ дэмжих тогтолцоонуудыг бий болгож байгаа. Д.Сарангэрэл гишүүн ээ.

Одоо энэ жилээс авхуулаад бид боловсролын зээлийн сангаас энэ докторт сурч байгаа, докторын судалгаа хийж байгаа энэ их дээд сургуулиудын багш нар, хүрээлэнгийн залуучууддаа бид цалинтай докторын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлж байна. Цалинтай.

Одоо үндсэн судалгаагаа хийгээд, үндсэн багшаар хийгээд, хажуугаар нь судалгаа хийнэ гэдэг бол байдаггүй юм билээ л дээ.

Тийм учраас цаашдаа бид үндсэн цалин, ингээд амьжиргааны зардал. Гадаадад сурч байгаа бол үндсэн цалин, амьжиргааных нь зардлыг дэмжсэн залуу судлаач нараа дэмжсэн бас нэг ийм тэтгэлгүүдийг гаргаж ирж байгаа. Энэ тодорхой үр дүнд хүрч байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Та тодруулах уу? Д.Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

Д.Сарангэрэл: (29-р тойрог, Хан-Уул дүүрэг)

Л.Энх-Амгалан сайд аа, үнэхээр их баярлалаа.

Залуу эрдэмтдийгээ дэмжсэн, энэ шинжлэх ухааны салбарт залуучууд тийшээ орох ийм урам зоригийг нэмж байгаад баярлаж байна.

Яагаад гэвэл энэ шинжлэх ухааны салбарт ороод өөрийнхөө бүх л амьдралаа зориулдаг юм билээ шүү дээ. Тэгээд ийм хүмүүсээ дэмжихгүй болохоор зэрэг манай энэ шинжлэх ухааны салбарт залуучууд маань нэлээн тийм хойрго хандах болсон гэсэн ийм судалгааны дүн байгаа юм билээ.

Би Та бүхэндээ нэг мэдээлэл өгөөд орхиё.

Мэргэжлийн эрдэмтэн судлаачдын баг судалгааны тайланд Монгол Улс судалгаа хөгжүүлэлтийн үндсэн үзүүлэлтээр 1 сая хүн амд 374 эрдэм шинжилгээний ажилтан ногдож байна гэж байгаа юм.

Тэгээд 1 хүнд ногдох судалгаа хөгжүүлэлтийн зардал нь ерөөсөө 3.9 ам.доллар.

Энэ нь дэлхийн дунджаас 10-аас 30 дахин бага. Ийм мэдээлэлтэй байхад эрдэмтэн больё, өөрийнхөө авьяас билгээ хөгжүүлбье, өөрийгөө эх орондоо зориулъя гэх тийм хүсэл эрмэлзэл хэнд ч.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Сарангэрэл гишүүний тодруулгад хариулъя. Л.Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Сарангэрэл гишүүнтэй санал нэг байна.

Үнэхээр манай эрдэмтэд бол яг эх оронч л доо. Ер нь бол.

Цалин харж судалгаа хийдэггүй.

Тэгээд нийгмийн баталгааг харж судалгаа хийдэггүй. Яг л цэвэр өөрийнхөө хүсэл тэмүүлээр хийдэг л нэг ийм л улсууд байдаг юм билээ. Их тэсвэртэй, тэвчээртэй, хүлээцтэй ийм улсууд.

Тийм учраас цаашдаа Монголын төр, засаг эрдэмтдийн цалин, нийгмийн баталгааны асуудал дээр тодорхой ахиц өөрчлөлтүүд гарах ёстой.

Гэхдээ яах вэ үр дүнгүүд гарч байна. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд ямар ч байсан манай эрдэм шинжилгээний ажилтнуудын цалин 40-өөс 80 хувь нэмэгдсэн.

Гэхдээ бид ямар ч байсан Засгийн газраас шийдвэр гаргаад цалингийн доод хэмжээг нь бид тогтоогоод өгчихсөн юм. Доод хэмжээг.

Одоо дээд хэмжээгээр дээшээ өөрийнхөө хийсэн судалгаа, хүрээлэнгүүдийн өөрийн орлогоороо цалингаа дээшээ хязгаар байхгүйгээр нэмээд явах, 3 сая, 5 сая төгрөгийн цалингийн хэмжээнд хүргээд явах боломжууд гарч байгаа.

Одоо жишээ нь, манай Химийн хүрээлэн гэхэд тодорхой судалгаа, шинжилгээнийхээ орлогуудаар эрдэмтдийнхээ цалинг хоёр дахин нэмсэн.

Дээшээ нөгөө хязгааруудыг нь аваад өгчихсөн учраас ийм орон зайнуудыг олгосноор тодорхой бодитой үр дүнгүүд гарч байгаа.

Тэгээд миний түрүүний хэлж байгаа цалинтай докторуудын хөтөлбөрүүд. Мөн гадаадад судалгаа, шинжилгээ хийж байгаа эрдэмтдээ бид эх оронд нь авчрахгүйгээр энд байгаа эрдэмтэн судлаачидтай хамтарсан хамтын судалгаануудыг хийх, хамтын нээлттэй лабораториудыгаа ашиглах чиглэл рүү **“е-зөгий”** гэж нэрлээд байгаа юм. Тийм ээ. Энэ цахим зөгий хэлбэрээр энэ хөтөлбөрүүд хийж гадаадад гарсан **“Brain Drain”** гэж нөгөө **“оюуны дайжилт”**-аа буцаж **“Brain Gene”** болгох энэ чиглэл рүү тодорхой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, сайн үр дүн, сайн санал санаачилгууд гарч байна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал асуултаа асууя.

Н.Ганибал: (12-р тойрог, Сүхбаатар аймаг)

Баярлалаа. Шинжлэх ухаан, технологийн энэ үйл явцаа бид сайжруулах нь зайлшгүй шаардлагатай байгааг бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр ер нь зүгээр одоогийн явж байгаа асуудал дээр сая жишээ татагдаад байгаа хэдэн салбарууд маань мэдээж Монгол Улсад хөдөө аж ахуйн салбар, дээрээс нь эрүүл мэнд, түүн дотроо элэгний өвчлөл гэдэг яг зайлшгүй бид бүхэн манай эрдэмтэд, эмч нар, судлаач нар энэ дээрээ түлхүү ажилладаг, эндээсээ бид ололт олдог, чадамжаа сайжруулдаг ийм л салбарууд л даа.

Тэгэхээр миний санал болохоор ер нь бид энэ хөдөө аж ахуйн салбар, энэ эрүүл мэндийн асуудлууд дээрээ “Шинжлэх ухаан, технологийн сан”-гийнхан түлхүү баримталдаг байж болох уу? Энэ хуулиараа.

Ер нь бидний өнөөдөр хамгийн хэрэгцээтэй байгаа гэдэг асуудлаар. Нэн ялангуяа энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хөдөө аж ахуйн салбар дээр гарах маш олон асуудлууд бидний өмнө байгаа. Үүнийгээ яаж даван туулах вэ? Тэргүүлэх салбаруудыг гаргаж тавих асуудлын шинэ хуулиараа бид гаргаж ирж болох уу?

Ер нь одоогийн байгаа нөхцөл байдал бүгд ойлгож байгаа. Хүрээлэнгүүд маань ер нь өөрсдийнхөө урсгал зардлыг л авдаг. Яг шинжлэх ухааныхаа ажлуудыг болохоор мэдээж нөгөө “Шинжлэх ухаан, технологийн сан”-гаас авдаг. Тийм ээ.

Тэгэхдээ тодорхой хэмжээнд эрдэмтдийн санал оруулаад хийх гэсэн ажлуудын санхүүжилт нь оруулсан мөнгөнөөсөө дандаа бага. Тийм ээ. Тодорхой хувиар бага мөнгөн дүнгээр орж ирээд тэгээд л ажил нь яг гүйцэд тултал нь санхүүгүй учраас тухайн судалгаагаа гүйцэд хийж чаддаггүй ийм асуудлууд ер нь ихэнх төслүүд дээр гардаг л даа.

Хоёрт нь, бидний хамгийн том мөнгөө зардаг асуудал бол лабораторийн баталгаажуулалт хийлгэхийн тулд олон улсын лавлагаа лабораториудад хамаг хөрөнгөө зардаг.

Тэгэхээр бид ер нь олон улсын лавлагаа лабораториудыг нэн тэргүүнд барих асуудал дээр бид нарын өнөөдөр энэ хуулиараа баталгаажуулах боломж байгаа юм уу?

Ер нь хуучнаасаа бид тодорхой хэмжээнд бүтцийн хувьд өөрчлөлтүүд орж байгаа боловч яг бодитой санхүүгийн хувьд бид илүү боломжуудыг бий болгоно гэдэг юм уу, энэ хуулийн хамгийн давуу талыг та нэг хэлээд өгөөч.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Л.Энх-Амгалан сайд асуултад хариулья.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Н.Ганибал гишүүний асуултад хариулья.

Н.Ганибал гишүүн ээ, ерөнхийдөө бид энэ **“Цөм технологи”** гэж тэргүүлэх чиглэлээр бид Засгийн газраар хоёр жил тутам батлагдаж, тэгээд энэ “цөм технологи”-д манай Монгол Улсын өрсөлдөх чадварын хамгийн чухал салбар болсон энэ хөдөө аж ахуй, уул уурхайн салбар, мэдээж нийгмийн салбарууд руу илүү түлхүү энэ санхүүжилтээ заръя гэсэн ийм бодлого барьж байгаа.

Бид чинь их хязгаарлагдмал боломжтой. Жилийн 10-аас 12-хон тэрбум төгрөгийн санхүүжилтгүйгээр судалгаа, хөгжүүлэлтээ хийж байгаа л ийм л айл шүү дээ.

Гэлээ гэхдээ одоо гоншигноод байх юу байх вэ. Бид хамгийн гол шинжлэх ухаанаа хөгжүүлж чадсан энэ Израйль, Сингапур, Эстони гэсэн хүн ам цөөтэй, санхүүгийн хязгаарлагдмал нөөцтэй байсан энэ улс орнуудын тэргүүн туршлагаудыг л бид сайн судалж, энэ тогтолцоог хийх нь зүйтэй юм болов уу л гэж бид энэ хуулиа хийхдээ энэ улсуудын хууль эрх зүйн орчнуудыг судалсан.

Тэр тусмаа өнөөдөр энэ хөдөө аж ахуйн салбар хамгийн эрсдэл дагуулж байгаа байгаль цаг уурын хамгийн эрсдэлтэй нөхцөлд байгаа.

Тэгэхээр сая өнгөрсөн долоо хоногт Монгол Улсын Их Хурлаар батлагдаж гарсан тэр

“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” гэсэн энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд манай хөдөө аж ахуйн салбарын хүрээлэнгүүд, хөдөө аж ахуйн салбарын хүрээлэнгүүд дээр хийсэн судалгаа, шинжилгээнүүд эргэлтэд орох ийм шинэ боломжууд би гарч байна гэж ойлгож байгаа.

Өнгөрсөн 14 хоногийн өмнө манай хөдөө аж ахуйн чиглэлийн хүрээлэнгүүд, судалгаа, шинжилгээний байгууллагууд хамтарч ер нь цаашдаа Монгол Улсад мал аж ахуйн ямархуу тогтолцооны шинэчлэлүүд хийх ёстой юм бэ. Энэ дээр техник, технологи, инновацуудыг ер нь яаж нэвтрүүлэх ёстой юм бэ, ямар загвар байх ёстой юм бэ гэсэн талаар тодорхой санал бодлуудаа хуваалцаж зөвлөмжүүдийг гаргасан байгаа.

Тийм учраас бид энэ хөдөө аж ахуйн салбарт хийгдэж байгаа судалгаа, шинжилгээнүүд эргэлтэд орж хөдөө аж ахуйн салбаруудыг өрсөлдөх чадвартай болоход нэлээн хувь нэмэр оруулна гэсэн ийм бодолтой байна.

Хоёрт нь, лабораторийн асуудал та хөндөж тавьж байна. Их зөв.

Өнөөдөр Монгол Улсад байгаа лабораториудынхаа нөөцүүдийг, менежментүүдийг бид сайжруулах ёстой.

Япон Улсын Засгийн газрын санхүүжилттэйгээр хэрэгжсэн **“Мянган инженер”** төслийн хүрээнд

манай их дээд сургуулиуд маань лабораторийн хэмжээнд маш том шинэчлэл хийж чадсан.

Цаашдаа бид энэ лабораториудаа дундын нээлттэй лабораториуд болгох, лаборантын орон тоонуудыг бий болгох.

Мэдээж шаардлагатай байгаа урвалж бодисууд, тоног төхөөрөмжүүд, технологийн шинэчлэлүүд хийж, урсгал зардлуудыг нь бид шийдэж өгснөөр одоо байгаа лабораториудынхаа үр өгөөжийг хүртэх ийм тогтолцоог энэ хуулиар бас ингэж оруулж ирж байгаа гэдгийг би онцолж хэлье гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Одоо Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуултаа асууя.

Д.Өнөрболор: (13-р тойрог, Сэлэнгэ аймаг)

Судалгаагаар бусад улсад дотоодын нийт бүтээгдэхүүний 4-өөс 5 хувийг шинжлэх ухаан, технологид зарцуулж үр ашгийг нь үндэстэн даяараа хүртэж байгаа. Тухайлбал,

- Бүгд Найрамдах Солонгос Улс дотоодын нийт бүтээгдэхүүний **4.4 хувь**,
- Израил **3.9 хувь**,
- Финлянд **3.5 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө зарцуулж байна.**

Тэгэхээр аливаа асуудлаа шийдэх, өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд шинжлэх ухаан, технологийн тогтолцоог амжилттай хөгжүүлсэн туршлага, сургамж ч гэсэн хамгийн ойрын жишээ гэх юм бол эрүүл мэнд, биотехнологийн салбарт цар тахлын үеийн нөхцөл байдал тод жишээ харуулж чадсан.

Гэтэл манай улс 1991 оноос хойш парламентын болон Засгийн газрын түвшинд шинжлэх ухаан, технологийн тогтолцоогоо бэхжүүлж чадаагүй. Зөвхөн салбарын асуудал мэтээр хандаж ирсэн нь бидний маш том алдаа байсан гэдэг нь тодорхой харагдаж байгаа.

Тэгэхээр нэн ялангуяа дэлхий дахинаа шинжлэх ухааны салбар **“парадигм”**²_[paradigm]-ЫН түвшинд нэлээдгүй өөрчлөгдөж байгаа.

Тэгэхээр Л.Энх-Амгалан сайд Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбарын шинэчлэлийн бодлогыг үндсэн 8 чиглэлд төвлөрүүлэн ажиллахаар оруулж ирж байгааг миний хувьд санаачилгыг нь дэмжиж байгаа юм.

Аливаа салбар шинжлэх ухааны үндэслэлтэй, эдийн засгийн бүтээмжтэй, эргэлттэй байх ёстой байр суурин дээр байдаг хүний хувьд дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувийг 0.11-ээс 3 хувь хүртэл хүргэх, эдийн засагт үзүүлэх үр дүнг нь нэмэгдүүлэх тал дээр санаа тавьж явдаг хүний хувьд асуулга тавьж байсан.

Тэгээд энэ асуудлын хүрээнд тодорхой асуудлуудыг нь шийдэхээр оруулж ирж байгаад талархаж байна.

Ер нь шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт нийт 1700 гаруй эрдэмтэн, судлаачид ажилладаг юм байна. Манайд.

Тэгээд энэ салбарын жилийн нийт төсөв нь 38.0 тэрбум төгрөг. Ихэнх нь урсгал зардалд зарцуулагддаг юм байна.

Тэгэхээр дэвшилтэт технологийн үйлдвэрлэл, тэр дундаа биотехнологийн чиглэлээр Сингапурын нийт экспортын 45.0 хувийг эзэлж байна, Солонгосын гэхэд 26 хувийг эзэлж байна. Манайх 90 хувьд ашигт малтмал, 5 хувьд нь хүрэхгүй нь өндөр технологи эзэлж байгаа юм.

Тэгэхээр энэ салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр дүн гаргахад төсвийн болон төсвийн бус эх үүсвэрүүдийн нэмэгдүүлэх тал дээр нэн онцгой анхаарах хэрэгтэй байна. Л.Энх-Амгалан сайд аа.

Энэ тал дээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар Та тайлбарлаж хэлж өгөөч ээ гэж хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Тантай санал нэг байна.

Гол нь яах вэ, бид Үндсэн хуульд заасан заалтаа хэрэгжүүлж чадаагүйн горьг л өнөөдөр амсаж байна гэж ойлгож болно.

Хэрэв бид Монгол Улсын Засгийн газарт Үндсэн хуулиар олгосон тэр эрх үүргүүдийг оруулаад, яг шинжлэх ухаан, технологийнхоо үндэсний бодлогыг батлаад, тэгээд түүн дээрээ үндэслэж нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл, улсын төсв баталдаг тогтолцоотой явсан бол өнөөдөр ийм үр дүн байхгүй болов уу л гэж бодож байгаа юм.

Хоёрдугаар асуудал. Тэр 2010 онд ямар санаатайгаар хийсэн зүйл юм байгаа юм. Би энэ дээр бүр гайхаад л байгаа юм.

² **paradigm** шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах онол, судалгааны арга, постулат, стандарт зэрэг ойлголт, сэтгэлгээний хэв маяг.

Салбарын сайдын хувьд. Ямар хүний гараар ороод.

Тэр “шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал” гэдэг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаас үүнийг аваад хаячихсан байгаа юм.

Энэ одоо санаатай хийгдсэн юм уу, санаагүй хийгдсэн юм уу, гаднын нөлөөлөл орсон юм уу, үгүй юм уу гэдгийг бид шалгах ёстой л болов уу гэж бодож байгаа юм.

Тэгэхээр **“шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал”** гэдэг нь “Шинжлэх ухаан, технологийн хүний нөөц, дэд бүтэц, тэргүүлэх чиглэл, цөм технологийг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь шинжлэх ухаан технологийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” гэсэн уг нь хамгийн сайн заалт байсан юм билээ.

Тэгээд шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, тэргүүлэх чиглэлийг тогтоож, дотоодын нийт бүтээгдэхүүний 2-оос доошгүй хувийг шинжлэх ухааны арга хэмжээ санхүүжүүлэхэд зарцуулна.

Судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг дэмжих, шинжлэх ухааны нээлт, оюуны бүтээлийг баталгаажуулах, гадаад технологийг Монгол Улсад нутагжуулах эрх зүйн баталгааг бүрдүүлэх гээд зайлшгүй хийгдэх ёстой бодлогын 11 арга хэмжээнүүдийнхээ эрх зүйн орчныг ингээд муутгачихсан нэг ийм л нөхцөл байдал үүссэн учраас та бид өнөөдөр ингээд шинжлэх ухаандаа зарж байгаа мөнгө, шинжлэх ухаанаасаа хүртэх ёстой өгөөжөө хүртэж чадахгүй ийм байдалтай байна.

Гэлээ гэхдээ зовлон тоочиж суугаад яах вэ. Гэхдээ ямар ч байсан шинжлэх ухаан, технологийн салбарт зарцуулагдаж байгаа энэ мөнгүүдийг бид үр бүтээлтэй зарцуулах.

Ингээд цаашдаа бид шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд **“Цөм технологи”**-ийнхөө жагсаалтуудыг баталж авсан.

Энэ дээр бид **“Цөм технологи”** тэргүүлэх чиглэлд орсон салбарууд дээрээ байгаа мөнгөнүүдээ үр бүтээлтэй зарах ийм л нөхцөлүүд байгаа.

Гэхдээ бид шинжлэх ухаан, технологийнхоо сангийн бүтэц, зохион байгуулалтууд, үйл ажиллагаан дээр нь өөрчлөлт оруулж, олон жил шаардагддаг суурь судалгаануудаа санхүүжүүлдэг тогтолцоонд шилжүүлсэн.

Мөн өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоонуудыг гаргаж ирж байна. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн эрдэмтдийн хамтарсан судалгаа, салбар дамнасан, салбар хоорондын судалгаануудыг бид тодорхой санхүүжүүлэх ийм тогтолцооны шинэчлэлүүдийг хийж байгаа гэдгийг танд хэлье.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Одоо Улсын Их Улсын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: (1-р тойрог, Архангай аймаг)

Ямар ч бай хуулийн төслүүдийг зарчмын хувьд дэмжиж байна. Бүхэлд нь хуулийн төсөлтэй бүрэн уншиж танилцаж амжаагүй байгаа.

Тэгэхээр манай 20, 30 жилийн өнгөрсөн энэ хугацааны хамгийн том алдаа бол шинжлэх ухааны салбарыг бодитоор дэмжиж чадаагүй, энэ салбарыг хөгжүүлээгүй.

Тэгэхээр бид цаашид энэ салбарыг дэмжихгүйгээр, хөгжүүлэхгүйгээр бусад салбарын хөгжлийг ярих ямар ч бодит боломж бололцоо байхгүй.

Тэгэхээр би бол нэг талдаа бага зэрэг шүүмжлэлтэй хандах гээд байгаа зүйл бол ер нь бид маш том бодлогын бөгөөд хандлагын өөрчлөлтийг гаргах зайлшгүй шаардлагатай байна.

Өнгөрсөн 20, 30 жилийн алдаа оноог нэг талдаа бас нэг цэг тавиад ер нь жоохон том амбицтай байвал яасан юм бэ л гэсэн санал хэлэх гээд байгаа юм. Том амбицтай байвал.

Тэгэхээр бид үндсэндээ улс орныг авч явж байгаа эдийн засгийн гол салбарууд болсон хөдөө аж ахуй, мал аж ахуйч гэдэг юм уу, газар тариалан, уул уурхай, эрчим хүч гэдэг юм уу энэ салбар болгон дээр бид инновац, технологийг шингээхгүйгээр судалгаа, хөгжүүлэлтийг хийхгүйгээр, магадгүй энэ салбарууд дээр шинэ технологийг нэвтрүүлэхгүйгээр, инновацыг бий болгохгүйгээр, судалгаа хөгжүүлэлтийг бий болгохгүйгээр хөгжил яриад ямар ч боломжгүй. Үндсэндээ яг л өнөөгийнхөө байгаа бахь байрандаа л ингээд л зогсож л байх л болно л доо.

Тэгэхээр би зүгээр том амбиц гээд байгаа нь том амбиц маань яаж бид энэ шинжлэх ухааны салбарыг эдийн засагжуулах вэ гэдэг асуудал байгаа юм. Нөгөө талдаа бусад энэ хөгжлийнхөө эдийн засгийн тулгуур болсон салбаруудаа яаж шинжлэх ухаанжуулах вэ,

инновацжуулах вэ, шинэ технологи нэвтрүүлэх вэ л гэдэг асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ хоёрын уялдаа холбоог бид бодлогын зангилаагаар гаргах ёстой. Би том амбиц гэж хэлээд байгаа нь нэг талдаа бараг энэ салбараа бид дэмжсэн ч юм шиг, дэмжээгүй ч юм шиг, амьтай ч юм шиг, амьгүй ч юм шиг байлгаж байхаар илүү бүр том түвшинд гаргаж ирээд, яг энэ Шинжлэх ухаан, технологийн яам гэдэг юм уу, бодлогын түвшинд гаргаж ирээд эргээд төрөөс нь үндсэндээ том бодлого яриад явмаар байгаа юм.

Түүнээс жишээ нь боловсролын яамны дэргэд ч гэдэг юм уу, ингээд зүгээр нэг агентлаг ч юм шиг, хүрээлэн ч юм шиг ийм нөхцөл байдалтайгаар хөгжинө гэж би байхгүй гэж хараад байгаа юм.

Салбар болгонд бид нарт угаасаа яг энэ технологи өөрөө хэрэгтэй байна.

Тэгэхээр бид шинжлэх ухааныг, шинэ технологийг нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, эдийн засагжуулах энэ харилцаа хамгийн чухал байна.

Энэ дээр та хэд маань шинэчилсэн найруулга, энэ том бодлогын өөрчлөлтөө хийж байгаа дээрээ нэг мөр том бүр ул суурьтайгаар нь хараад нэг хийж болохгүй юм уу?

Энэ салбарыг л бид тодорхой хэмжээнд бүрэн эдийн засагжуулж, тогтолцоо, засаглалыг нь бий болгож байж л явахгүй бол өөрөөр би төдий л яг өнөөгийн энэ хурдаар өөрчлөлт гарна гэхэд хүнд байгаа юм.

Одоо үндсэндээ хөдөө аж ахуй дээр ч тэр, газар тариалан дээр ч тэр, мал аж ахуй дээр ч тэр, уул уурхай дээр ч тэр яаж

бид энэ хөдөлмөрийг нь хөнгөвчлөх вэ гэдэг. Тэр хөдөлмөрийн бүтээмжийг нь дээшлүүлэх үү, үр ашгийг нь нэмэгдүүлэх үү, яаж шинэ технологийг нэвтрүүлэх үү л гэдэг л хамгийн том л асуудал болоод байна.

Үйлдвэрлэлийг бид яаж бий болгох вэ гэдэг. Үйлдвэрлэлд бид шинжлэх ухаанчаар яаж хандах вэ.

Ер нь төсөв гээд, төр гээд. Мэдээж төрийн үүрэг, хариуцлага байгаа. Төр бодитой дэмжлэгээ үзүүлэх ёстой.

Нөгөө талдаа энэ салбар маань өөрөө босож өндийгөөд бие даасан байдалтайгаар хувийн хэвшилтэйгээ хамтарч ажиллах, салбар болгонтойгоо хамтарч ажиллах тэр орон зайн юмнуудыг бий болгох ёстой.

Өнгөрсөн 2023 оны төсвөөс эхлээд нэг талдаа бид шинжлэх ухааны байгууллагууд болоод их дээд сургуулиудыг өөрсдөө орлого олох эрхийг нь нээж өгсөн. Буцаад захиран зарцуулах эрхийг нь нээж өгсөн.

Энэ чинь уг нь төрөөс нэг талдаа бид энэ эдийн засгийн харилцаанд орох эрхийг нь нээж өгөөд байгаа. Тэгээд үүний үр дүн хэр байгаа юм? Энэ дээр үнэлж дүгнэж үзэх л хэрэгтэй байгаад байна. Илүү өөрсдөө бүтээлч манлайлагч байх шаардлага байна л гэж хараад байгаа юм.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Л.Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Г.Тэмүүлэн гишүүнтэй санал нэг байна.

Тогтолцооны том амбицтай шинэчлэл хийх ёстой. Тэр дээр би санал нэг байна.

Ямар ч байсан бид өргөн барьсан энэ хууль дээрээ Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд ахалдаг болгож ийм тогтолцоо оруулж ирж байгаа. Тийм тогтолцоог бид хийсэн.

Ер нь яах вэ Эдийн засгийн хөгжлийн яам их түлхий үүрэг рольтой байх ёстой гэж би ойлгож байгаа.

Биеийн тамир, спорт хариуцсан тусдаа сайд гаргаж болсон юм. Соёл хариуцсан тусдаа сайд, яам гаргаж болсон юм.

Ер нь Шинжлэх ухааны яам байх ёстой гэж би ойлгодог байхгүй юу.

Ингээд олон жил шинжлэх ухаан чинь яг үндсэндээ боловсрол соёл, биеийн тамир, шинжлэх ухаан гэсэн нэг ийм хавсарга маягтай л явж ирлээ шүү дээ.

Тэгээд биеийн тамир хариуцсан сайд гараад ирэхээр тодорхой ахиц гарч болдгийг Б.Бат-Эрдэнэ аваргаас бид харж болж байна.

Соёлын яам байгуулагдахаар тодорхой салбарын асуудлууд шийдэгдээд явчихдаг ийм сайн үр дүнгүүд байна.

Тэгээд цаашдаа Монгол Улс хөгжье, дэвшье, өрсөлдөх чадвараа дээшлүүлье гэх юм бол энэ шинжлэх ухааныхаа бодлогыг нь шийдвэр гаргах түвшинд нь тусдаа бие даасан яам байх ёстой л гэж би салбарын сайдын хувьд ингэж үздэг, ингэж хардаг.

Өнөөдөр Монгол Улсын экспортод гарч байгаа нийт бүтээгдэхүүний чинь бараг үндсэндээ 93 хувь нь ямар ч мэдлэг, технологи, инновац шингэсэн бүтээгдэхүүн бид экспортолж чаддаггүй. Хөдөө аж ахуйн салбар ч ийм байна, уул уурхайн салбар ч ийм байна.

Ер нь яагаад монгол хүний бүтээмж ингээд бусад улс орнуудтай харьцуулахад ийм бага болчихсон юм. Монгол хүн яахаараа цагт 2-оос 3 долларын бүтээмж хийдэг. Бусад улс орнуудын ард иргэд нь даруй манай монгол хүнээс 10-аас 20 дахин бүтээмжтэй ажилладаг ийм хүний нөөцийг, ийм хүний хөгжлийг бий болгож чадсан юм бэ гэдэг бол цэвэр шинжлэх ухаан, технологи, инновац шүү дээ. Тийм ээ.

Одоо хамгийн сайн жишээ Израйль.

Тийм учраас бид шинжлэх ухааныхаа тогтолцоог ер нь Израйль Улсын тогтолцоо.

Израйль чинь бол яг хөдөө аж ахуйгаа. Хамгийн их технологи, хамгийн их инновац шингэсэн улс орон чинь Израйль байгаа юм.

Тэгээд Израйль Улсын шинжлэх ухаан, технологидоо барьсан энэ бодлого, менежментийн тогтолцоо манай улсад илүү их тохирох.

Бид их олон салбар луу сарнихгүйгээр цөөн хэдэн хөгжлийн том мотор болох хөдөө аж ахуйн салбар, уул уурхайн салбарууд дээрээ л бид илүү их мэдлэг, инновац шингээсэн. Энэ мэдлэг, инновац, судалгаануудыг бүрэн санхүүжилтийн циклээр нь санхүүжүүлж чаддаг.

Нөгөө “үхлийн хөндий” рүү судалгаа, шинжилгээнүүдээ алдаад байдаг биш суурь судалгаа. Тийм ээ. Хөгжүүлэлт, зүгшрүүлэлт, тэгээд тодорхой нийгэм, эдийн засгийн салбарт эргэлт, бүтээгдэхүүн инновац гаргах энэ бүтэн тогтолцоонуудыг л хийж чадах юм бол бид жинхэнэ утгаараа тогтолцооны шинэчлэл болж чадна л гэж бодож байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: (1-р тойрог, Архангай аймаг)

Тэгэхээр салбарын сайд том амбиц дээр санал нэгтэй байгаад талархаж байна.

Тэгэхээр үндсэндээ яг энэ шинжлэх ухааны салбар өөрөө том амбицтай байж, том тогтолцоотой, засаглалтай байж Шинжлэх ухаан, технологийн яамтай болгох зайлшгүй шаардлагатай гэж хараад байгаа.

Энэ дээр нэмэх нь бид оюуны өмчийг салгаж авч үзэж ерөөсөө болохгүй. Үндсэндээ аваад үзэхээр бас л нэг ийм нэг дагавар, дайвар салбар шиг л энд тэнд. Хууль зүйн яам ч очоод байдаг. Тийм ээ.

Тэгэхээр Шинжлэх ухаан, технологийн яам гээд байгуулагдах юм бол энэ оюуны өмчтэй нь цуг бие даалгаад эргээгээд бүх салбар болгонд инновац, технологийг шингээх талаар ажилладаг ийм бүтэц, бүрэлдэхүүнийг л бий болгох ёстой гэж хараад байгаа.

Хэрэв хуулийн төсөл дээр ч гэдэг юм уу бид одоо Их Хурал дээр уг нь том бодлогын шинэчлэлийг хугацаа заагаад хийвэл уг нь их сайн байгаа шүү. Тэр дээр анхаарч ажиллаарай л гэж хэлэх гэсэн юм.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо үг хэлэх гишүүн байна уу? Нэрээ өгөөрэй.

Б.Баярсайхан гишүүнээр тасаллаа. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн л үг хэлнэ.

Тэгэхээр дэмжиж байгаа болон дэмжээгүй эсэхээ заавал хэлээд үгээ хэлнэ шүү. Гишүүд.

Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: (10-р тойрог, Өвөрхангай аймаг)

Баярлалаа.

Шинжлэх ухаан, технологийн тухай их чухал хууль байгаа юм. Хуулийн төслийг дэмжиж байна. Би хоёр, гуравхан санал хэлье гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт нь, бид шинжлэх ухаан, технологийн салбарт асар их хөрөнгө оруулалт оруулах ёстой юм.

Улсын төсөв сүүлийн үед нэг ийм болчихоод л байгаа юм. Тэдэн хувь гээд л. Тэгээд тэр нь ч нэг их хэрэгждэггүй.

Тодорхой хөрөнгө мөнгө тавьдаг энэ систем рүү оруулж өгмөөр байгаа юм. Ялангуяа Засгийн газрын хүрээнд үүнийг бүр тодорхой авч үзэх ёстой.

Тэгээд л улсын төсөв хэлэлцэх үед л манай хэдэн эрдэмтэн, судлаачид, хүрээлэнгүүд чинь хэдэн төгрөг гуйгаад л. Иймэрхүү хэлбэрээр л байгаа юм.

Тийм учраас би санхүүжилтийн систем нь бүр их оновчтой, үр дүнтэй ийм болгох чиглэлд нь их онцгой анхаарч хуулийн төслийг цаашид чамбайруулах ёстой юм уу гэж бодож байгаа юм.

Хоёр дахь юм нь, шинжлэх ухаан, технологийг арилжааны чиглэл рүү оруулмаар байгаа юм. Бид арилжааны чиглэл рүү нэг их сайн оруулж өгөхгүйгээс болоод шинжлэх ухаан, технологийн олон сайхан нээлт, гаргасан юмыг хэрэгжүүлж чадахгүй байгаа юм.

Би зарим бүтцийн өөрчлөлт хүртэл энэ дээрээ хийх хэрэгтэй юм уу гэж боддог юм. Тухайлбал, бодитой салбаруудын энэ шинжлэх ухааны байгууллагуудыг салбарт нь өгдөг ч юм уу.

Тухайлбал, хөдөө аж ахуйн салбар байгаа юм. Тэр мал эмнэлэг, мал үржил, газар тариалан, ургамал, хорио цээр гээд өөртөө байж өөрөө ажлаа явуулдаг систем рүү нь оруулж. Тухайн салбар нь хүртэл өөрсдөө хөрөнгө мөнгө тавьдаг. Зөвхөн Шинжлэх ухааны академи дээрээ биш тухайн салбар нь өөрсдөө тавьдаг. Ингэж байж энэ өөрөө санхүүжилтийг нь.

Тэгээд дээр нь бизнесийн чиглэл рүү явмаар байгаа юм.

Гурав дахь асуудал юу байна вэ гэхээр шинжлэх ухаан, технологийн ололт амжилт, судалгаа, туршилтыг ашиглах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх асуудал байгаа юм.

Манай эрдэмтэн, судлаачид ингээд л баахан цаас бэлтгээд л нэг зузаан юм бэлэн болгоод гаргачихдаг. Тэрийг нь ашигладаггүй. Үүнийг яаж ашигладаг болгох вэ гэдэг асуудал их чухал байгаа юм.

Манай Засгийн газар болон сайд нар үүнийг ашигладаг болгох ёстой байхгүй юу.

Тэгэхгүй сүүлийн үеийн хандлага улс төрчид өөрөө бүх юмыг нь мэддэг болчихоод болохгүй байгаа байхгүй юу. Нөгөө шинжлэх ухаан, судалгааны байгууллагын бүх юмыг нь хийгээд тавьчихсан. Тэрийгээ хэрэгжүүлдэггүй. Хэрэгжүүлдэггүй. Өөр юм яриад яваад байдаг. Гаднын гоё юм гэж яриад яваад байдаг.

Тэгэхээр яаж энэ хуульд тусгаж өгөх. Хамгийн гол санаа тэр шинжлэх ухааны байгууллагын бий болгосон юмыг ашигладаг, хэрэглэдэг, хэрэгжүүлдэг, тэрийг хөгжүүлж авч явдаг, санхүүжилтийг нь шийдэж явдаг ийм систем рүү ормоор байгаа юм.

Үүнийг энэ хуульд нь нэлээн тодорхой суулгаж өгмөөр байгаа юм.

Хамгийн бид нарын дутагдалтай юм энэ.

Шинжлэх ухааны байгууллагаараа баахан юм хийлгэчихдэг. Нөгөөдхөө ашигладаггүй. Тэгээд нэг хүн гарч ирээд л нэг юм хийлгэдэг. Дараагийн хүн гарч ирээд л дараагийн өөр юм хийлгэдэг. Ингээд ерөөсөө шинжлэх ухааны байгууллага нь ч гэсэн зарим үед бараг толгой нь эргээд шахуу явчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид шинжлэх ухааны байгууллагын хийсэн юмаа хэрэгжүүлдэг болгомоор байгаа юм.

Энэ дээр нь хуулийн төсөлд тодорхой зүйлүүд тусгах шаардлагатай байна гэж бодож байна. Тэгээд хуулийн

төслийг аль болохоор жаахан хурдан хэлэлцээд явах шаардлагатай болов уу гэж бодож байна.

Яагаад гэхээр бидний бүрэн эрхийн хугацаа чинь 2 сар хүрэхгүй хугацаа үлдэж байна шүү дээ.

Тийм учраас хэрэв баталъя гэж үзэж байгаа үүнийг аль болохоор жоохон хурдан, чанартай, мэргэжлийн хүмүүсийг маш сайн татан оролцуулж ингэж хэлэлцэж шийдвэрлэх шаардлагатай байх гэж бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Тогтохсүрэн гишүүн дэмжиж үг хэлсэн. Тийм ээ.

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье.

Өнөөдөр буюу 04 дүгээр сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа төрсөн байна.

Танд төрсөн өдрийн мэнд өргөн дэвшүүлье. /алга ташив/

С.Одонтуяа гишүүн аав Дангаасүрэнгийн Салдан, ээж Буяндалайн Чимэддолгор нарын отгон хүүхэд болон энэ өдөр мэндэлсэн байна.

Мөн энэ өдөр мэндэлсэн Гочоогийн Ганболд гишүүн, мөн Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан нарт төрсөн өдрийн мэнд хүргэж Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Та бүхэнд болон гэр бүлийнхэнд нь Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. /алга ташив/

Эмэгтэй хүний насыг асуудаггүй юм. Энэ С.Чинзориг гишүүн дандаа болохгүй юм асууж явдаг хүн шүү.

Нямаагийн Энхболд гишүүн үг одоо хэлнэ.

Н.Энхболд: (14-р тойрог, Төв аймаг)

Баярлалаа. Л.Энх-Амгалан сайд аа, дэмжиж байна гэж хэлэх гэсэн юм. Хуулийг чинь дэмжиж байна.

Хоёрхон зүйлийг манайхан ер нь анхаармаар байна. Бараг сая Д.Тогтохсүрэн гишүүний хэлсэнтэй санаа давхцаж байгаа юм.

Бид энэ их бага хэмжээгээр ямар нэгэн хөрөнгө зарчхаад, эрдэмтдээрээ юм хийлгэхээд, тэгээд яг тэрийгээ амьдралд хэрэгжүүлэх тал дээр нь их дутагдалтай ажиллаад байгаа юм.

Их мөнгө чадахгүй байгаа л даа. Гэхдээ л сонсож байхад бага ч гэсэн хөрөнгөөр нэвтрүүлчхэж болмоор тийм нээлтүүд энэ тэр зөндөө олон хийчихсэн байдаг юм билээ шүү дээ. Тэгээд ерөөсөө тэрийг л амьдралд нэвтрүүлээд яваад эхэлбэл нэгдүгээрт эрдэмтдийн маань урам ч сэргэнэ, юм хийчихвэл үнэхээр ингээд.

Тэгэхгүй зүгээр нэг зэрэг хамгаалсан нэртэй. Тэгээд тэр нь хэрэглэгддэггүй. Тэгсхийгээд л байж байдаг. Үүнээс болж шинжлэх ухааны салбарынхны нэр хүндэд тодорхой хэмжээгээр муугаар нөлөөлдөг болов уу гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ хуульдаа ер нь цаашдынхаа практик ажилд хэний ажил яг практикт нэвтрээд үр дүнгүй байдаг тал дээр. Ялангуяа байгалийн шинжлэх ухааны

салбарын юмнууд. Тийм ээ. Хүмүүнлэгийнхээс бусад нь.

Хүмүүнлэгийн салбарынх дээр ч гэсэн янз бүрийн л юмнууд гардаг л даа. Тэгэхдээ үүнийг шийдвэр гаргагчдын түвшинд хүргэх тал дээр академи, бусад байгууллагууд өөрсдөө их идэвхтэй ажиллах ёстой юм билээ.

Хийсэн юмыг нь гишүүд, шийдвэр гаргадаг түвшний хүмүүс мэддэггүй шүү дээ. Мэддэггүй байхгүй юу. Баахан юмнууд судалж судалж Монгол Улсад ийм л хууль тохирох юм байна ч гэдэг юм уу, энэ асуудлаар ийм шийдвэр гарвал зөв юм байна гээд яг өөрийн орны онцлогт тохирчихсон тэр юмнууд гаргаад ирэхэд нөгөөдхийгөө яг тэр шийдвэр гаргаж байгаа хүмүүст хүргэж чаддаггүй. Эндээс ч нэг их хайгаад явдаггүй. Санамсаргүй тохиолдлоор заримдаа олж мэдэж уншина уу гэхээс.

Тэгэхээр энэ тал дээр яам, академи яг манайд тохирсон маш зөв судалгааны юм гарчихлаа гээд зориуд Засгийн газар, харьяалах агентлагууд, сайд нарт хүргэж байх тал дээр илүү их ажиллах ёстой юм билээ.

Түүнээс тэрүүхэн тэндээ үзчихээд л орхиод байвал тэгээд хайран хүний хөдөлмөр, хайран эрдэмтдийн бүтээл хэрэглэгдэхгүй яваад байдаг юм хавтгай харагддаг юм.

Хоёрдугаарт, манай шинжлэх ухааныхан янз бүрийн шинэ бүтээл гаргачихлаа гээд сонин сонин юм яриад яваад байдаг улсууд байдаг. Тухай бүрт нь хариулт өгч байх хэрэгтэй байна.

Урд өмнө нь гарч байсан янз бүрийн инээдтэй тохиолдлуудын тухай яриад яах вэ.

Мөнхийн хөдөлгүүр бүтээчихсэн юм шиг тийм юмнууд заримдаа ярих юм. Зарим хүмүүс. Багаахан эрчим хүчийг яагаад ч гэнэ вэ нэмээд нэмээд явсаар байгаад тэгээд ерөөсөө бараг цахилгаан станц хэрэггүй шахуу юм ярьдаг хүмүүс байна. Тийм ээ. Тийм байсан өдийд бүх асуудал шийдэгдчихсэн баймаар юм.

Хүмүүс эргэлзэхийнхээ хажуугаар ийм сайхан юм яриад байхад үүнийг нь хэрэглэдэггүй яасан засаг төр вэ, яасан шинжлэх ухааны байгууллагууд вэ энэ тэр гэсэн юм яриад. Энэ чинь өөрөө тодорхой хэмжээгээр хортой байхгүй юу.

Тэгээд логикоор бодоход жишээ нь 10 байсан юмыг 20 болгочихдог яг тэр логикоороо 20-ийг 40 болгоод, 40-ийг 80 болгоод ингэсээр байгаад тухайлбал цахилгаан дээр цахилгаан станц хэрэггүй шахуу л юм. Жоохон хүчин чадал байхад өсгөсөөр байгаад л хязгааргүй эрчим хүчтэй болчих юм шиг юм хүртэл ярих юм.

Тэгээд ийм ийм юмнууд дээр манай шинжлэх ухааны байгууллагууд, эрдэмтэд, уг нь байдаггүй л юм даа. Мөнхийн хөдөлгүүр гэж байсан өдийд гараад ирчихсэн л байх ёстой. Мөнхийн эрчим хүчний эх үүсвэр гэж байдаг аль хэдийн энэ хүн төрөлхтөн чинь хүрчихсэн л байх ийм хугацаа өнгөрчихлөө шүү дээ.

Тийм учраас ийм ийм учраас болдоггүй юм гэдгийг маш тийм энгийн ойлголтын түвшинд тайлбарлаж явах ёстой юм байна лээ. Энэ өөрөө би энэ шинжлэх ухааны байгууллагуудын нэг үндсэн үүргүүдийн нэг гэж бодож байна.

Буруу зөрүү, хуурамч нийгэмд, залуу үед тийм юм яриад байгаа зүйлүүд дээр яг үндэстэй тайлбарууд хийж байх

ёстой юм байна лээ шүү гэдэг энэ ташрамд хэлбэ. Ингээд дэмжиж байна. Хуулиудыг.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Дэмжсэн хоёр гишүүн үг хэлсэн. Одоо Д.Сарангэрэл гишүүн хэлэх юм уу? Д.Сарангэрэл гишүүн үг хэлбэ.

Д.Сарангэрэл: (29-р тойрог, Хан-Уул дүүрэг)

Ер нь сайдын гол үүрэг тухайн салбарынхаа бодлогыг Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд хэрэгжүүлэх байдаг.

Мөн тухайн салбарынхаа хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход үндсэн үүрэг нь чиглэж байдаг.

Энэ үүднээсээ би Боловсролын сайд Л.Энх-Амгалан энэ чиглэлд үнэхээр сайн ажиллаж байна. Боловсролын багц хууль. Одоо ингээд шинжлэх ухаан, технологийн хууль ороод ирлээ.

Үндсэндээ энэ салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагаа бараг ингээд өндөрлөж байгаа байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн асуудал, хууль эрх зүйн орчны өөрчлөлтийн асуудал нэлээн хоцрогдсон байсан. Манай С.Чинзориг сайд энэ чиглэлд тийм идэвхтэй нэлээн түрэмгий ажиллаж байгаа гэж би хоёр сайддаа. Сайн утгаараа шүү. Хаалтанд. Урам өгч хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт, миний гол хэлэх гэж байгаа зүйл бол 1990 оноос хойш Монголын эрдэмтэд 55 мянган шинжлэх ухааны бүтээл, бүтээгдэхүүн хийсэн байна.

Өнөөдөр энэ хүмүүсийн үйл ажиллагаанууд олон нийтэд танил биш байна. Энэ хүмүүсээ алдаршуулах ийм ажиллагаа нэлээн орхигдож байгаа учраас энэ хуулийн төсөлд ажлын хэсгийн түвшинд Та нар зарим нэг заалтуудыг би бодох ёстой гэж бодож байгаа.

Түрүүн би Та бүхний өгсөн танилцуулгаас үзэхэд өнөөдөр 1 сая хүнд 374 эрдэмтэн оногдож байгаа нь дэлхийн дунджаас 10-аас 30 дахин бага эрдэмтэнтэй Монгол Улс болсон байна гэдэг нь өөрөө хүүхэд, залуучууд энэ шинжлэх ухаанд шунах, шинжлэх ухаанаар ажиллах, хичээллэх ийм сонирхол их буурсан байна гэсэн үг л дээ.

Тэгэхээр хэрвээ бид энэ эрдэмтдийнхээ хийсэн бүтээлүүдийг, шинжлэх ухааны бүтээгдэхүүн, үйлчлэлийг олон нийтэд сурталчилдаг, алдаршуулдаг болох юм бол хүүхэд залуучуудыг энэ чиглэлд татах ийм боломж нь бүрдэх юм.

Тийм болохоор хуульд тодорхой заалт оруулах хэрэгтэй байх.

Нөгөө талаасаа манай эрдэмтдийн зүгээс Нобелийн шагнал авах хэмжээнд ажиллах ийм эрдэмтэд байгаа тухай мэдээллүүд явж л байдаг.

Дэмжлэг би хангалтгүй байна гэж бодоод байгаа учраас энэ хууль эрх зүйн орчинд энэ урам зоригийг нь нэмсэн, бодитоор дэмжсэн ийм заалтуудыг оруулах нь их зүйтэй гэж бодож байгаа юм.

Ингээд хуулийн төслийг бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Дэмжсэн гурван гишүүн үг хэллээ.

Их Хурлын гишүүд танхимдаа орёё. Байраа эзэлье. Санал хураалт явагдана. Гишүүдийг танхимд оруулаарай.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Баярлалаа. Би түрүүн нэг асуух асуулт дээр нэр өгсөн байсан юм.

Энэ хууль шинэчилсэн найруулгын төслөөр батлагдаад нэмэгдэл хөрөнгө санхүү шаардахгүй гэж байгаа юм.

Уг нь хамгийн их хөрөнгө санхүү энэ салбарт оруулах ёстой гэж ойлгодог.

Хэд хэдэн улс орнуудын шинжлэх ухаан, технологийн ийм төвүүдтэй бид танилцаж байсан л даа.

Тухайлах юм бол Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинжлэх ухаан, технологийн төв. Тийм ээ. Тэгээд Солонгос Улс чинь Солонгосын хойгийн дайны дараа энэ улс орноо сэргээн босгох, эдийн засгаа хөгжүүлэх, энэ улс орноо хөгжил дэвшилд хүргэхийн тулд ерөөсөө л шинжлэх ухаан дээр л суурилсан юм байна л даа.

Тэгээд гадаадад сурч байгаа Солонгос иргэд, эрдэмтэд, судлаачдыг эх орондоо уриад, тэгээд энэ шинжлэх ухаан, технологийн төвийг байгуулаад.

Тухайлах юм бол бусад их сургуулиудын шинжлэх ухааны хүрээлэнгүүдээс Сөүлийн их сургуулийн шинжлэх ухааны хүрээлэнгээс хоёроос гурав дахин өндөр цалин хангамжтай л энэ

төвийг ажиллуулсан тийм л жишээ юм билээ.

Бид танилцсан л даа. Ерөөсөө л хуулбар. Дэлхий нийтэд түгэн дэлгэрсэн тэр хамгийн сайн технологи, инновац, шинжлэх ухааны ололтыг л ерөөсөө л хуулбарлаад л хэрэглээд байсан.

Гэтэл өнөөдөр 30, 40 жилийн дараа 50, 60 жилийн дараа Солонгос Улс дэлхийд тэргүүлэгч, шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр ийм гайхамшигтай улс орон болж хөгжиж чадсан байна шүү дээ.

Тэгээд энэ талаас нь нэлээн сайн анхаарахгүй бол болохгүй болов уу гэсэн ийм юм байгаа юм.

Тэгээд хүмүүсийн ярьж байгаатай санал нэг байгаа л даа.

Энэ салбар дундын уялдаа, хамтын ажиллагаатай холбоотой юм их учир дутагдалтай байна гэж ойлгодог.

Ерөөсөө л энэ шинжлэх ухааны суурь судалгаа, шинжлэх ухааны бүтээл, яг шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн гаргасан дүгнэлт дээр л бодлого тодорхойлогдож байдаг. Төрийн бодлого ч ялгаа байхгүй хэрэгжиж байгаа ийм л жишиг байна шүү дээ.

Тэгээд би биеийн тамир, спортын салбар бол одоо ерөөсөө анагаахын шинжлэх ухааны төв нэртэй л байгаа юм. Зөвхөн спортын анагаах ухааны чиглэлээсээ л гээд.

Гэтэл спортын салбар чинь өөрөө бүхэл бүтэн спортын эрдэм шинжилгээний хүрээлэн гээд дэлхийн бүх улс орнуудад байна шүү дээ.

Одоо Унгар Улс гэхэд манайхаас төдийлөн хүн ам ойролцоо мөртөө олимпын их наадамд хамгийн олон алтан медалийг авдаг ийм улс орон байх жишээтэй.

Түүний уг үндэс нь юу байна гэхээр спортын шинжлэх ухаан дээр л тулгуурлаж байгаа ийм жишээ байгаа юм.

Тэгээд бид нарт энэ газар нутгийн онцлог байна.

Ер нь бүх талаас нь анхаарч үзээд Бүгд Найрамдах Солонгос Улсын Спортын шинжлэх ухааны хүрээлэнтэй хамтын ажиллагаа.

Одоо бид шинэ юм зохиох гээд байх хэрэгцээ шаардлага алга байна шүү дээ.

Яг энэ Солонгосын спортын шинжлэх ухааны хүрээлэнгийн тэр бүтэц, тогтолцоо, үйл ажиллагаа энэ юмтай л бид уялдуулаад л хийгээд өгөх ийм л зорилт тавиад нэлээн урагшаа ажиллаж байгаа юм.

Тэгээд Солонгост спортын төрийн бодлого гэхэд зөвхөн тэр Спортын шинжлэх ухааны хүрээлэнгийн гаргасан судалгаа, үндэслэл, дүгнэлт дээр л тулгуурлаж бодлого гардаг болохоос биш хэн нэгэн улс төрч, хэн нэгэн улс төрийн нам сонгуульд эрх барьснаар асуудал шийдэгддэггүй ийм л жишигтэй юм л даа.

Тэгэхээр тийм учраас энэ талаас нь их анхаарах, цаашдаа ийм шаардлага байна гэдэг энэ саналыг л би хэлэх гээд байгаа юм.

Тэгэхгүй бол ерөөсөө дур дураараа яваад байх.

Уг нь манай шинжлэх ухааны эрдэмтэд, энэ хүрээлэнгүүдийн хийж байгаа судалгаа, шинжилгээний ажил, энэ бүтээл үнэхээр үр дүнтэй сайн зүйлүүд хийдэг юм байна лээ л дээ.

Дахиад хэлэхэд энэ уялдаа, хамтын ажиллагаа гэдэг юм их сул байгаагаас болоод одоо бүр өөрийнх нь яамны дэргэдэх хүрээлэнгүүдийнхээ хийсэн бүр нарийвчилсан зүг чигийг нь заагаад өгсөн тэр судалгаан дээр ажиллаж чадахгүй байгаа ийм зүйлүүд байна шүү дээ.

Тэгээд эцэст нь хэлэхэд ерөөсөө одоо энэ Боловсролын яам. Сайд яриад байдаг. Гэтэл яг боловсролын яаманд байж байгаа улсууд нэлээн тийм хүнд сурталтай, тэр байгаа хүрэнээсээ гарч.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Их Хурлын гишүүд ээ, танхимдаа орж ирээрэй. Одоо удахгүй санал хураалт явагдана шүү.

Л.Энх-Амгалан сайд үг хэлэх юм уу? Балжиннямын Баярсайхан гишүүн Байнгын хороон дарга үг хэлье.

Б.Баярсайхан: (9-р тойрог, Завхан аймаг)

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг дэмжиж тал бүрээс нь ач холбогдлыг нь ярьж, асуулт асууж, дэмжиж байгаа гишүүддээ Байнгын хорооны даргын хувиас маш их талархаж байгаагаа илэрхийлье.

Бид олон жил улс орны хөгжлийн гол суурь нь шинжлэх ухааны манлайлал юм гэж ярьдаг боловч үүнийг өнөөдөр амьдрал дээр төдийлөн хэрэгжүүлж чадахгүй байгаа гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Сая гишүүд хөдөө аж ахуйн салбар, уул уурхайн салбарт шинжлэх ухааны ач холбогдлыг нэлээн түлхүү ярьж байна.

Тэгвэл эрүүл мэндийн салбарт өнөөдөр шинжлэх ухааны ололт амжилт ямар чухал ач холбогдолтой юм гэдгийг өнөөдөр бид халдварт бус өвчнөөр 4 мянгаас 5 мянган хүнээ жилд алдаж байгаа байдал.

Энэ хүнсний аюулгүй байдал алдагдаж байгаа байдал.

Өнөөдөр хоол хүнсээ бид гадаадаас импортолж байгаа байдал, малын тэжээлээ хүртэл тарьж чадахгүй байгаа байдал. Энэ асуудлууд дээр хүртэл шинжлэх ухаан хэрэгтэй юм гэдгийг бид ойлгох хэрэгтэй.

1990-2020 оны хооронд энэ 30 жилд улс орныг хөгжүүлэх 567 хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулагдаж байсан боловч дахиад л судалгаа, шинжилгээ, шинжлэх ухааныхаа салбарын эрдэмтэд, судлаачид дээрээ суурилагагүйн улмаас өнөөдөр бид ямар нийгэм байгуулчхаад байгаагаа бид харж болж байна.

Энэ хууль батлагдах юм бол гадаад дотоодод боловсрол эзэмшиж мэргэжсэн судлаач, эрдэмтэн залуучуудаа бусад улсад алдаж, энэ “брэйн дрэйн” буюу мэргэжилтэй боловсон хүчний дайжилт маш идэвхтэй тархаж байна гэдгийг олон улсын судалгаа харуулж байна.

Тэгэхээр энэ улс орны тархи болсон эрдэмтэй, мэдлэгтэй залуусаа тогтоохын тулд сайн цалинтай, таатай орчин, чөлөөтэйгөөр судалгаагаа хийх энэ орчин нөхцөлөөр бид бодитойгоор хангах ёстой.

Монголын их дээд сургуулийн чанар дэлхийд тийм муу биш.

Монголд сурч төгсөж байгаа залуучууд өнөөдөр дэлхийд тэргүүлэх маш олон мундаг тэргүүлэгч компаниудад ажил хөдөлмөрөө хийгээд явж байна. Үнэлэгдээд явж байна.

Мөн гадаадын их, дээд сургуулиудын удирдлагуудтай уулзаж байхад манай их, дээд сургуулиудтай хамтын ажиллагааг бий болгож судалгааны бааз хүртэл байгуулах саналыг нэлээн тавьж байдаг.

Тэгэхээр шинжлэх ухааныг хөгжүүлэхэд энэ судалгааны бааз, орчин нөхцөл маш чухал.

Тэгээд Л.Энх-Амгалан сайд яг бодитой миний олон дахин ярьж байгаа төсөв хөрөнгө шийдэгдэх энэ асуудал л өнөөдөр шинжлэх ухааны салбарыг урагшлуулах гол асуудал юм шүү гэдгийг ойлгож дараа дараагийн жилүүдэд энэ хууль батлагдсаны дараа 2025 оны төсөв, энэ болгон дээр бодитойгоор үр дүнгээ авах өгөх байх гэж бодож байна.

Сая салбарын сайд нэг зүйлийг хэллээ.

Боловсролынхоо салбарын ард нь байдаг шинжлэх ухаан. Миний Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байхад бүхэл бүтэн нийгмийн дөрвөн том салбарыг хамаарсан нэг яамтай байсан.

Өнөөдөр Монгол Улсад хоёр чухал асуудал зарим яамдын хавсарга хавчуургад явж байна.

Нэгдүгээрт, хүүхдийн асуудал. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлагт харьяалагддаг.

Шинжлэх ухааны асуудал. Нөгөө улс орны хөгжлөө манлайлах энэ салбар нь нэг салбарынхаа хавчуургад явж академи нэртэйгээр төсөв багатайгаар өнөөдөр ингээд явж байгаа нь бид статусын зэрэглэлийн хувьд хүртэл шинжлэх ухааны салбарын хүүхдийн асуудлыг хаана тавиад байгаа гэдгээ харж үүнийг ирэх жилд өөрчлөх нэн шаардлагатай байгаа гэдгийг хэлье.

Ингээд энэ хуулийг дэмжиж байгаа эрхэм гишүүддээ маш их баярлалаа.

Монгол Улсын шинжлэх ухааны салбарт өндөр үр дүн энэ хууль батлагдсаны дараа гарна гэж итгэж байна.

Энэ чуулганыг анхааралтай ажиглаж байгаа дэлхийн улс орнуудад тэргүүлэх том компанид ажиллаж байгаа монгол эрдэмтэн залуучууд маань Монгол Улсынхаа шинжлэх ухааны ололтод та нар маань хувь нэмрээ, өөр өөрсдийнхөө ажиллаж байгаа улс орноосоо оруулаарай. Эх орноо хараарай, дэмжээрэй гэдэг уриалгыг хэлж байна. Маш их баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гишүүд байраа эзэлье. Санал хураалт явагдана.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат үг хэлнэ. Үүний дараа санал хураалт явагдана.

Д.Ганбат: (3-р тойрог, Баянхонгор аймаг)

Энэ их л оройтож байгаа юм даа. Тийм. Их л оройтож баталж байна. Тэгээд ямар ч байсан шинжлэх ухааныг

оролцуулаад бас нэг ийм хууль батлагдаж байгаа нь яамай даа л гэж хэлье.

Тэгээд нэг хууль баталчхаад мартчихаж болохгүй.

Сүүлийн энэ отгон чуулганаар нэлээн хэдэн дэмжчихмээр хуулиуд орж ирж байна.

Уг нь Та нар 8 жилийн өмнө л батлаад явчихсан байсан бол одоо хэрэгжилтийг нь яриад, ийм юм хийчихлээ гээд байж байсан бол шал өөр байх байлаа.

Одоо тэгээд харь гаргаас ирсэн юм шиг хэдэн хүн цуглачхаад л, чухал чухал хуулиудыг нэлээн хурдтай маягаар батлаад. Нэр нь гоё харагдаад байдаг.

Ярьж байгаа юмнууд нь дорнын зүг рүүгээ байдаг юм уу.

Хятадууд чинь “та нар хэлэв ээ, би савхдав аа” гэдэг шиг л хоолны нэр хэлж хоосон савхдаж байгаа юм шиг л баахан хуулиуд эрийтэл гаргаад явчихдаг юм байна.

Өнөөдөр шинжлэх ухаангүйгээр хаашаа ч явахгүй. Энд тэндхийн удирдлагуудыг хараад байхад дандаа л нөгөө нийгмийн ухааныхан байгаа байхгүй юу.

Улс орон хөгжөөд байгаа энэ улс орнуудыг харахаар дандаа байгалийн шинжлэх ухааныхан түлхүү ажилладаг.

Харамсалтай нь өнөөдөр Монгол Улсын Их Сургуульд физикийн факультетаа бараг татан буулгах хэмжээнд оччихсон байна.

Тэнд орох хүүхдийн тоо багасчихсан байна гээд яриад байгаа байхгүй юу.

Тэр байгалийн шинжлэх ухаан буюу математик, физик, хими, биологи гэсэн 10, 20-хон жилийн өмнө, 30 жилийн өмнө суурь нь маш сайн байсан. Академик боловсрол олгодог байсан.

Түүний сүүлч нь манай эрдэмтэд мэргэд эх орондоо үлдчихсэн байж байна.

Сүүлийн үед төгссөн залуучууд маань бүгд гараад явчихсан.

Тэр **Microsoft**, **Apple** гэсэн компаниудад ажиллаж байгаа.

Тэгээд харамсалтай байгаа юм л даа. Тэгээд тэд нарыг татна гээд бас **“Зөгийн үүр”** гээд бусад улс орнуудаас хийж байсан туршлагыг хэрэгжүүлээд ажиллах гэж оролдсон. Ирээгүй байгаа.

Тэгэхээр тэрийг яаж шийдэх юм.

Математикийн хувьд бид чинь дунд сургууль, энэ боловсролоор маш их хоцрогдсон байна шүү дээ.

Уг нь 20, 30 жилийн өмнө эхэнд нь явдаг байсан байхгүй юу.

Цөөн хэдэн элит сургуулийн хүүхдүүд л математикийн олимпиадад гадагшаа дотогшоо яваад байр эзлээд байна.

Тэрний үр дүн тэр 90-ээд оны өмнө бэлтгэгдсэн, 80, 90 онд сүүлд нь хэдэн багш нар бэлдсэн. Түүний л үр дүн байх гэж бодож байгаа.

Тэгэхээр математикийн багш нарын цалин, их сургуулийн байгалийн шинжлэх

ухаан дээр байгаа багш нарын цалин, санхүүжилт, Шинжлэх ухааны академийн эрдэмтдийн цалин мөнгө, асуудлыг нь хангалттай шийдэж өгөх хэрэгтэй.

Үүнээс гадна тэр ажиллах орчин, тэрний санхүүжилтийг нь, мөн залуу эрдэмтдээ дэмжих талаар сүүлийн үед нэг жоохон зүйл ярьдаг байсан.

Ерөнхийлөгчийн зүгээс **“Залуу эрдэмтдийн шагнал”** гэж байсан. Тэр чухам юу болж байна вэ.

Зүгээр нэг баярын бичиг юм уу, нэг тиймэрхүү зүйлээр шагначих биш амьдрал ахуйд нь хэрэгтэй, ажиллах нөхцөл боломжийг нь хангасан тэр лабораториудыг нь шийдэж өгөх хэрэгтэй. Орчныг нь шийдэж өгөх хэрэгтэй.

Орон сууцны боломжийг нь, ар гэртээ санаа зовохгүйгээр ингэж ажиллуулах хэрэгтэй.

Тэгэхгүй бол одоо бас 2014, 2015 онд баахан залуучуудыг бид урьж авчраад л ажиллуулаад л тэгээд дараа нь юу ч биш болгоод л ингээд үлдсэн.

Бодлого бол тууштай байх хэрэгтэй шүү.

Ардчилсан нам ялаад гарчихвал мэдээжийн хэрэг, шинжлэх ухаан, инновацыг маш их дэмждэг л дээ.

Шууд л 2024, 2025 оноос бид энэ хуульд илүү сайн өөрчлөлт оруулаад дэмжээд явчихна.

Та нар шиг тэгээд 8 жил өнгөрсний дараа бас л энэ хэдэн эрдэмтдээ шилний цаанаас мөсөн чихэр, мөхөөлдөс олгож байгаа юм шиг ээлжит ийм юмаа хийж

байгаа нөхдүүд шүү гэдгийг би онцлон анхааруулъя.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны саналаар Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн дэмжсэн санал өгсөн болно.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг

дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийнхаа асуудалд орно. **12:25**

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулья.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: (10-р тойрог, Өвөрхангай аймаг)

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Л.Мөнхбаатар, Г.Тэмүүлэн нараас 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн

байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 54 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр төслийг чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээ байгуулан ажилласан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын албан ёсны цахим сайт, **D-Parliament.mn**-ээр дамжуулан иргэнээс ирүүлсэн нэг санал, ажлын хэсгийн гишүүн Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ж.Сүхбаатар нараас болон Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Жендэрийн үндэсний хорооноос ирүүлсэн саналуудыг үндэслэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын бэлтгэсэн болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгээ явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, нам, эвслийн бүлэг байгуулах, гишүүдийн тоог тогтоох, яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш 2 жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа эрүүгийн хэрэгтэй холбогдсон асуудлаар хянан шалгах түр хороо байгуулахгүй байх, мөн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаар болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах зэрэг нийт 18 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурал дахь намын бүлгийн даргыг тухайн намын бүлгийн гишүүдийн олонхын саналаар сонгох, бүлгийн ажлын алба нь бүлгийн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажилладаг байх зэрэг зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.19 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа төслийн 44 дүгээр зүйлд 44.1.16-д гишүүний бүрэн эрхийн хугацаандаа иргэд, сонгогчдод тайлангаас бусад эд зүйл тараах, аливаа

хэлбэрээр ял хэлбэрээр үнэ төлбөргүй үе үзүүлэх зэрэг үйлдэл, үйл ажиллагаа хийхгүй байх заалт нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй цөөнх болсон.

Байнгын хороо ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Тогтохсүрэн даргад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд дарга Маамбаагийн Үнэнбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын дарга Бямбадоржийн Болдбаатар, Улсын Их Хурлын Тамгын

газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Ганхуягийн Агар-Эрдэнэ нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. 24 санал байна.

Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг асуулт асууя.

С.Чинзориг: (10-р тойрог, Өвөрхангай аймаг)

Тэгэхээр ажлын хэсгээс нэг зүйл тодруулья.

Одоо орж ирж байгаа энэ Улсын Их Хурлын тухай хууль, дэгийн тулах тухай хуулиудаар чинь Их Хурлын гишүүдийн үг хэлэх асуудал чинь жаахан хязгаартай болж байгаа л даа. Болж байна л даа.

Тэгээд энэ чинь нөгөө намын бүлгүүдэд нь цаг оноогоод, бүлгүүд нь тухайн хэлэлцэж байгаа асуудлуудаар хэн, ямар гишүүнээр үг хэлүүлэх вэ гэдэг чинь ингээд бүлэг рүү шилжиж байгаа юм шиг ийм зохицуулалт орж байгаа.

Би үүнийг гайхаад байгаа юм.

Одоо Үндсэн хуулиараа Улсын Их Хурлын гишүүн чинь хэдийгээр нэг тойргоос сонгогдож байгаа ч гэсэн Үндсэн хуулийн заалтаар “ард түмний элч мөн” гэсэн Үндсэн хуулийн заалттай.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүн “нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж ажиллана” гэсэн үндсэн хуулийн заалттай шүү дээ.

Тэгэхээр үг хэлэх асуудлыг нь хязгаарлаад, бүлгийн зөвшөөрөл авч байж тухайн асуудлаар үг хэлэх ийм юм руу орчихоор чинь Үндсэн хуулиар гишүүнд олгогдсон “нийт ард түмний элч мөн”, “нийт, ард иргэн, улсын эрх ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэсэн энэ Үндсэн хуулийн заалттай зөрчилдөхгүй юу?

Энэ утгаараа Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа аливаа асуудлаар иргэдийн төлөөллийг, төрийн эрхийг барих эрхийг нь төлөөлөн хэрэгжүүлж байгаа хүний хувьд өөрийнхөө байр суурийг илэрхийлэх, нийт ард түмний эрх ашгийг хамгаалах ийм асуудлууд бий шүү дээ.

Тэгэхээр бүлэг тухайн асуудлаар нэр өгвөл үг хэлдэг, бүлгээс нэр өгөхгүй бол үг хэлэхгүй. Ингээд Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хязгаарлаж байна гэж.

Улсын Их Хурлын гишүүн “ард түмний элч мөн”, “нийт иргэн, улсын эрх ашиг сонирхлыг дээдлэн эрхэмлэн баримтална” гэсэн энэ Үндсэн хуулийн заалттай зөрчилдөх юм биш үү?

Би энэ дээр жаахан өөр байр суурьтай байгаа юм.

Аливаа хэлэлцэж байгаа асуудлаар улс орны эрх ашгийн үүднээс, ард түмний эрх ашгийн үүднээс байр суурь чөлөөтэй илэрхийлж байх энэ зарчим нь би Үндсэн хуулийнхаа суурь агуулга зарчимтайгаа нийцнэ гэж үзэж байгаа юм.

Тэгээд үүнийг манай ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо юу гэж үзэж байгаа юм?

Улсын Их Хурлын гишүүний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нэлээн хязгаарлаж байна л гэсэн асуудал руу орчхож байгаа юм биш үү гэж би бодоод байгаа юм.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Их Хурлын гишүүд байраа эзэлье. Одоо санал хураалт явагдана. Нийтдээ 24 санал хураалт явагдана.

Асуултад хариулья. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, хууль санаачлагч Нямаагийн Энхболд дарга хариулья.

Н.Энхболд: (14-р тойрог, Төв аймаг)

Ажлын хэсэг дээр хөндөөгүй юм байна лээ.

Тийм учраас хууль санаачлагчийн хувьд хариулья.

Тийм. Бид бүх асуудлуудыг хооронд нь уялдаа холбоотой л авч үзэх хэрэгтэй байгаа юм л даа.

Яагаад бид Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулав, яагаад Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулав, яагаад намуудын хуульд өөрчлөлт оруулав гэдгийг бүгдийг нь логик дэс дарааллаар нь бодож үзэх хэрэгтэй байгаа юм.

Үндсэн хуульд Улсын Их Хурлын гишүүдийн үүргээс гадна намуудын үүрэг хариуцлага, Намуудын тухай хуульд намууд төрийн тогтолцоог бий болгох, шийдвэр гаргахад ямар үүрэгтэй оролцож байх юм бэ гэдгийг заачихсан. Үндсэн хуулийнхаа хүрээнд ийм заалтууд байж байгаа. Нэгдүгээрт.

Энэ хүрээндээ асуудлыг бодолцож үзсэн юм. Тэгээд жишээ нь бүлэг дээрээ гишүүд бүгдээрээ чөлөөтэй ярих эрхтэй. Бүлэг дээрээ.

Үндсэн хууль тодорхойлохдоо намыг улсын хэмжээнд бодлого явуулдаг, эв санаагаараа нэгдсэн ийм хүмүүсийн нэгдэл гээд заачихсан.

Нам л юм бол мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, түүнийгээ хэрэгжүүлэх арга замын талаар нэгдмэл байр суурьтай хүмүүсийн нэгдлээ гээд заачихсан байгаа учраас түүнийг нэгдүгээрт бодох хэрэгтэй.

Нам дээрээ ямар ч асуудлыг хэдэн ч цаг чөлөөтэй ярих намынхаа бүлэг дээр ийм бололцоо нь байж байгаа.

Хоёрдугаарт, Байнгын хороон дээр энэ хязгаарлалт ерөөсөө ороогүй.

Бүгдээрээ чөлөөтэй байр сууриа илэрхийлж ярьж болно. Яг одоогийнх шигээ.

Тэгээд нэгэнт бодлого боловсруулдаг бүтцийнхээ хэмжээнд, тэгээд Байнгын хороон дээрээ бүгд чөлөөтэй ярьчхаад гараад ирсэн асуудлуудаар чуулган дээр үг хэлцгээнэ.

Чуулган дээр үг хэлэхдээ бас бүгдийг нь хязгаарлачхаагүй. Төсөв, Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилт, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, төсвийн сахилга бат, үндсэн чиглэл гэх мэтчилэн дөрөв, таван асуудлаар бүгдээрээ чөлөөтэй ярих эрх нь байгаа.

Энд ард түмний илч байх, байр сууриа чөлөөтэй илэрхийлэх, үгээ чөлөөтэй хэлэх энэ эрхүүд нь байгаа.

Гол нь олон хүнтэй болчихоор бүгдээрээ үг хэлэхэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа хэтэрхий сунжрах болов уу, цаг их авах болов уу гэдэг үүднээс.

Тэгээд ер нь аливаа асуудал бодлогын хүрээнд л яригдаж байх нь зүйтэй шүү дээ гэдэг.

Энэ зөвхөн Монголд биш бусад бусад бүх парламентад мөрдөгддөг ийм зарчмын дагуу л энэ хуулийн төслийг хийсэн.

Бүлэг дээрээ ярьж байгаад санал онолоо нэгтгэчихвэл түүнийгээ хэн нь илэрхийлж ярих вэ гэдгээ бүлэг дээрээ тохироод л явж байх.

Түүний цаана гишүүн болгоны санал ямар нэгэн байдлаар тусгагдчихсан гэж үзэж.

Дээр нь Байнгын хороон дээр яригдсан учраас Байнгын хороон дээрээ мэргэшсэн Байнгын хорооныхоо хуралдаанд оролцоод гишүүн болгон байр сууриа илэрхийлсэн.

Тэр нь бас тодорхой хэмжээгээр тусгагдсан байгаа гэж үзээд ийм зохицуулалтуудыг оруулсан юм.

Түүнээс Үндсэн хууль зөрчсөн асуудал байхгүй байх гэж бодож байна. Үндсэн хууль дээр хүн болгон заавал үгээ хэлж байх ёстой гэсэн үг байхгүй л дээ.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ бүлгээрээ, Байнгын хороогоороо дамжуулаад аль болохоор бодлогын хүрээнд зангидсан эмхтэй цэгцтэй, тооцоотой судалгаатай. Нэг хүний бодол биш бүтцийн, мэргэжлийн байгууллагын санаа оноо тусгасан.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя.

С.Чинзориг: (10-р тойрог, Өвөрхангай аймаг)

“Төрийн эрх ард түмний мэдэлд байна” гэсэн Үндсэн хуулийн заалттай. Ард түмэн Үндсэн хуулиар өөрт төрийн эрх барих энэ үндсэн онцгой эрхээ өөрийн сонгосон Улсын Их Хурлын гишүүнээрээ төлөөлүүлэн төрийн эрх барьж байгаа.

Тэгэхээр тэр иргэдийн сонгох Үндсэн хуулиар олгогдсон төрийн эрх барих онцгой эрхийг нь хэрэгжүүлж байгаа.

Улсын Их Хурлын гишүүн ард иргэдээ хамгаалж өөрийнхөө байр суурийг чөлөөтэй илэрхийлж байх Үндсэн хуулийн заалтыг нь зарчмыг нь би хадгалж өгөх ёстой л гэж бодож байна.

Бид “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал” гэж их ярьдаг шүү дээ.

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал” гэдэг бол харин энэ ард түмнээ төлөөлж өөрийнхөө байр суурийг чөлөөтэй илэрхийлж байх, ард түмнийхээ дуу хоолойг төрд хүргэж байх ёстой.

Энэ нь харин тэр халдашгүй байдал гэж би тэгж боддог.

Тэгэхээр үүнийг нь нэлээн хумьчхаад байгаа юм байна гэж л би бодоод байна л даа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Их Хурлын гишүүд танхимдаа орж ирж байраа эзэлье. Санал хураалт явагдана.

С.Чинзориг гишүүний саяын хэлсэн дэгтэй холбоотой асуудал дээр нэмж хэлэхэд одоогийн Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороодын явж байгаа хэлэлцүүлэг бол бас үр дүнгүй, нөгөөтээгүүр их сунжирсан байдалтай.

Байнгын хороо, чуулган дээр гишүүдийн асууж байгаа асуулт ихэнх нь танин мэдэхүйн шинж чанартай асуултууд их байдаг.

Байнгын хороонд асуусан асуултаа чуулганы танхимд ирээд чуулганы хуралдаан дээрээ мөн адил давтаж асуудаг. Аль эсвэл хэлэлцүүлгийн явцад байхгүй байж байгаад бүх асуултуудад хариултууд аль хэдийнээ явагдчихсан байхад дахиж асуугаад байдаг гээд ийм зүйлүүд байгаа юм.

Ийм учраас Байнгын хороо, чуулганы хуралдааныг илүү ажил хэрэгч болгох шаардлага байгаа. Энэ үүднээс энэ зүйлүүдийг оруулсан байгаа.

Ер нь мэргэжлийнхээ Байнгын хороон дээр илүү түшиглэж ажиллах, парламентын мэтгэлцээнийг тэнд илүү түлхүү явуулдаг.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр илүү бодлогын баримт бичиг ярьдаг, бодлогоо ярьдаг.

Намууд, бүлгүүдийн байр сууриудыг илэрхийлдэг ийм байх нь зүйтэй гэж үзсэн.

Гэхдээ Улсын Их Хурлын гишүүд тодорхой төсөв, санхүү, хөгжлийн бодлогын баримт бичиг гээд олон асуудлуудаар чуулганы нэгдсэн хуралдаанд бүгд үг хэлэх эрх нь нээлттэй байгаа.

Ийм зохицуулалт байгаа гэдгийг нэмж хэлье.

Их Хурлын гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт явагдана.

Улсын Их Хурлын гишүүд санал хураалтдаа оролцъё.

Монгол Ардын намын бүлэг, Ардчилсан намын бүлэг ирцээ бүрдүүлнэ. Гишүүд байраа эзэлье.

Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцох байгаа.

Энэ үндсэн үүргээ биелүүлэхгүй байгаа гишүүдийн нэрсийг аваад ирээрэй. Тамгын газрынхан.

Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцохгүй байгаа гишүүдийг тойргоор нь зарлана.

Өнөөдөр хуралдаанд оролцсон боловч санал хураалтад оролцохгүй байгаа гишүүдийн нэрсийг аваад ир.

Ер нь сүүлийн судалгаагаар Улсын Их Хурлын чуулганыхаа хуралдаанд оролцдог гишүүнийг л дахин сонгоно гэсэн байна лээ шүү дээ.

Хуралдаандаа суудаггүй гишүүдийг дахин сонгохгүй юм байна лээ шүү.

Чуулганы нэгдсэн хуралдаанд байнга оролцож байгаа, идэвхтэй оролцдог гишүүдийг нэрсийг нь хэлнэ.

Гэхдээ эхлээд ирэхгүй байгаа нөхдүүдийг зарлая. Их Хурлын гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт байгаа.

Өнөөдөр чинь нийтдээ 18 асуудал хэлэлцэнэ. Олон асуудал байгаа.

Санал хураалтыг түр хойшлууллаа.

Дараагийнхаа асуудалд орно. **12:48**

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн
2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Д.Тогтохсүрэн танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: (10-р тойрог, Өвөрхангай аймаг)

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Л.Мөнхбаатар, Г.Тэмүүлэн нараас 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 54 дүгээр захирамжаар дээрх хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын хэсэг 2, ажлын дэд хэсэг 4 удаа тус тус хуралдлаа.

Тус Байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл өргөн

мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлэх, хуулийн төсөл баталснаар улсын төсвийн орлого, хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах, Төрийн байгуулалтын байнгын хороо Төрийн албан дахь жендэрийн тэгш байдлын төлөв байдлын талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг 2 жил тутам хэлэлцэх, Төсвийн байнгын хороо хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг жил бүр хэлэлцэх зэрэг хуулийн төслийн талаар 19, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан 1, найруулгын 3, нийт 23 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төслийн 9 дүгээр зүйлд Улсын Их Хурлын гишүүн тойрогт ажиллаж, иргэдийн гаргасан санал, хүсэлт, гомдлын талаар 4 минутаар 2-оос доошгүй удаа нэгдсэн хуралдаанд үг хэлж болох ба Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэлээ бичгээр ирүүлнэ гэсэн 9.18 дахь хэсэг нэмэх санал гаргасны Байнгын хорооны хуралдаант гишүүдийн олонх дэмжээгүй тул цөөнх болсон.

Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт аваагүй болно.

Байнгын хороо ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Тогтохсүрэн даргад баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналууд байгаа.

Санал хураалтыг дэгийн тухай хуулийн 14.12-т заасны дагуу 14.00 цагаас явуулна.

Дараагийнхаа асуудалд оръё. [12:53](#)

**Тав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн
2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Д.Тогтохсүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: (10-р тойрог, Өвөрхангай аймаг)

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Л.Мөнхбаатар, Г.Тэмүүлэн нараас 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 04 дүгээр сарын 11, 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 54 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн

Д.Тогтохсүрэнгээр ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр төслийг чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Улсын Их Хуралд ирүүлдэг тайлан илтгэл, мэдээллийн хамрах хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц үр дүнгийн талаарх болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг сонсдог байхаар.

Мөн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн Хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй байх, хянан шалгах түр хорооны

бүрэлдэхүүнд ажилладаг гишүүдийн тоог шинээр тогтоох зэрэг нийт 9 зарчмын зөрүүтэй санал болон найруулгын 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлээгүй болно.

Байнгын хороо ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал,

дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Тогтохсүрэн даргад баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураах ёстой.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.12-т заасны дагуу 14.00 цагаас санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна.

Чуулганы үдээс өмнөх хуралдаан өндөрлөж байна. Түр завсарлууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 14.00 цагаас үргэлжилнэ. /алх цохив/ **12:55**

ЗАВСАРЛАГА

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн
2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/ (үргэлжлэл)

Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн амрыг эрье.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлж байна. /алх цохив/

Гишүүд чуулганы хуралдааны танхимд ирж санал хураалтдаа оролцъё.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүд бүгд оролцох үүрэгтэй.

Энэ үүргээ биелүүлж оролцох шаардлагатай байна гэдгийг хэлье.

Ирээгүй байгаа гишүүдийн нэрсийг нь дуудъя.

Улсын Их Хурлын эрхэм гишүүн Норовын Алтанхуяг, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Хавдисламын Баделхан хуралдаа ирнэ үү.

Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Наянтайн Ганибал, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Цэдэвийн Сэргэлэн, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Ж.Батсуурь, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Хаягаагийн Болорчулуун, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Хассуурийн Ганхуяг, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Ц.Сандаг-Очир гишүүн орж ирье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Даваажанцангийн Сарангэрэл, Улсын Их Хурлын эрхэм гишүүн П.Анужин, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Батсүхийн Саранчимэг, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Т.Аубакир, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Ж.Чинбүрэн нар хуралдаан орж ирье.

Эрхэм гишүүд Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаандаа оролцохыг шаардаж байна.

Монгол Ардын намын бүлэг, Ардчилсан намын бүлэг ирцээ бүрдүүлье.

Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Пүрэвдорж ирцээ бүрдүүлье. Одоогийн байдлаар 10 хувьтай байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй 24 санал байгаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

4.5.Улсын Их Хурал тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас, шагналтай байна.

4.6.Улсын Их Хурлын оноосон нэртэй адил утга, агуулгатайгаар нэр, нэрийн товчлолыг зөвшөөрөлгүй ашиглахыг хориглоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар. Ажлын хэсэг гэнэ.

Санал хураалт явуулъя. Гишүүд байраа эзэлье.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг хуралдаа ирж оролцоно уу.

Улсын Их Хурлын эрхэм гишүүн Х.Баделхан гишүүн хуралдаа ирж оролцох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен хуралдаан оролцъё.

Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал чуулганыхаа нэгдсэн хуралдаанд оролцохыг шаардаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Ж.Батсуурь, Хассуурийн Ганхуяг, Ц.Сандаг-Очир, Г.Амартүвшин, Д.Сарангэрэл, П.Анужин, Дамдины Цогтбаатар, Балжиннямын Баярсайхан, Дашдондогийн Ганбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Ж.Чинбүрэн нар хуралдаа оролцох хэрэгтэй байна.

Чуулганы нэгдсэн хуралдааныг эдгээр гишүүд таслаад байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг хэвийн явуулах, зохион байгуулах ажлыг саатуулаад байгаа учраас эдгээр гишүүд яаралтай хуралдааны танхимд орж ирье.

Саналын томъёололыг уншиж танилцуулсан. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.8 дахь хэсэг нэмэх:

“4.8.Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “хэлэлцэх нийт хугацааг тогтоох” гэснийг “хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоох” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.25 дахь хэсгийн “үл хүндэтгэсэн үйлдэл гэж үзнэ.” гэснийг “үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалтын “бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг” гэснийг өмнө “халдашгүй байдал,” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.12 дахь хэсэг нэмэх:

“27.12.Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “хянан шалгагч томилох, бичиг баримтад дүн шинжилгээ хийх зэрэг” гэснийг “хянан шалгагч, шинжээч томилох, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, гэрчээс мэдүүлэг авах зэрэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 28 дугаар зүйлийн 28.5.3 дахь заалтын “яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар” гэснийг “яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 28 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 28.6, 28.11 дэх хэсэг нэмэх:

“28.6.Тухайн ээлжит чуулганы хугацаанд хоёр хүртэл хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хянан шалгах түр хороо байгуулах саналыг дараагийн ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэнэ.

28.11.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.4, 29.13 дахь хэсгийн “12” гэснийг “10” гэж, мөн зүйлийн 29.4, 29.9 дэх хэсгийн “12-оос” гэснийг “10-аас” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.3.Бүлэг даргаа гишүүдийн олонхын саналаар сонгож, бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрийн жагсаалтыг бүлгийн дарга Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлгийн эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “Бүлэг” гэсний дараа “бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаандаа” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 46 дугаар зүйлийн 46.5.4 дэх заалтын “Хууль тогтоомжийн тухай хуульд” гэсний өмнө “энэ хуулийн 36 дугаар зүйл,” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай хоёр дахь өгүүлбэр нэмэх:

“Энэ журам нь Төрийн албаны тухай хуулийн 54.2, 55.2-т заасан журмаар зохицуулах харилцаанд хамаарахгүй.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

Нийтдээ 50 гаруй санал байгаа гэдгийг бас гишүүдэд хэлье.

Найруулгын санал.

1.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.9, 24.10 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн “зардлыг” гэсний өмнө “үйл ажиллагааны” гэж, 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсгийн “ба” гэсний дараа “түүнээс” гэж тус тус нэмж, 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “зардлыг санхүүжүүлнэ.” гэснийг “үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулна.” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “зааснаас” гэснийг “заасны дагуу томилогдсоноос” гэж, 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийн “хууль тогтоомжийн” гэснийг “хуулийн” гэж, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийн “Энэ зүйлд” гэснийг “Энэ хуулийн 36 дугаар зүйлд” гэж, 44 дүгээр зүйлийн 44.4.1.6 дахь заалтын “кампанит ажилд” гэснийг “сурталчилгаанд” гэж, 46 дугаар зүйлийн 46.5.17 дахь заалтын “мэдээллийн сан бүрдүүлж гишүүдэд үйлчлэх” гэснийг “мэдээллийн сан бүрдүүлэх” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “тогтоох асуудлыг” гэснийг хасах.

3.Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын болон тэдгээрт авсан эшлэлийн дугаарлалтыг өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал байна.

1.Төслийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.1.16 дахь заалт нэмэх:

“44.1.16.гишүүн нь бүрэн эрхийн хугацаандаа иргэд, сонгогчдод тайлангаас бусад эд зүйлс тараах, аливаа хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлдэл, үйл ажиллагаа хийхгүй байх.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулья.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “тус тус өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁶.2-т” гэснийг “Монгол Улсын Их Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52.2-т” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасаж, төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2 дугаар зүйл” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал.

1.“Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дэх заалтын “-ийг энэ тогтоолын” гэснийг “гэснийг “Улсын Их Хурлын гишүүний тойрогт ажиллах унааны лимит” гэж өөрчлөн энэ тогтоолын” гэж, төслийн 2 дахь заалтын “28 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 2, 3, 4, 5 дахь” гэснийг “28 дугаар тогтоолын 1 дэх заалтын 1, 2, 3, 4 дэх” гэж тус тус өөрчилж, уг тогтоолын 2 дугаар хавсралтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын “Улсын Их Хурлын гишүүний төсөв зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.2.4, 2.2-т “сонгогдсон тойрогтоо” гэснийг “тойрогт” гэж тус тус өөрчилж, мөн журмын 1.2.5-д “гэрээний үндсэн дээр ажиллуулах” гэснийг хасах.

2.Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн заалт, хавсралт болон тэдгээрт авсан эшлэлийн дугаарлалтыг өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийнхаа санал хураалтыг явуулна. [15:27](#)

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн
2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/ (үргэлжлэл)

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн зарчмын зөрүүтэй саналын томьёололыг явуулья.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “хэлэлцэх хугацааг” гэсний дараа “хэлэлцүүлгийн үе шат бүрээр” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.7.Гишүүн хуралдаанд байр сууриа илэрхийлж үг хэлэх /цаашид “үг хэлэх” гэх/ хугацаа 4 минутаас илүүгүй байна.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 17 дугаар зүйлийн 17.14 дэх хэсгийн “программ, эсхүл санал хураах хуудсаар явуулна.” гэснийг “программ ашиглан явуулна.” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

Хэн горимын санал гаргах вэ? Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ горимын санал гаргая.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Би горимын санал гаргаж байна. Энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хурааж өгөөч ээ гэсэн горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулья. Гишүүд ээ анхааралтай байгаарай. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Сая хүчингүйд тооцсон санал хураалт дэмжигдлээ.

Үндсэн саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийн “хуулийн” гэснийг “хууль, тогтоолын” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “зааснаас” гэснийг “заасан болон олон улсын гэрээ соёрхон батлахаас” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

51.3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсгийн “энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийн “Энэ хуулийн 37.1-д” гэснийг “Энэ хуулийн 37.1, 37.2, 37.3-т” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсгийн “тайлбарлаагүй” гэснийг “бичээгүй” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

59.0 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт. /алх цохив/

16.Төслийн 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

56.4 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 115 дугаар зүйлийн 115.2.6 дахь заалтын “жил бүр” гэсний дараа “, Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг 2 жил тутам” гэж нэмэх.

“115.4.Энэ хуулийн 115.2, 15.3-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулж, энэ хуулийн 115.2-т заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалт. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 115.2.18 дахь заалт нэмэх:

17.Төслийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“115.2.18.хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг Төсвийн байнгын хороо жил бүр”

“120.3.Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж болно.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

59.0 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 115 дугаар зүйлийн 115.3 дахь хэсгийн “тайланг” гэснийг “мэдээллийг” гэж өөрчлөх.

18.Төслийн 134 дүгээр зүйлийн 134.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

19.Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “хуралдаанд оруулж” гэсний дараа “, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар” гэж, 121 дүгээр зүйлийн 121.6 дахь хэсгийн “121.1-д” гэсний өмнө “энэ хуулийн” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “дуусахаас” гэснийг “хаахаас” гэж өөрчлөх, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “9.16-д” гэснийг “9.15-д” гэж, 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсгийн “буюу” гэснийг “, эсхүл” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “хоног” гэснийг “өдөр” гэж, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “53.1-д” гэснийг “52.1-д” гэж, 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсгийн “50.2-т” гэснийг “52.2-т” гэж, мөн зүйлийн 53.6 дахь хэсгийн “38, 39, 40, 41, 42, 43 дугаар” гэснийг “39, 40, 41, 42, 43, 44 дүгээр” гэж, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн “27 дугаар” гэснийг “28 дугаар” гэж, 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсгийн “90.2-т” гэснийг “95.2-т” гэж, мөн зүйлийн 95.9 дэх хэсгийн “95.7-д” гэснийг “95.8-д” гэж, 98 дугаар зүйлийн 98.4 дэх хэсгийн “86, 87” гэснийг “85, 86” гэж, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийн “26 дугаар” гэснийг “24 дүгээр” гэж, 117 дугаар зүйлийн 117.9 дэх хэсгийн

“120.6-д” гэснийг “117.6-д” гэж, 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсгийн “126.6-д” гэснийг “129.1-д” гэж, 123 дугаар зүйлийн 123.3 дахь хэсгийн “127.5-д” гэснийг “126.5-д” гэж, 127 дугаар зүйлийн 127.2 дахь хэсгийн “7 дугаар” гэснийг “17 дугаар” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “багтаан” гэснийг, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийн “, эцэслэн” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал байна.

1.Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.18 дахь хэсэг нэмэх:

“9.18.Улсын Их Хурлын гишүүн тойрогт ажиллаж иргэдийн гаргасан санал, хүсэлт, гомдлын талаар 4 минутаас 2-оос дээшгүй удаа нэгдсэн хуралдаанд үг хэлж болох ба Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэлээ бичиж ирүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Үг хэлэх үү? Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлье. Саналаа тайлбарлаж үг хэлье.

Б.Пүрэвдорж: (16-дугаар тойрог, Ховд аймаг)

Улсын Их Хурлын гишүүн улс орны бодлого тодорхойлж, хууль батлах үндсэн үүрэгтэй.

Тэгэхээр үүний хажуугаар хийх ёстой бас нэг гол үндсэн зүйл бол ард түмнийхээ дуу хоолой болох ёстой байгаа юм.

Тэгэхээр өнгөрсөн жил би 108 уулзалт хийсэн. Он гараад 80 гаруй уулзалт хийж байна. Энэ уулзалт болгон дээрээ ард иргэд надад өөрсдийнхөө асуудлаар саналуудаа тавьдаг.

Тэгээд шууд хууль тогтоол хийх боломжгүй зөндөө саналууд тавьдаг байхгүй юу. Гүйцэтгэх салбарт хийх ёстой, Засгийн газрын түвшинд хийх ёстой зөндөө асуудлуудыг тавьдаг.

Тэгээд энэ хүмүүсийн саналыг сонсоод жишээ нь өнгөрсөн оны зуны уулзалтаар багуудаар явж уулзалт хийж байхад багийн иргэд ийм ийм зүйлийг хиймээр байна гэдэг энэ саналыг тавьдаг. Тэгэхээр би таны энэ үгийг 10 сарын 05-ны өдрийн 10.05 минутад таны энэ саналыг хэлнэ.

Таны саналыг 10 сарын 06-ны өдрийн 10.05 минутад чуулганы эхэн дээр үг хэлнэ. Тэгээд сумынх нь нэр, багийнх нь нэр, овог, нэрийг нь хэлж ард иргэдийнхээ дуу хоолой болж ажилладаг л даа.

Энэ ажлыг маань одоо жишээ нь манай ээжийн ангийн шавь Монгол Улсын гавьяат эдийн засагч Дамба гуай. Одоо та бүхэн бүгдээрээ мэднэ. Манай Ховд аймгийн төр, нийгмийн нэр зүтгэлтэн ийм хүн байгаа. Танай Монгол Ардын намын гишүүн хүн байгаа.

Энэ хүн надад Б.Пүрэвдорж оо, энэ түмний дуу хоолой болно гэдэг чинь одоо Их Хурлын гишүүний хамгийн гол зүйл шүү гэдэг ийм зөвлөгөөг өгч байсан. Тэр зөвлөгөөний дагуу л би ажиллаж байгаа.

Тэгээд харамсалтай нь одоо ингээд миний эсрэг энэ дэгийн хуулиуд дандаа батлагддаг. 8 жилийн туршид миний эсрэг. Өөрөөр хэлбэл миний үг хэлэх тэр эрх чөлөөг, өөрөөр хэлбэл ард түмний дуу хоолой болох тэр зүйлийг маань хаах тэр ажлыг хийж байгаа.

Тэгээд янз янзын арга сэдээд л ингээд явж байгаа. Одоо энэ хуулиар чинь бид нар ерөөсөө ард түмний дуу хоолой болж чадахгүй юм байна.

Бид энэ иргэдийн зүгээр өдөр тутам болж байгаа тэр асуудал дээр үг хэлэх боломжгүй болж байгаа юм байна.

Бид тэр хүмүүсийн асуудлыг тавилаа гэхэд энд тэнд илгээх боломжгүй, заавал бүх хүний асуудлыг хууль болгож гаргана гэж байхгүй шүү дээ.

Тэгэхээр бидний гол зүйл чинь юу юм. Бид иргэдтэй уулзахаар тэд нарын дуу хоолой болж чадахгүй бол бид энд хууль тогтоох байгууллагад энд суухын хэрэг бараг байхгүй байгаа байхгүй юу даа.

Тийм учраас яг энэ дээр иргэдийн үгийг хүргэх ажил, түүгээрээ хууль тогтоох байгууллага түүгээрээ дамжуулан хамгийн том эрх мэдэлтэй байгууллагын хувьд гүйцэтгэх засаглал болон шүүх эрх мэдэл, бусад байгууллагуудад үгээ хэлэх тэр боломжийг нь нээж өгөх ёстой байхгүй юу. Бүх юмыг албан бичгээр явуулаад бас болохгүй байна шүү дээ.

Одоо ингээд жишээ нь юу байдаг юм бид уулын чоно мал идээд дуусаж байна. Тийм үү. Гэтэл энэ асуудлыг бид албан бичгээр явуулахаар нөгөө сайд нь ерөөсөө асуудал шийдэхгүй.

Тэгээд бид үүнийг чинь Их Хурал дээр хэлж байж, олон түмэнд хэлж байж

тэр шаардлагын үндсэн дээр тухайн гүйцэтгэх засаглалд шахалт үзүүлж байж л бид асуудлаа шийдэж байгаа шүү дээ.

Ийм байдлаар бид энэ иргэдийн дуу хоолой болох тэр үндсэн ажил маань байхгүй болчихоод байна. Тийм учраас яах вэ намайг ингээд үг хэлдэг гээд хаагаад байж болохгүй шүү дээ. Энэ чинь бас танай нам ч бас өөрсдөө яг энэ иргэдийн дуу хоолой болж ажиллах боломж нь бас байж байгаа шүү дээ.

Энэ тал дээр та нар нэг тийм хүмүүстэй ойрхон нягт харилцаатай байж тэр төрийн шийдвэр чинь зөв болно. Иргэдийн дуу хоолой, гаргаж байгаа тэр асуудлууд чинь бүгдээрээ зөв болно.

Бид амьд харилцаагүй баахан хууль гаргаад бид тэр нь үр дүнгүй болоод байна шүү дээ.

Тийм учраас энэ амьд харилцаан дээр үүсэж бий болсон тэр санал сэтгэгдлийг энэ төрийн бодлогод тусгах чинь бидний хамгийн том үүргүүдийн нэг байхгүй юу даа. Энэ ажил дээрээ хангалтгүй ажиллаад байна шүү дээ.

Энэ ажил дээрээ хангалтгүй ажиллаад байна шүү дээ.

Ер нь Ж.Сүхбаатар гишүүн ч бас хэлж байсан. Ер нь Их Хурлын гишүүний хамгийн том ажил бол иргэдийн дуу хоолой болох л байхгүй юу даа. Энэ дээр та бүхэн дэмжиж өгөөч. Ж.Сүхбаатар гишүүн ээ, та бас дэмжиж өгөөрэй. Т.Доржханд гишүүн ээ, бас дэмжиж өгөөрэй.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан.

Санал хураалт. /алх цохив/

Хэн гаргаж байгаа юм? Горимын санал.

Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан горимын санал гаргая.

Б.Баярсайхан: (9-р тойрог, Завхан аймаг)

Миний төхөөрөмж ажилласангүй. Саналыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханы гаргасан горимын саналаар уг саналыг хүчингүйд тооцох санал хураалт явуулья. /алх цохив/

Гишүүд ээ, анхааралтай саналаа өг.

Уг саналыг хүчингүйд тооцох санал хураалт шүү дээ. Энэ чинь.

Б.Баярсайхан гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалтыг явуулна.

126 гишүүн 4 минутаар нэгдсэн чуулганд 2-оос доошгүй гэхээр чинь ямар агуулга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоожийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 41.4 дэх хэсгийн “шаардлагатай гэж үзвэл” гэсний дараа “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу” гэж нэмж, 4.6 дахь хэсгийн “багтаан” гэснийг хасах.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Дараагийнхаа асуудал оръё. [15:52](#)

Тав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн
2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/ (үргэлжлэл)

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Санал хураалтдаа орно. Танилцуулга хийгдсэн байгаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “байгуулалтын” гэсний дараа “болон энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтын “жил бүр” гэсний дараа “, төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг 2 жил тутам” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Үг хэлэх юм уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлбэ.

М.Оюунчимэг: (25-р тойрог, Чингэлтэй дүүрэг)

Би Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бас хэлсэн юм. Энэ их чухал.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байхдаа Хүний эрхийн тайланг бид заавал сонсож байх ёстой гээд одоо сонсдог болсноос хойш Хүний эрхийн комисс гэж байдаг юм байна гэдэг ойлголт бий болсон юм.

Одоо энэ дээр Төрийн албаны зөвлөлийн тайланг хоёр жил тутам сонсож байна гээд байгаа юм.

Сүүлийн үед төрийн албан дээр дарамт маш их болсон. Төрийн албан дахь сэтгэл ханамжийн судалгааг **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ын хүрээнд сая хурдасгуураас хийхэд маш ноцтой гэж хэлж болохоор дүгнэлт гарсан юм билээ.

Т.Доржханд гишүүн ээ, би үгээ хэлчихье. Тэгэх үү?

Бидний хамгийн гол санаа зовоож байгаа зүйл бол энэ захиргаа, төрийн албан дахь дарамт ажлаас гарах шалтгаан болж байна гэж судалгаанд оролцсон хүмүүсийн бараг 70 хувь нь хэлсэн байна.

Өөрөөр хэлбэл төрийн албанд ажил, амралтын зохистой харьцаа байхгүй болчихсон. Төрийн алба болон ер нь хувийн хэвшил дээр энэ жендэрийн эрх тэгш байдал, ажлын байран дахь дарамт асар их болсон нь өөрөө ажлаас гарах шалтгаан болж байна гэсэн судалгаа их хувьтай гараад байгаа юм.

Тийм учраас энэ тайланг хоёр жил биш бараг улирал тутам сонсож байх. Яг ийм асуудал гарвал хариуцлагыг нь тооцдог байх заалтыг нэлээд тодорхой оруулж өгөх хэрэгтэй байна.

Хамгийн сүүлийн жишээ **“Эмийн сонсгол”** дээр харахад **“шударга байсныхаа төлөө, өөрийнхөө үзэл бодлод үнэнч зогсож, хууль бус юманд гарын үсэг**

зурахгүй гэсний төлөө” “Өргөө” амаржих газрын дарга байсан эмэгтэй ажлаасаа халагдчихсан байх жишээтэй.

Эм, эмнэлгийн хэрэгслийн газрын дарга **“хууль бус, хугацаа нь дууссан оношлуурыг нийлүүлж болохгүй гэснийхээ төлөө” өнөөдөр бас ажилгүй явж байна.**

Харин хариуцлага тооцогдох ёстой хүн нь албан тушаал ахиад л яваад байдаг ийм шударга бус байдал төрийн албан дээр байж болохгүй.

Саяхан **филармони** дээр **“ажлын байран дахь дарамтаас болоод ийм байдал байна гээд шүүхэд болоод Хүний эрхийн зөвлөлд гомдол гаргасныхаа төлөө” тэр эмэгтэйд ажлаас нь халчихсан** байгаа байхгүй юу.

Нөгөө дарга нь, эрэгтэй дарга нь. Уг нь хариуцлага хүлээх ёстой дарга нь.

Энэ мэтчилэн ийм ноцтой зүйл гараад байхад бид нар одоо энэ хуулийг зүгээр л яаралтай батлах хэрэгтэй гээд яваад баймааргүй байна. Маш хариуцлагатай тусгаж өгөх хэрэгтэй байна.

Сая Б.Пүрэвдорж гишүүн хэлж байна л даа. Ард түмний дуу хоолой байх ёстой гээд. Би лав иргэдтэйгээ эргэх холбоотой маш хариуцлагатай ажилладаг. 120 гаруй уулзалтууд хийсэн. Сүүлийн үед яг яриад байгаа байхгүй юу.

Төрийн албан дээр, дүүрэг дээр, хороон дээр ч гэдэг юм уу ажил, амралтын зохистой харьцаа байхгүй болчихсон. Орой ч хамаагүй дууддаг. Хагас сайн, бүтэн сайнд ажилладаг.

Тэгээд тэр ажлын цалин, урамшуулал нь байдаггүй ч гэдэг юм уу,

эсвэл ажлын байран дахь энэ удирдлагын дарамт бол нэлээд их байна гэсэн судалгаа сая “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хурдасгуураас хийсэн судалгаагаар гарчихсан байна.

Тэгэхээр Н.Энхболд дарга аа, Төрийн албаны зөвлөлийн тайланг, Хүний эрхийн комиссын тайланг бид улирал бүр бараг. Эсвэл одоо хоёр улиралд нэг удаа сонсдог болохгүй бол нэг жил, хоёр жил гэдэг бол дэндүү урт хугацаа байна.

Сүүлийн үед яагаад төрийн албанаас хүмүүс их гарч байна, яагаад залуучууд гадагшаа гараад байна гэдэг нь цалин хөлстэй гэхээсээ илүүтэй ажлын байрны дарамт гэдгийг 69.0 хувь нь хэлсэн байна шүү дээ.

Хамгийн сүүлийн маш чухал судалгааг сая сэтгэл ханамжийн баталгаа гэсэн судалгаанаас харагдаад байгаа.

Тэгэхээр бид үүнийг л засах ёстой шүү дээ. Энэ хуулиудаараа. Үүнийг л бид тусгаж өгөх ёстой.

Тийм учраас ялангуяа үүнд хяналт тавих ёстой, энд судалгаа хийдэг энэ байгууллагуудын тайланг улирал тутам сонсдог байх хэрэгтэй байна. Хүний эрхийн Үндэсний Комисс, энэ Төрийн албаны зөвлөлийн гээд.

Н.Энхболд дарга аа, энэ дээр та нэг тайлбар өгөөч. Бид энэ дээр яах ёстой вэ? Хоёр жил гэдэг бол дэндүү урт хугацаа байна. Тийм.

Бид өмнө Хүний эрхийн комиссын асуудал дээр яг үр дүн гарсан юм. Л.Мөнхбаатар дарга аа.

Хүний эрхийн комиссын тайланг сонсдоггүй байхад Улсын Их Хурал дээр

сонсдог болсноос хойш энэ зөрчил нэлээд арилж байгаа. Тэгвэл одоо бид нар энэ тайланг ингэж сонсож баймаар байна.

Тэгэхээр би нэг санал гаргаад. Гишүүдээсээ. Юу гэсэн үг юм. Бид сая Төрийн албаны зөвлөл гэж байгуулчхаад хоёр жилд нэг удаа тайланг нь сонсох ямар ч их шаардлагагүй болно шүү дээ.

Ийм аймшигтай судалгаа гараад байна шүү дээ.

“Төрийн албан дахь сэтгэл ханамжийн баталгаа” гээд сая хамгийн сүүлд **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ын хүрээнд хийсэн судалгаагаар ийм юм гарсан байна шүү дээ.

Ихэнх залуучууд бид гадагшаа яваад байгаа нь энэ цалин хөлс гэсэн чинь ажлын байран дахь дарамт гэж байгаа байхгүй юу. Ажил, амралтын зохистой харьцаа байхгүй, илүү цагийн хөрөнгө мөнгө боддоггүй.

Дээрээс нь дарга, түшмэдүүдийн дарамт сүүлийн үед төрийн албанд ажиллахад хэцүү болж байна гэж бичиж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр бид тайланг нь хоёр жилд биш нэг жил ч юм уу, эсвэл улирал тутам сонсож байна. Сонсоод асуудал үүсвэл ийм хариуцлага тооцож байна гэдгийг нь тодорхой тусгаж өгөх хэрэгтэй байна.

Н.Энхболд дарга аа, та энэ дээр нэг хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Үг хэллээ. Асуулт, хариулт байхгүй. Дэгээрээ байхгүй учраас үг хэлсэнд тооцлоо.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

59.0 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн ард 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.18 дахь заалт нэмэх:

“15.1.18.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг жил бүр.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

64.1 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4, 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.3.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурлын хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор мэдээллийн нэгдсэн сан болон Улсын Их Хурлын цахим хуудаст нийтэлж, байршуулна.

15.4.Энэ хуулийн 15.1-д заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.

15.5.Байнгын хороо энэ хуулийн 15.1-д заасан тайлан, илтгэл, мэдээллийг энэ хуулийн 15.4-т заасан дүн шинжилгээ яаманд хэлэлцэн, шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн төсөл боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулна.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

64.1 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “7-31” гэснийг “7-15” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Б.Пүрэвдорж гишүүн хурал битгий үймүүлээд байгаарай.

Янз янзын санал гаргаад. Одоо Б.Пүрэвдорж гишүүний гаргасан, түрүүн дэмжүүлсэн санал бол ингэж байгаа шүү дээ.

126 гишүүн 4 минутаар 2-оос доошгүй гэж байгаа юм. Ингэх юм бол 1008 минут болно. 1008 минут гэдэг чинь 17 цаг байх. 17 цагийг ажлын өдрөөр тооцохоор 2-оос 3 өдөр нь Их Хурлын гишүүн тойрогтоо ажилласан тухай тайлан сонсох асуудал болох нь байна шүү дээ.

Ард иргэдийн санаа бодлыг яаж илэрхийлэх вэ гэхээр хууль, тогтоолын төсөл болгон өргөн барьж илэрхийлнэ. Бодлого болгож илэрхийлнэ. Түүнээс биш түүнийг дамжуулах бүрэлдэхүүн байж болохгүй гэдгийг манай гишүүд анхаарах нь зүйтэй.

6.Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.3 дахь хэсэг нэмж, 33.3, 33.4, 33.5, 33.6, 33.7 дахь хэсгийн дугаарыг 33.4, 33.5, 33.6, 33.7, 33.8 гэж өөрчлөх:

“33.3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргээ хавсран гүйцэтгэж байгаа гишүүн түр хорооны бүрэлдэхүүнд ажиллахгүй.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийг “Тайлбар” болгон доор дурдсанаар өөрчилж, 38.9, 38.10, 38.11, 38.12, 38.13, 38.14 дэх хэсгийн дугаарыг 38.8, 38.9, 38.10, 38.11, 38.12, 38.13 гэж өөрчлөх:

“Тайлбар: Энэ хэсэгт заасан “хүндэтгэн үзэх шалтгаан” гэдэгт хорио цээрийн дэглэм тогтоогдсон, гамшиг тохиолдсон, албан томилолттой байгаа, эрүүл мэндийн шалтгаантай, мэдэгдэх хуудас хүргүүлэхээс өмнө гадаад улсад байгаа зэрэг хувь хүнээс өөрөөс нь үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 38 дугаар зүйлийн 38.12 дахь хэсгийн “холбогдох төрийн байгууллага” гэснийг “төрийн болон нутгийн захиргааны холбогдох байгууллага” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

56.4 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “Хувь хүн нь” гэснийг “Шинжээч, хянан шалгагчийг сонгож авах,” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

64.1 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

1.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “төсвийн хяналт, шинжилгээний” гэсний өмнө “Тамгын газрын” гэж, төслийн 35 дугаар зүйлийн 35.7.5 дахь заалтыг “даргалах” гэсний дараа “, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах” гэж, төслийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “хадгалах” гэсний дараа “, сонгох” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн” гэснийг “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, /цаашид “хууль, тогтоомж” гэх/-ийн” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 12.6, 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн” гэснийг “хууль тогтоомжийн” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “бодлогын баримт бичгийн” гэснийг “бодлого, төлөвлөлтийн” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “Асуудал хариуцсан” гэснийг “Холбогдох” гэж, мөн хэсгийн “танилцуулж болно.” гэснийг “танилцуулна.” гэж, төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “энэ хуулийн 54.1-д” гэснийг “энэ хуулийн 48.1-д” гэж, төслийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “хэвлэл мэдээллийг” гэснийг “хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг” гэж, төслийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “хэн бүхэн” гэснийг “оролцогч” гэж, төслийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “санал, дүгнэлтийг” гэснийг “санал, дүгнэлт, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төслийг” гэж, төслийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн “, Зөрчлийн тухай, эсхүл бусад хуульд заасан хариуцлага оногдуулна.” гэснийг “болон холбогдох

бусад хуульд заасан хариуцлага оногдуулна.” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.12 дахь хэсгийн “Байнгын хорооноос байгуулах” гэснийг, төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “заавал” гэснийг, төслийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн “хөөж” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийнхаа асуудалд орёе. **16:09**

Зургаа.“Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Монгол Улсын Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна.

Ажлын хэсгийн гишүүн. Таныг индэрт урьж байна.

Г.Амартүвшин: (29-р тойрог, Хан-Уул дүүрэг)

Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д тусгагдсан “хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” гэсэн заалт нь 2021 онд шинэчлэн найруулж баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуульд тусгалаа

олж, уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсэгт “шүүх эрх мэдэл хөгжлийн бодлоготой байх бөгөөд түүний Ерөнхий зөвлөл хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Улсын дээд шүүх, Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд уламжилна гэж тогтоосон.

Дээрх зорилтын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бүх шатын шүүх, Шүүхийн сахилгын хороо, Улсын Ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, анхан болон давж заалдах шатын шүүхийн шүүгч, шүүхийн Тамгын газрын төлөөллийг оролцуулан Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогод тусгах саналыг боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Их Хуралд уламжилсан.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн

93.1 дэх хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тогтоолын төслийг 10 жилийн хугацаанд хэрэгжиж, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байх зүйтэй гэж үзээд нийт 766.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 зорилго, 16 зорилт, 79 арга хэмжээ, 103 шалгуур үзүүлэлт бүхий урт хугацааны хөгжлийн баримт бичгийг байхаар боловсруулсан байна.

Тухайлбал, шүүхэд мэдүүлэх, иргэний эрхийн баталгааг хангаж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлэх, шүүх эрх мэдлийн байгууллагын захиргааны менежментийг хөгжүүлэх, шүүхийн хүний нөөцийн чадавхыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирсон тогтвортой урьдчилсан тооцоолсон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг цогцоор нь тусгалаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед

- Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан шүүхийн хөрөнгө оруулалт болон шүүгчдийн сургалтын төсвийг тогтоолд хэрхэн тусгасан талаар,
- Улсын Их Хурлын гишүүн

Н.Алтанхуяг Шүүхийн цогцолбор барилгын ажлын явц, хөрөнгө оруулалт, шүүхийн цахим шилжилтийн талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах бодлогын талаар, мөн шүүхийн захиргааны хүний нөөцийн цалин хөлс, нийгмийн хамгааллын баталгаа, ажлын байр дахь дарамтыг бууруулах асуудлын талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.
- Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн тогтоолын төслийг дэмжиж буйгаа илэрхийлээд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулахад кибер аюулгүй байдлыг анхаарч ажиллах асуудлыг талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Шүүгчийн жендэрийн тэнцвэрт байдлыг хангах зохицуулалтыг боловсронгуй болгох,
- Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар шүүгчийн хараат бус, шүүгчийн бие даасан байдлыг бэхжүүлэх төсвийн талаар,
- Мөн Улсын Их Хурлын гишүүд Д.Цогтбаатар Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах хөтөлбөрийг боловсронгуй болгох асуудлаар тус тус үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Г.Амартүвшин гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Лхагвадоржийн Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Цэвээнсүрэнгийн Давхарбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Навагчамбын Баасанжав, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Наранчулууны Отгончимэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Авирмэдийн Отгонцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Батсүрэнгийн Ундрах, Шүүхийн сахилгын хорооны гишүүн Очирбатын Номуулин, Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний танхимын тэргүүн Гүррагчаагийн Алтанчимэг, Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга Содномцэрэнгийн Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны дарга Лхагважавын Санжрагчаа, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Шолтойн Жолбарс нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Баярлалаа. Би хоёр зүйл асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, Шүүхийн ерөнхий зөвлөлд өмнө нь ажиллаж байсан л даа. Бид Их Хурлаас.

Тэгээд хамгийн гол нь энэ шүүгчдийг бэлтгэхтэй холбоотой, энэ хуульчид бэлтгэж байгаа их дээд сургуулиуд, энэ сургалтын чанар, ялангуяа энэ хүмүүсийн сэтгэл зүрхний боловсрол, хандлага дээр нь нэлээн анхаарах шаардлага байгаа тухай бид ярьдаг байсан.

Тэгээд энэ чиглэлийн юм одоо ямархуу байдалтай байна аа?

Дараагийнх нь юм бол шүүхийн байгууллагын ажиллах орчин, нөхцөл, байр сууцаас өгсүүлээд шүүх хараат байх, энэ санхүүжилттэй холбоотой гээд ийм асуудлууд бол бас нэлээн яригдаж байсан. Энэ талаар одоо хариулт өгөөч ээ гэж^

Энэ ярьж байгаа юмтай холбогдоод өнөөдөр шүүхийн байдал, ялангуяа авлигал, хээл хахуультай холбоотой, хулгай луйвартай холбоотой төрийн энэ өндөр дээд эрх мэдэлд байгаа хүмүүсийн орооцолдсон, улс төрийн нөлөө бүхий этгээдүүдийн орооцолдсон нөлөөлсөн ийм хэрэг асуудлууд шүүх дээр шийдэгдэхгүй хэчнээн жилээр хойшлогддог. Энэ дундаас

нь хэрэг, ял завшдаг. Учруулсан хохирлыг нь бүрэн хэмжээнд барагдуулж чадахгүй ийм нөхцөл байдлууд бий болоод байгаа юм.

Энэ талаар ярих юм бол олон жишээг хэлж болно.

Бид Хөгжлийн банкны асуудал 2021 оны төгсгөл хэрээр л одоо энэ асуудал яригдсан. Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ энэ Хөгжлийн банканд нүүрлэсэн хулгай луйвар, чанаргүй зээлийн асуудал зөвхөн нэг банк дампууруулах тухай асуудал биш. Энэ улс орноо бүхэлд нь дефолт руу чирэх дампууруулах ийм эрсдэл үүслээ гэдгийг олон нийтэд мэдээлсэн.

Энд Засгийн газар дангаараа хүч хүрэхгүй нь. Яагаад гэвэл энэ дандаа улс төрийн нөлөө бүхий этгээдүүд оролцчихсон байгаа учраас хүч хүрэхгүй байна гэж.

Ингээд Их хурал дээр энэ асуудлыг өдөр болгон бид шаардсан. Ажлын хэсэг байгуулахыг. Ажлын хэсэг байгуулагдсан. Б.Баттөмөрөөр ахлуулсан. Бидний 5 хүн орсон.

5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 56 хоног ажиллаж байж ингээд бүх асуудлуудыг нь гаргаад, 3.2 байх аа, их наяд төгрөгийн зээл гаргачихсан. Үүнээс 1.7 их наяд нь чанаргүй зээлийн ангилалтай.

Тэгээд улс төрийн нөлөө бүхий 20 хүний нэрийг зарлаад хуулийн байгууллага шалгуулахаар шилжүүлээд, Ерөнхий сонсгол хийгээд, Түр хороо байгуулаад ингээд явсан.

Тэгээд энд чинь нөгөө Хөтөл, Дарханаас өгсүүлээд том аж ахуйн нэгж, байгууллагуудыг авчихсан энэ асуудлуудыг Засгийн газрын мэдэлд авсан. Ингээд ийм ажил болоод яваад байдаг.

Тэгээд явж явж энэ асуудал тэгсхийгээд л хариуцлага тооцож чаддаггүй. Тэгсхийгээд замхардаг ийм байдал байна.

Би цаг бага байгаа учраас ганцхан Хөгжлийн банктэй холбоотой асуудлыг л ярьж байна. Тэгээд энэ мэт асуудлуудыг одоо яах юм бэ?

Ер нь хуучнаа бодох юм бол асуудал өөр болсон. Шатны гишгүүрийг дээрээс нь шүүрдэнэ. Их Хурлын гишүүнээсээ эхлээд ёс зүйн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья. Ажлын хэсгээс хариулчихья. Сургалттай холбоотой, ажлын байрны нөхцөлтэй холбоотой зүйлүүдийг тодруулж асууж байна. Хэн хариулах вэ?

Л.Энхбилэг дарга хариулья. Шүүх ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг хариулья. Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгье.

Л.Энхбилэг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Өнөөдрийн нөхцөл байдал шүүх дээр хүнд байгаа. Бид сүүлийн 10 жил ер нь хөрөнгө оруулалтын асуудал огт байхгүй. Үүнээс шалтгаалаад шүүхүүд ажиллах орчин, нөхцөл муу.

Ажиллах орчин нөхцөлөөсөө шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хугацаандаа явахгүй удаашрах, хуралдаан сараар хойшлох асуудлууд гарч байгаа. Үүнийг хүлээн зөвшөөрч байгаа, ойлгож байгаа.

Тэгээд одоо батлах хөгжлийн бодлогоороо бид үүнийг засаж, **“ШҮҮХ ТӨВТЭЙ БИШ, ИРГЭН ТӨВТЭЙ ШҮҮХ”** болохын төлөө зорьж ажиллаж байна.

Хууль зүйн сургуулиудтай холбогдолтой сургалтын асуудлыг манай Н.Баасанжав гишүүн хариулна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ажлын хэсгийн 6 номерын микрофоныг өгье. Шүүх Ерөнхий Зөвлөлийн гишүүн Н.Баасанжав хариулъя.

Н.Баасанжав: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын 3.2.3 дээр эрх зүйч болон хуульч бэлтгэх тогтолцооны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно, сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллана гээд 284.0 сая төгрөгийг 10 жилийн хугацаанд төлөвлөсөн байгаа.

Энэ хүрээнд яагаад энэ асуудлыг тавьж байгаа вэ гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл одоо энэ бүрэлдэхүүнээр ажилласнаас хойш бид 7 дахь удаагийн сонгон шалгаруулалтыг хийж байна.

Энэ хугацаанд зарласан орон тоогоор шүүгчийн ажлын байр бүрэн нөхөгдөхгүй байна.

Үүний шалтгааныг бид бас судалж байна.

Тэгээд нэг шалтгаан бол өөрөө эрх зүйч бэлдэж байгаа энэ бакалаврын түвшний боловсрол, улмаар дараа нь хуульч бэлтгэж байгаа тогтолцоон дээр эргэж харахгүй бол яг энэ сонгон шалгаруулалт дангаараа орон тоог амжилттай нөхөхөд хангалтгүй юм гэдгийг олж харсан юм.

Тийм учраас үүнийг хөгжлийн бодлогод оруулсан байгаа.

Эрх зүйч бэлтгэх тогтолцоон дээр гол анхаарах зүйл бол магадлан итгэмжлэлийг Хуульчдын холбоо амжилттай хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар энэ эрх зүйн орчин боловсронгуй болох байх гэж бид бас эндээ олж харсан.

Улмаар нэгэнт бэлтгэгдчихсэн тэр магадлан итгэмжлэлийг төгссөн эрх зүйч маань дахиад хоёр жилийн дадлагыг үр дүнтэй хийж байж хуульч болдог.

Тэгээд нэгэнт бэлтгэгдчихсэн хүмүүс бид шүүгчийг шилж олъё гэвэл бас хялбар болно гэж харж байгаа.

Одоо зах зээлд 2021 оны судалгаагаар 26 мянга гаруй эрх зүйчид байсан. Гэтэл хуульчийн ажлын байр өөрөө маш хязгаартай. 6 мянган хуульчийн ажлын байр л байгаа харагдаж байгаа.

Тэгэхээр тогтолцооны асуудал бас энд яригдах юм. Энэ ганцхан Шүүхийн ерөнхий зөвлөлийн биш, энэ бүр эрх зүйн салбарын өөрийн асуудал байгаад байгаа юм гэдгийг.

Одоо хамгийн сүүлийн сонгон шалгаруулалт зарлагдсан явах гэж байгаа.

Энэ дээр ялангуяа иргэний шүүгчид, анхан шат дээр иргэний шүүгчээр ерөөсөө сайн залуучууд, сайн хуульчид төдийлөн сонирхож ирэхгүй байна.

Нэгдүгээрт, шүүгчийн орчин нөхцөл, байр байшин, ажлын ачаалал маш түвэгтэй. Цалин хөлсийг бид одоо жоохон нэмж чадаж байгаа хэдий ч шүүхийн захиргаан дээр нь дэмжин ажиллах тэр нэгжийн ажлын орчин түвэгтэй байгаагаас энэ сайн хангагдахгүй байгааг цогц бодлогын хүрээнд нөгөө талаас нь бас шийдэхийг зорьж байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Авлигалтай холбоотой юм чинь Шүүх ерөнхий зөвлөлийнхөнд. Хэн хариулах юм? А.Отгонцэцэг.

Хөгжлийн банкны асуудал дээр чинь тийм тайлбар хийж болох юм уу? Ажлын хэсгийн микрофоныг өгье. 4 номерын микрофоныг өгье.

Н.Отгончимэг: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүрэг нь шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр тэр шүүн таслах ажиллагаа хуулийн дагуу явах нөхцөл бололцоогоор хангаж өгөх үүрэгтэй байгаа. Тухайлбал, Хөгжлийн банктэй холбоотой энэ хэргийн хувьд бас яг энэ нөхцөл бололцоо дээр хүндрэлүүд үүссэн.

Энэ хүндрэл нь юу вэ гэхээр олон оролцогчтой, олон өмгөөлөгчтэй хэрэг маргааныг шийдвэрлэхэд тэр хэмжээний шүүхийн танхим олдохгүй байсан.

Гэхдээ хуулийн гаргалгааны хувьд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд орон нутгийн байгууллага, энэ шүүхийн байгууллагад хуульд заасны дагуу туслалцаа үзүүлэх ёстой гэдэг ийм заалт байдаг.

Энэ дагуу бид нийслэлд хандаж, нийслэл тодорхой хэмжээгээр шүүх хуралдаан цаг хугацаандаа явах нөхцөлийг нь хангаж өгсөн байгаа.

Гэхдээ энд дурдах зүйл гэвэл тэр гаргаж өгсөн тэр том заал барина. Ашиглалтын зардлыг жишээлбэл шүүх төлөөд явсан байгаа.

Ийм байдлаар Ерөнхий зөвлөл нөхцөл бололцоог нь хангаж ажиллалаа.

Хэргийн хугацааны талаар ярьж байна. Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого энэ баримт бичгийн 5.1.4 дээр яг энэ талаар тодорхой заалт орсон байгаа. Тухайлбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг ерөөсөө энэ хэрэг маргааны төрөл, онцлогоосоо хамааруулаад ялгамжтай тогтоох эрх зүйн орчныг энэ 10 жилдээ бүрдүүлнэ гэдэг зорилго тавьсан байгаа.

Яг үнэндээ эрүү, иргэний, захиргааны хэрэг тэр олон оролцогчтой байна уу, тэр ээдрээ төвөгтэй байна уу гэдгээс үл хамаарч нэгэн жигд хугацаатай байгаа.

Тэгэхээр энэ бүх нөхцөл байдлаас хамаараад хэргийг хянан шийдвэрлэх хугацаа өөрөө бас ялгамжтай байх ёстой.

Үүний эрх зүйн зохицуулалтыг энэ хугацаанд бий болгоно гэдэг ийм зорилго байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Нэлээн тодорхой хариуллаа. Та тодруулах юм уу? Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Тийм. Өнөөдөр миний тэр асуугаад байгаа, ялангуяа улс төрийн нөлөө бүхий этгээдүүдийн холбогдсон авлигал хулгайтай холбоотой асуудал шүүх дээр гацаад явахгүй байгаа асуудлыг зөвхөн ажиллах орчин нөхцөл, байр цалин, нийгмийн хамгааллын асуудалтай холбож ярьж болохгүй л дээ. Тийм.

Тийм учраас би цогцоор нь асуугаад байгаа юм бол ерөөсөө энэ хүний асуудал, хүний нөөцийн асуудал, хүний хандлага, хариуцлага, ёс зүйтэй холбоотой ийм л асуудал байгаа шүү дээ.

Тийм учраас энэ тал руугаа асуудал чиглүүлж ажиллахгүй бол бид энэ зовлонгоосоо, одоо чөтгөрийн тойрог гэдэг чинь эндээс хэзээ ч гарахааргүй ийм нөхцөл байдал байна л даа.

Төрийн бүх салбаруудаас хамгийн түрүүнд шүүхийн салбарын цалинг ялгамжтайгаар буюу өндөр тогтоож өгсөн.

Ингээд үүний тайлбар бол ерөөсөө авлигалаас ангид байх юм гэсэн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Б.Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Үг, асуулт хоёр угаасаа хамт байгаа юм шүү. Асуулт асууж болно, бас үгээ хэлж болно.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Жамьянхорлоогийн Сүхбаатар үг хэлье.

Ж.Сүхбаатар: (25-р тойрог, Чингэлтэй дүүрэг)

Би Байнгын хороон дээр зарим зүйл ярьсан. Тэгэхдээ нэг зүйлийг нь өнөөдөр ач холбогдол өгч, өөртөө асуухаас илүүтэй ерөөл бусдад мэдээлэл өгүүлэх үүднээс асуух гэж байгаа юм.

Одоо шүүхийн энэ баримт бичгийн нэг чухал хэсэг нь “шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлнэ” гэж байгаа юм.

Манайхан шүүх ярихаар дандаа шүүгч тойрч яриад л байдаг. Шүүгчийн цалин хөлс ийм байна, шүүгч тийм ажиллаж байна, ингэж байна гээд.

Гэтэл шүүх эрх мэдэл гэдэг бол өөрөө байгууллагынхаа хувьд, институцийнхээ хувьд үйлчилгээ үзүүлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо жишээлбэл ингээд 6.1.3 дээр “шүүхийн байр, шүүх хуралдааны танхим, хүлээлгийн танхимд, хэрэг маргааны оролцогч өмгөөлөгчтэйгөө шүүх хуралдааны аль ч үед ганцаарчлан ярилцлага нөхцөл боломжийг бүрдүүлнэ” гэж байна. Маш чухал.

6.1.4 дээр “хөгжлийн бэрхшээлтэй хүн шүүхээр үйлчлүүлэх боломжийг хангасан дэд бүтцийг бүрдүүлнэ” гэж байна.

Тэгэхээр яг одоо бол үнэхээр байдал хүнд байна шүү дээ. Ерөөсөө ингээд л холилдоод л. Тэр шүүхийн танхимд битгий хэл шүүхийн тэр үүдний

өрөөнд багтахгүй байна шүү дээ. Хүмүүс нь.

Тэгэхээр Та бүхэнд, энэ иргэдэд бас мэдээлэл өгөх хэрэгтэй байгаа юм. Яг одоо нийт энэ улсын хэмжээнд, эсвэл Улаанбаатар хотод хэдэн 100 мянган иргэд давхардсан тоогоор ч байна үйлчлүүлж байна.

Дээр 3 жил, 4 жилийн өмнө би үзэж байхад одоо буруу санаагүй бол 800, 900 мянган иргэд л үйлчлүүлээд байх шиг байсан. Улаанбаатарт ч билүү.

Тэгэхээр үүнийг хэлмээр байгаа юм. Энэ чинь иргэд 100, 100 мянгаараа тэнд үйлчлүүлж байна гэдгийг нь одоо бас нэг ойлгуулж баймаар юм билээ.

Тийм учраас иргэд ингэж үйлчлүүлээд байгаа учраас тэр шүүхийн үйлчилгээний үүдний өрөө, тэр танхимаас гадна бүр үүдний өрөө хүртэл зөв зохистой баймаар байна.

Одоо шүүх хуралдаан болж байхад бол шүүгч битгий хэл тэнд оролцож байгаа бүх хүн тавгүй байдалд олон цаг хэргээ ярих гэж, өмгөөлөх гэж явж байна.

Тийм тавгүй нөхцөл дунд зөв шийдвэрүүд гарахад. Энэ чинь хүний психологитой холбоотой шүү дээ. Харилцаа, уур амьсгал, прокурор, тэр шүүгч нарын хоорондын харилцаа байна. Хэг ёг хийсэн тийм харьцаатай хэцүү юм билээ шүү дээ. Ер нь хараад байхад.

Тэгээд нэгдүгээрт энэ тоот баримт талаас нь та хэд хэлээч.

Хоёрдугаарт, энэ шүүгч нарын ачаалал яг ямар байна?

Бид ингээд шүүх эрх мэдлийг шүүгч гэж ярьдгаа биш, шүүхээр үйлчлүүлж байгаа иргэд талаас нь хармаар байна.

Дээр нь, хоёр дахь гол юм бол өмгөөлөгч, тэр хэргийн оролцож байгаа улсууд ганцаарчлан ярьдаг, тэр тухтай байх, тэр эрхээ хамгаалдаг тэр асуудлууд дээр нь ойлгуулах талд нь яримаар байгаа юм.

Тэгэхгүй болохоор одоо бид нарын Их Хурал дээр, Засгийн газар дээр ярьж байгаа яриа гэхээр “шүүх гэхээр шүүгч л нүдэнд харагдаад байдаг”, нөгөө талын юм байхгүй.

Шүүхийн үүднээс орж ирэхэд л энэ чинь бас нэг хүн чинь нэг нь эрх чөлөөгөө хамгаалах гээд ингээд бодол санаагаар хүмүүс орж ирж байгаа шүү дээ. Гэтэл тэнд ороход л, ер нь аль ч шүүхийн ихэнхэд нь ороход нэг зэврүүн.

Тэгээд хүмүүст тав тухгүй. Тэгээд л гадаа нь багшралдаад л, машин унаа нь ч багтахгүй, бие засах одоо газрууд нь ч гэсэн хэцүү ч гэдэг юм уу.

Энэ үүднээс нь харахгүй болохоор нөгөө “сүх далайтал үхэр амар” гэж өөрсдөө шүүхээр орохгүй юм шиг хүмүүс боддог.

Ганц энэ чинь эрүүгийн хэрэг биш шүү дээ. Иргэний, Захиргааны гээд.

Тэгэхээр Монгол Улсын байж байгаа байдал, дүр төрхийг дооожоотой юу, доожоогүй, юу хүчин чадалтай юу гэдгийг шүүх эрх мэдлээс л хардаг.

Ер нь шүүх бол төр, улсын өөрийнх нь тулгуур л даа. Тэгээд шүүх муу байна

гэж яриад байгаа бол өөрсдийгөө л бид шүүмжилж байгаа юм. Төрийн хүмүүс бол.

Тэгэхээр энэ талд нь ойлгуулах талаас нь хандах ёстой.

Тийм учраас би энэ хэргийн ачаалал, үйлчлүүлж байгаа байдал, энэ юм талаас нь та хэд хэлээч.

Түүнээс биш нэг шүүгчийг л ганцхан тойроод л юм шийдчих гээд байгаа юм шиг ярьж байна. Үгүй ээ. Ер нь ажиллах орчин нөхцөл хүний амжилтад нөлөөлдөг, хүний сэтгэл зүйд нөлөөлдөг, хүний тэр байж байгаа байдалд нөлөөлдөг шүү дээ.

Зарим нь олон сар шүүхийн үүд хаалга сахисаар байгаад стресс дарамтад ороод сэтгэл зүйн өвчтэй болчихож байгаа байхгүй юу. Бие нь өвдчихөж байгаа байхгүй юу. Энэ хохирлыг хэн ч тооцохгүй байгаа.

Энэ утгаар нь би бас үг хэлэхийн далимд та хэд нэмээд энэ нэг танин мэдэх ойлголт.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ж.Сүхбаатар гишүүн чухал асуудлуудыг хөндөж тавьж байна. Шүүхийн ачаалал, нөхцөл байдлынхаа талаар Та бүгд товч танилцуулчих уу?

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг хариулья. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгөөрэй.

Л.Энхбилэг: Баярлалаа. Ж.Сүхбаатар гишүүний асуултад хариулья.

Өнөөдөр Монгол Улсад 526 шүүгч шүүн таслах ажиллагаа явуулж байна.

Нийтдээ 1400 орчим захиргааны албан хаагчид.

Шүүхийн байрны хувьд нийслэлд нийтдээ 16 шүүх анхан шатны шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлж байгаа. Энэ шүүхэд ерөөсөө л 4 л шүүхийн байртай.

Өөрөөр хэлбэл л нэг шүүхийн байранд 3-аас 4 шүүх байрлаж байна гэсэн үг. 3 шүүх байрлаж үйл ажиллагаа явуулж байна гэсэн үг.

2023 оны шүүн таслах ажлын мэдээ гарсан. Бид 106 мянган хэрэг шийдвэрлэсэн. 2014 онтой харьцуулж үзэхэд жил тутамдаа 1.6 дахин хэргийн тоо өсөж байгаа.

Энэ хэмжээгээрээ иргэд шүүхээр үйлчлүүлж байна гэсэн үг.

Ойролцоогоор бид 1600 орчим иргэд үйлчлүүлж байгаа. Ер нь дүүргийн шүүхүүд дээр.

Тэр 4 шүүхийн байран дээр л гэсэн үг байхгүй юу. Ойролцоогоор. Одөрт.

Нэг хэргийн оролцогч. Мэдээж “Иргэний хэрэг” дээр **нэхэмжлэгч**, **хариуцагч**, **гуравдагч** **этгээд**, тэгээд дагалдаад л **өмгөөлөгч**, **гэрч**, **шинжээч** гээд л явдаг.

“Эрүүгийн хэрэг” дээр гэхэд л сая “Хөгжлийн банк” дээр **80** оролцогчтой, **4** хуулийн этгээдтэй.

Тэгээд **80** шүүгдэгч доор хаяад л 2-оос 3 өмгөөлөгчтэй байх жишээний.

Тэгээд **үлсын яллагч**, **гэрч**, **хохирогч** гээд ингээд үзэхээр харьцангуй тоо маш өндөр байгаа.

Тэгээд байрны багтаамж маш муу. Хуралдааны танхим бараг 2 метр квадрат л явагддаг гээд Та бүхэн төсөөлөөд бодоорой.

Манай гишүүдээс дэлгэрүүлж хариулах юм байвал хариулна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ажлын хэсгээс нэмж хариулах уу? Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг нэмж хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

Н.Отгончимэг: Хөгжлийн бодлоготой холбогдуулаад Ж.Сүхбаатар гишүүний асуусан асуултад хариулъя.

Энэ бодлого бол үндсэн “7 зорилго” агуулж байгаа.

Энэ 7 зорилгын яг үндсэн нэг зорилго нь цэвэр энэ шүүхийн үйлчилгээг яаж шуурхай болгох вэ, чанартай болгох вэ гэдэг асуудалд зориулагдсан байгаа.

Өнөөдөр бид заргалдаж байгаа тал нь заргаа авах асуудал шүүхийн үйлчилгээний чанар нь биш гэдгийг ойлгох ёстой юм билээ.

Шүүхийн үйлчилгээний чанар гэдэг бол хамгийн түрүүнд шударга шүүхээр ерөөсөө шуурхай, өөрийнх нь эрхийг хөндөхгүйгээр тэр маргаанаа, асуудлаа шийдвэрлэх асуудал гэж ойлгож байгаа.

Тэгэхээр Шүүхийн үйлчилгээний чанарыг ахиулахад хамгийн түрүүнд ороод ирсэн хүн маань шүүхийн үйлчилгээ авахдаа өмгөөлөгчөөсөө тэр даруй цаг мөчдөө үйлчилгээгээ авах асуудлыг хөндөхөд байрны асуудал хөндөж байна.

Та бүхэн анзаарсан бол сүүлийн үед нэлээн олон хэргүүд шууд дамжуулалтаар олон нийтэд ил явж байгаа.

Тэгээд анзаарвал байрлалын хувьд өмгөөллийн үйлчилгээ авч байгаа хүн нь өмгөөлөгчөөсөө хол сууж байгаа.

Энэ чинь л өөрөө өмгөөлүүлэх эрхийн наад захын шаардлагыг хангахгүй шүүхийн байртай байгааг илтгэж байгаа юм.

Тийм учир энэ хөгжлийн бодлогодоо шүүхээр үйлчилгээ авах гэж байгаа хүн бол наад захын эрхээ хангах боломжтой байр, нөхцөлөөр хангагдах ёстой гэдэг энэ зорилгууд орж ирсэн байгаа.

Улсын хэмжээнд урьд жилийн статистикаар 106 хэрэг шүүхээр орсон байна лээ. **Эрүү, Иргэн, Захиргаа** бүгд нийлээд **106 мянган хэрэг** орсон.

Энэ хэргийн доод тал нь хоёр тал байгаа. Доод тал нь хоёр тал байгаа гэж бодоход **200 мянга** гээд маш энгийнээр тоо гарах боломжтой.

Тэгээд хэргийн талууд нэмэгдэх хэрээр авч үзэх юм бол жилдээ 116 шүүх болон нэмээд Дээд шүүхээр **400-аас 500 мянган** хүн шүүхийн сервис үйлчилгээг авч байгаа гэсэн үг юм.

Тэгэхээр энэ бүх хүний авч байгаа тэр сервис болон үйлчилгээ чанартай л байх ёстой гэдэг үүднээс **“7 зорилго”-ын** нэг нь болж энэ **“чанарт ахиц гаргана”** гэдэг ийм зорилт орж ирсэн.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг үг хэлье.

М.Оюунчимэг: (25-р тойрог, Чингэлтэй дүүрэг)

Тэгэхээр системийг нь сайжруулахгүйгээр шүүгчдийг муулаад юу ч өөрчлөгдөхгүй.

Тэгээд би энд сууж байгаа бүсгүйчүүдээр үнэхээр бахархаж байна. Яагаад гэвэл нэр дэвшигчийн сонголоор ялаад гарч ирсэн эмэгтэйчүүд маань энэ “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого” гээд шинэчлэлийг өөрсдөө гаргаад бариад ороод ирж байна.

Үнэхээр бахархаж байна. Та нараар.

Нэг хэсэг хүмүүсийн буруу үйл ажиллагаанаас болоод нийт шүүгчдийн нэр хүндийг унагааж болохгүй.

Би 2016 оноос хойш Улсын Их Хурлын гишүүн болоод байж байхад анх удаа манай эрэгтэй гишүүдээс жендэрийн баланс алдагдчихлаа, юу болоод байна, дахиад санал хураалт явуулъя гээд чадлаараа ороод ирсэн энэ эмэгтэйчүүдээс бараг нэгийг нь хүчээр унагаах шахаж эрэгтэй хүнийг оруулъя гээд явж байсан.

Тийм байдлаар юм бол явж ирсний хар гай бүх газар сөрөг үр дагавар бий болгоод байгаа.

Тэгээд манай энэ бүсгүйчүүд маань шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг маш тодорхой оруулж ирж байгаад талархаж байна.

Үүнийг бид цаг алдалгүй шийдэх ёстой.

Тэгээд сая хэлж байна л даа. Хөөрхий минь 10 жилд 766.0 тэрбум төгрөгийг төсөвлөөд орж ирж байгаа 7 зорилтын хүрээнд гэж байгаа юм.

Тэгсэн хэрнээ өнөөдөр нийслэлд гэхэд 4, 5 шүүх нь шүүхийн танхим байхгүй.

Тэгээд сая Та бүхний тайлбарлаж байгаагаас харахад хүн л алдаж, оносон ч бай, гэмт хэрэгтэн ч бай, биш ч бай Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх үүрэгтэй.

Тийм учраас “шүүхийн үйлчилгээг чанартай авах ёстой” гэдэг асуудал өөрөө хамгийн чухал.

Гэтэл өмгөөлөгчтэй, өмгөөлөгч авсан хүн тэнд өмгөөлөгчөөсөө хол суугаад яаж өмгөөллийн зүйл авах вэ дээ. Тийм ээ.

Тэгээд сая хэлж байна. 106 мянган хэрэг гээд. Сүүлийн үед бид гэр бүлийн тухай асуудал дээр, хүүхэд хамгааллын асуудал дээр тусгай шүүгчтэй байя. Энэ дээр тусгай асуудлыг хөндөж байя гээд энэ асуудал яригдаж байгаа. Орон тооны асуудал яригдаж байгаа.

Тэгэхэд бид бараг сүүлийн 20-оос 24 жилд шүүхийн шинэчлэлийн асуудлыг хөгжлийн бодлогын түвшинд оруулж ирээгүй ингээд л орхисон байгаа байхгүй юу.

Тэгээд цаг жоохон оройтож орж ирж байна. Тэгэхдээ орж ирж байгаа нь сайн байна.

Тэгээд энд Монголын нийгмийн хөгжил, чанартай үйлчилгээг үзүүлье гэдгийг манай хүүхнүүд манлайлаад явж байгаад би үнэхээр баярлаж байна.

Тэгээд сая энд хэлж байна л даа. 2014 оноос хойш бараг бодлогын томоохон өөрчлөлт тогтолцоонд ороогүй.

Нэг хэсэг мэдээж шүүгчийн цалин өндөр байсан гээд 2015 онд билүү, 3 сая орчим байсан.

Үүний дараа прокурорынх, Авлигатай тэмцэх газрынх гээд бид ер нь жил болгон бараг 2015 оноос хойш энэ чиглэлийн хүмүүсийн цалин хөлсийг дорвитой нэмсэн.

Харин шүүгчдийн маань цалин эргээд бага болчихсон байгаа. Тийм ээ. Харьцуулаад үзэхэд.

Гэтэл ачаалал нь маш их. Дээрээс нь ажил, амралтын баланс шүүгчдэд алдагдчихсан. Тэр дундаа ихэнх нь эмэгтэйчүүд. Ар гэрээ орхиод, эсвэл амралт ч үгүй ажилладаг.

Гэхдээ түүнийх нь урамшуулал, илүү цагийн цалин юм уу, эсвэл гүйцэтгэл дээрээ суурилсан санхүүжилтийн механизм энд бас орхигдчихсон.

Тэгээд бид шүүгчдийг янз бүрийн өмнөх алдаанаас болоод одоогийн өөрчлөлт хийе гээд өдөр шөнөгүй ажил, амралтын балансаа алдаад ажиллаж байгаа энэ хүмүүс рүүгээ асуудлыг буруутгаад яриад байх шаардлага байхгүй.

Тийм учраас хугацаа алдалгүй батлах ёстой гэж бодож байна. Харин та нар маань энэ тооцоо, судалгаагаа, 2024 оны төсөв одоо хэрэгжээд эхэлчихсэн учраас энэ хууль батлагдлаа гэхэд хугацааг нь хэзээнээс суух вэ?

2025 оны төсөв дээр ерөнхийдөө. Бид тэр байтугай зүгээр нүүрсийг л харахад 800 тэрбум төгрөг гэдэг бол нэг компанийг хулгайд л гараад явж байхад эдгээр хүмүүс шүүхийн чанартай үйлчилгээ үзүүлье, 700-хан тэрбум төгрөг 10 жилийн хугацаанд бид зарцуулья гээд

орж ирж байна гэдэг бол байж боломгүй зүйл л дэ. Бүхэл бүтэн Монгол Улсын хувьд.

Тэгээд шүүхийн танхим нь өөрөө өнөөдөр нэг байранд 2, 3 шүүх хуралдаад байж байна гэдэг бол юу гэсэн үг вэ. Энэ бол байж болохгүй.

Тийм учраас энэ арга хэмжээг шуурхай авах хэрэгтэй.

Шүүхийн тасралтгүй үйл ажиллагааг явуулах үүргээ Засгийн газар зайлшгүй биелүүлэх ёстой.

Тийм учраас бүгдээрээ энд нь бас хэлэлцүүлгийн явцад тодорхой тусгаад ажлын хэсэг энэ дээрээ сайн ажиллаад шуурхай батлах ёстой гэсэн байр сууриа илэрхийлье гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

М.Оюунчимэг гишүүн дэмжиж үг хэллээ.

Шүүхийн хувьд жил бүр хөрөнгө оруулалтуудынхаа саналыг Шүүх ерөнхий зөвлөлөөс өгдөг. Гэвч сүүлийн 10 жил хөрөнгө оруулалтууд огт тавигдаагүй.

Өнгөрсөн жил ч гэсэн Шүүх ерөнхий зөвлөлөөс саналуудаа ирүүлээд 50 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр өгсөн боловчиг Хууль зүйн байнгын хороо хянаад явуулсан. Тэр хэвээр нь.

Гэтэл улсын төсөв дээр мөн хасагдсан.

Одоо энэ жил 5 тэрбум төгрөг л байж байгаа.

Ийм байгаа учраас энэ нөхцөл байдлуудыг өөрчлөхөд энэ бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийг явуулахад шаардагдах хөрөнгийг Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороо тавьж өгөх ёстой. Сангийн яам.

Тэгээд энэ агуулгаараа энэ бодлогын баримт бичгийг үндэслээд жил бүрийн улсын төсөвт тодорхой хөрөнгүүд суух юм. М.Оюунчимэг гишүүн ээ.

Энэ асуудлыг дэмжиж байгаагаа илэрхийллээ.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл үг хэлнэ.

Д.Сарангэрэл: (29-р тойрог, Хан-Уул дүүрэг)

Шүүхийн үйл ажиллагааг дэмжих зорилготой энэ тогтоолын төслийг дэмжиж байна.

Шүүх дээр манай эмэгтэйчүүд дийлэнх нь ажилладаг. Ажиллах нөхцөл хүнд гэж Та бүхэн маань ярьж байна. Бид ч гэсэн үүнийг мэднэ.

Ажлын ачаалал маш ихтэй. Ямар их материалтай танилцдаг билээ.

Дараа нь шийдвэр нь хуулийн дагуу тухайн хүнд сөрөг гарах юм бол эргээд шүүгчдийг буруутгадаг.

Энэ нь өөрөө сэтгэл зүйн илүү тийм дарамттай ийм онцлог мэргэжилтэй ажил гэдгийг мэднэ.

Тийм учраас энэ удаа шүүгчдээ дэмжсэн, ажиллах нөхцөлийг нь сайжруулах гэсэн ийм тогтоолын төслийг бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа илэрхийлье.

Би өөрөө сэтгэл зүйн хүн болохоороо энэ тогтоолын нэрийг хараад “Шүүхийн эрх мэдлийн хөгжил, эрх мэдлийг хөгжүүлнэ” гэж ер нь яах вэ?

Тэгээд “шүүхийн чанартай үйлчилгээ” гэдгийг би бас ойлгохгүй байгаа юм. Шүүхийн үйлчилгээ өөрөө хуулийн дагуу. Тийм ээ. Шуурхай. Одоо ийм л байх ёстой байх л даа. Шударга байх ёстой байх.

Үүнээс одоо нөгөө гоо сайхны үйлчилгээ гэдэг юм уу, бараа, бүтээгдэхүүнтэй адилхан тийм чанар яригдах уу, үгүй юу? Магадгүй хуулийн хэллэг нь ямар байх нь вэ? Би үүнийг мэдэхгүй байна.

Тэгээд зүгээр нэг “эрх мэдлийг хөгжүүлнэ” гэхээр одоо яаж хөгжүүлнэ гэсэн үг вэ гээд логикийн хувьд, яг сэтгүүл зүй дээр ингээд цаасан дээр буухаар сонин харагдаад.

Чанартай үйлчилгээ гэхээр бүр ойлгомжгүй болоод. Нөгөө хуулийн үйлчилгээ биш юм шиг, нэг тийм өөр сэтгэгдэл төрж байгаа байхгүй юу.

Үүнийг магадгүй “шүүхийн стратеги төлөвлөгөө” гэдэг юм уу, тэр талаас нь ер нь нэрлэх тийм боломж байгаа юу гэж би танин мэдэхүйн чанартай, өөрөө мэргэжлийн хүн учраас энэ талаас нь Та бүхнээсээ тодруулга авч байгаа юм шүү.

Бусдаар бол бүх талаар дэмжиж байна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Сарангэрэл гишүүн үг хэлсэн үү? Асуулт байгаа юу? Хэн хариулах вэ?

Шүүхийн зөвлөлийн гишүүн А.Отгонцэцэг хариулъя. 5 номерын микрофоныг өгье.

А.Отгонцэцэг: Өдрийн мэнд хүргэе. Д.Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

Шүүхийн тухай хуулийн 2021 оны 03 дугаар сарын 01-нээс мөрдөж эхэлсэн Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “шүүх эрх мэдэл хөгжлийн бодлоготой байна”, “шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулж, Улсын дээд шүүхийн саналыг авч Улсын Их Хурлаар батлуулна” гэсэн ийм хуулийн зохицуулалттай.

Энэ зохицуулалтын хүрээнд “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого” гэсэн томъёоллоор энэ 7 зорилго бүхий шүүх эрх мэдлийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж орж ирсэн.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Одоо 2 гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимд орж ирээрэй.

Одоо Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлье.

Ц.Сандаг-Очир: (21-р тойрог, Налайх, Багануур, Багахангай дүүрэг)

Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын дунд хугацааны баримт бичгийг дэмжиж байгаа юм.

Гэхдээ бас зарим нэг зүйлийг хэлэх, асуух тодруулах зүйл байна.

Бид ингээд л яриад л байна. Улсын Их Хурал хууль тогтоох дээд байгууллага,

гүйцэтгэх засаглал Засгийн газар, шүүх засаглал гээд.

Гэтэл энэ шүүх засаглал маань ингээд төсөв хөрөнгийн хувьд хараат, Засгийн газраасаа. Дандаа л төсвөөр хангасан, цангасан, дутагдсан л ийм л явж ирж байна л даа.

Тэгэхээр цаашдаа хэлэлцүүлгүүдийн үеэр харахад эрх барьж байгаа нь ч цөөхөн ч гишүүд хандлага нь өөрчлөгдөж, энэ шүүх засаглалыг цаашдаа төсөв, санхүүгийн хувьд нэмэгдүүлэх, бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна гэж ярьж байгаа нь их сайн байна гэж харж байна.

Нэг засаглал нь төсөв хөрөнгөөр дутагдаад, гачигдаад, шинэчлэл юмаа хийх гээд байдаг. Төсвөөр дутаад л байгаа юм л даа.

Тийм учраас зайлшгүй л энэ салбарт, засаглалын энэ институтэд, төсөв санхүүгийн асуудал.

Тэгэхдээ энэ засаглал чинь бас өөрөө улсад орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлдэг байхгүй юу.

Би юу гэж асуух гэж байна вэ гэхээр шүүх ер нь жилдээ орон нутгийн төсөвт хэдий хэмжээний орлого төвлөрүүлдэг юм? Хүү, торгуулийн орлогоос.

Энэ нь юундаа зарцуулагддаг юм? Өөрсдөд нь хэдэн хувь нь оногддог юм? 100 хувь орон нутгийн төсөвт одоо хуваарилаад авчихдаг юм уу? Үүнийг тодруулж өгөөч.

Яагаад үүнийг тодруулж байна вэ гэхээр цаашдаа дунд хугацааны бодлогын баримт бичигтээ төвлөрүүлж байгаа

орлогыг өөрсдөө зарцуулдаг байх асуудлыг ер нь цаашдаа Их Хурал засаг, Засгийн газартайгаа яривал яасан юм? Ярьдаг зүйл байдаг юм уу, үгүй юу?

Ингэвэл бас та нарын энэ дутагдаад байгаа төсөв, санхүүгийн асуудлыг шийдэх нэг гарц гаргалгаа нь энэ шүү дээ.

Тодорхой хэмжээний асуудлуудаа өөрсдөө дотроо шийдээд байх бололцоо боломж эндээс гарна шүү дээ. Үүнийг Та бүхэн хэлээдхээч.

Нөгөө талаар шүүхэд итгэх иргэдийн итгэл алдраад байгаа асуудал ерөөсөө энэ авлига, албан тушаалын хэрэг л байхгүй юу.

Иргэд яагаад шүүхэд итгэхгүй байна, яагаад шүүхийн нэр хүндэд итгэхгүй байна гэхээр ерөөсөө авлига албан тушаалын хэрэг эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн энэ зүйл, заалтад холбогдсон учруулсан хохирол, хийсэн хэрэгт нь оноосон ялыг оноохгүй байгаад л иргэд дургүйцээд байгаа юм.

Тэгээд энэ салбарт энэ тал дээр шүүхийн процесс хаалттай байна. Ил тод, нээлттэй байж чадахгүй байна.

Ийм учраас иргэд улсад хэдэн тэрбум төгрөгийн хохирол учруулчихаад тэгээд хэдхэн цөөхөн тооны мөнгөөр торгуулчихаад ингээд ял завшаад.

Ял завшуулахгүй гээд хорьж цагдахдаа гол нь биш. Тэр учруулсан хор хохирлыг нь л ёстой яалт ч үгүй төлүүлдэг байх л ёстой байхгүй юу. Төлүүлдэг байх ёстой.

Улсыг, иргэнийг, компанийг хохиролгүй болгодог байх ёстой. Ийм ажил хийгдэхгүй байгаа учраас ерөөсөө

энэ авлига албан тушаалын гэмт хэргийн энэ асуудлуудад оноосон хэрэгт нь тохирсон ял оноохгүй байгаа учраас, ял завшаад байгаа учраас иргэд уур бухимдалтай, ингэж итгэхгүй байгаа юм.

Хоёрт, би цаг дуусах гээд байна. Байнгын хороон дээр ажиллаж байсан. Шүүх ер нь цаашдаа өөрийн гэсэн хэвлэл мэдээлэл, телевизтэй байвал яасан юм бэ. Ил тод байх асуудал чинь эндээс эхлэлтэй юм биш үү.

Энэ авлига албан тушаалын хэргүүдийг цаашдаа ер нь шууд нээлттэй байдлаар явуулдаг байх тал дээр энэ бодлогын баримт бичигт яаж тусаж байгаа юм? Энэ дээр нь.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Шүүх ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг хариулъя.

Л.Энхбилэг: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Бид жилдээ 30 гаруй тэрбум төгрөгийг улсын орлогод оруулдаг. Тийм. 30 гаруй тэрбум.

Ер нь энэ тоо 20-оос 30 хувь өсөж байгаа.

→ **Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа гээд.**

2020 оны Шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд хорихоос өөр төрлийн ялыг хүнтэй нь авна. Одоо ялыг эдлүүлэх гэж гүйцэтгэх хуудсыг хүнтэй нь авна гэхихсэн.

Одоо бид **560** орчим шахуу **шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудас**

шүүх дээр хайрцаг нь байна. Шийдвэр гүйцэтгэл хүнээ авчир гэж шаарддаг.

Энэ талаар бид бас хуульд өөрчлөлт оруулахаар саналаа ингээд төлөвлөөд явж байгаа.

→ **Шүүх нээлттэй байх гээд.**

Бид нээлттэй байхыг маш их хичээж байгаа.

Шүүгч нар маань 2021 оноос хэрэгжсэн хуулийн дагуу шүүхийн шийдвэрээ нээлттэй, ил тод, шүүхийн цахим санд байршуулж байгаа.

Бид 5 мянга орчим шахуу шүүхийн шийдвэрийг **shuukh.mn** дээр байршиж байгаа. 500 мянга орчим.

Үүнтэйгээ холбогдуулаад 2021 оны хуулийг хэрэгжүүлж шүүгч нар шүүхийн шийдвэрийг иргэдэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх үүднээс **“шүүхийн шийдвэрийн хураангуй”** гэдгийг бичиж эхэлж байгаа.

Энэ бол материаллаг хууль дээрээ ч байгаа, процессын хууль дээрээ ч байгаа.

Одоо бид шүүхийн нээлттэй, ил тод байдал гээд Шүүхийн тухай хуулийн 12-т байгаа.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд бас зөрчилтэй юмнууд байна. Одоо нөгөө Нууцын тухай хууль, Хувь хүний мэдээллийн тухай хууль гээд.

Ер нь шүүх хуралдааныг нээлттэй, ил тод явуулья гэхээр бид нарт мөн адил нөгөө техник, тоног төхөөрөмж байхгүй.

Одоо бид шүүх хуралдааныхаа бичлэгийг хадгалахын тулд зүгээр нэг

ердийн камераар бичлэг хийгээд л хадгалаад байгаа.

Үүнийгээ бид давах заалдах болон хяналтын шатын шүүхээс эхэлж нээлттэй, ил тод шүүх хуралдааныг **“live stream”** буюу нээлттэйгээр явуулдаг байя гээд хөгжлийн бодлогодоо тусгаад, төлөвлөөд санхүү, төсвөө төсөвлөчихсөн явж байгаа.

Нээлттэй, ил тод байдал дээр нэмээд манай А.Отгонцэцэг гишүүн хариулна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье. Шүүх ерөнхий зөвлөлийн гишүүн А.Отгонцэцэг нэмж хариулья.

А.Отгонцэцэг: Бодлогын баримт бичгийн эхний зорилт шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангаж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлнэ гээд.

Нэг дэх зорилтоо **“Шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангана”** гэж байгаа юм.

Энэ бол иргэн эрх зүйн асуудалтай тулгараад шүүхэд хандахаас эхлээд шүүхэд хэргээ үүсгүүлээд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болоод, процессын явцад эдлэх бүх эрхээ ямар ч хүндрэл бэрхшээлгүй бүрэн эдлэх боломжийг хангана гэсэн агуулгатай. **“Шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангана”** гэсэн энэ зорилтын хүрээ.

Ингэж шүүхийн процесст оролцож байгаа иргэний эрхийн баталгаа баталгаатай хангагдаж байгаа нь ил тод, олон нийтэд харагдаж байх ёстой гэсэн

дарааллаар дараагийн зорилтыг бол “Нээлттэй, ил тод байдлыг хангана” гэж томъёолсон.

Яг энэ зорилтын хүрээнд үйл ажиллагаа 1.2.1 дээр шүүхийн шийдвэрийг ойлгомжтой байдлаар олон нийтэд нээлттэй, ил тод, шуурхай мэдээлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгоно.

Энд арга хэлбэрийг аль болох хүртээмжтэй, олон нийтэд энэ зорилтот бүлгүүдэд ялгамжтайгаар хүрч чаддаг, ойлгогддог байлгах зорилгоор ингэж арга хэлбэрийг боловсронгуй болгоно гэж байгаа.

Сая Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаа “өөрийн телевизтэй байх” гэсэн санаа энд орж болно.

Ер нь бүх л арга хэлбэрийг ашиглана гэсэн санаа байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Одоо Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа үг хэлье.

Х.Булгантуяа: (23-р тойрог, Баянзүрх дүүрэг)

Ийм баримт бичигтэй байхыг дэмжиж байна.

Бид Гэр бүлийн тухай хууль Улсын Их Хурал дээр яг одоо хэлэлцэгдэж байгаа.

Гэр бүлийн тухай хуулийг хэлэлцэж байхад гэр бүлийн асуудлаар дагнасан тусгайлан шүүхтэй болох асуудлыг бид бас ярьсан. Үүнийг олон улсын байгууллагууд ч гэсэн бидэнд нэлээдгүй зөвлөж байгаа.

Ер нь шүүхийн шийдвэрийн тоо баримтаас дурдах юм бол жилд 54 мянга орчим иргэний хэрэг шийдвэрлэснээс Гэр

бүлийн тухай хуулиар 10 орчим хувь нь байгаа. Тийм ээ.

Энэ тоо ер нь нэлээдгүй нэмэгдэх шинжтэй.

Тэгээд Гэр бүлийн хууль, ингээд гэрлэлт цуцлах, эцэг эх тогтоох, эцэг эх байх эрхийг нь хасах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, гадаад дотоод хүүхэд үржлийн харилцааг шүүхээр тогтооно гээд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад орсон.

Бид сая Гэр бүлийн тухай хуулийн хэлэлцүүлгийг хийж байхад Хууль зүйн сайд бид дараагийн 2-оос 3 жил бэлтгэж байгаад гэр бүлийн тухай тусгайлан шүүхтэй болно гэдэг асуудлыг ярьсан.

Энэ асуудал танай баримт бичигт ерөөсөө дурдагдаагүй байна.

Энэ ингээд л эсвэл захиргааных руу, иргэнийх рүү гээд л ийш тийшээ шийдэгдээд байхаар хүүхдийн асуудал, гэр бүлийн асуудлуудыг мэргэшсэн шүүгч байхгүй болохоор гаргаж байгаа дүгнэлттэй ч төдийлөн сайн танилцаж, ялангуяа энэ дунд хүүхдийн эрх зөрчигдөж үлдэх гээд байдаг тал их байдаг учраас үүнийг нэгдүгээрт тусгаж оруулах нь зүйтэй байна.

Хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх бол яг үнэнийг хэлэхэд цагдаа дээр ч очоод, шүүх прокурор дээр очоод хамгийн их зөрчигдөж байгаа талаар маш их ярьдаг.

Манай хөгжлийн бэрхшээлтэй хүний, ялангуяа дохионы хэлмэрч байдаггүйгээс үүдээд цагдаа дээр ч очоод асуудлаа танилцуулж чаддаггүй. Очоод мэдүүлэг өгч чаддаггүй. Ингээд авах ёстой

нэг дохионы хэлмэрчийнх санхүүжилт нь огт байдаггүй гэдэг асуудал байна.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бүр энэ дээр тусгайлсан бодлогын бас нэг баримт бичигтэй болно гэдэг юм уу, ингээд оруулбал яасан юм бэ.

Тэгэхгүй бол их ерөнхий байдлаар оржээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн дотроо харааны бэрхшээлтэй бол нэг ондоо, сонсголын бэрхшээлтэй бол бас нэг ондоо байдаг.

Дээрээс нь нэмээд Та бүхэн маань бас энэ баримт бичгийнхээ үг, үсэг юман дээр бас нэг сайн хараарай.

Одоо нэг ийм үгүүд яваад байх юм. **Хуульчдаас шүүгчийг шилж олох арга ажиллагааг хөгжүүлнэ.** Одоо бодвол шүүгч хүн бол хуульч хүн л байж таарах байх. Шилж олох гэдэг. “Шилж олох”, “сонгон шалгаруулах” энэ тэр гэдэг одоо гаднын бичиг цааснаас орчуулчихсан юм шиг байж бас болохгүй байх.

Одоо манай хуульчид хамгийн. Энэ асуудал дээр түрүүн Д.Сарангэрэл гишүүн бас хэлж байна. **“Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”** гэж.

Тэгэхээр иймэрхүү зүйл дээр нь бас Та бүхэн маань анхаараарай.

Дээр нь, сүүлийн үед хүүхдээс мэдүүлэг авахтай холбоотойгоор хүүхдээс мэдүүлэг авдаг тусгайлан өрөө, тасалгаатай байх. Хэрэг хянан шийдвэрлэхэд процессыг бид Хүүхэд хамгааллын тухай хууль дээр бас оруулж өгсөн.

Танай хууль дээр энэ асуудлыг огт дурдаагүй байна.

Энэ бодлогын баримт бичиг дээр.

Одоо хоёрхон дүүрэг л хүүхдээс мэдүүлэг авах тусгайлсан өрөөтэй. Бусад өрөөнд та бүхэн хэлж байна. Бид ажиллахад ч хэцүү байдаг гэж.

Тэгэхээр ажиллахад ч хэцүү, хүүхдээс мэдүүлэг авах нь битгий хэл том хүн ч ороод эрх нь зөрчигдөх гээд байгаа юм шиг эвгүй санагдаад байгаа тийм өрөөнд хүүхдийг суулгачхаад хэчнээн цагаар мэдүүлэг авдаг ийм асуудлууд бас гардаг.

Тэгэхээр шүүхийн хувьд ч гэсэн энэ асуудлыг Та бүхэн цаашид яаж шийдье гэж бодож байна аа? Хүүхэд, гэр бүлийн асуудал бол огт дурдагдаагүй байгааг Та бүхэн анхаараарай.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Х.Булгантуяа гишүүн хэд хэдэн асуудал хөндөж ярьж байна.

Энэ дээр **“шүүгчийг шилж сонгох”** гэдэг нэр томьёо Шүүхийн тухай хуульд байгаа шүү дээ. Тийм ээ. Энэ нэр томьёо бол тогтчихсон нэр томьёо байгаа юм. Үүгээрээ явна. Тийм. **Шилж олох** гэж тэр нэр томьёогоороо явдаг. Олон жил тогтчихсон хууль зүйн ойлголт байгаа юм.

Тэр юун дээр нь харин хариулчхаарай. Хүүхдийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд тусгайлсан тийм онцлог зохицуулалттай байгаад байгаа шүү дээ. Тийм ээ. Энэ дээр хариулчихъя. А.Отгонцэцэг гишүүн хариулах уу? Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн А.Отгонцэцэг хариулья. Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье.

А.Отгонцэцэг: Түрүүн хэлсэн.

Эхний зорилт бол “Шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангана” гэсэн зорилт байгаа.

Энэ зорилтын хүрээнд үйл ажиллагаа 1.1, 1.2 “хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн иргэнд үзүүлэх хууль зүйн туслалцааны үр нөлөө, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн ийм үйл ажиллагааг томъёолсон.

Энд “зорилтот бүлгийн иргэн” гэдэгт хүүхэд, насанд хүрээгүй этгээд орно, хүчирхийлэл, дарамтад байгаа гэр бүлийн гишүүн орно. Энд бүгдээрээ орно.

Энэ үйл ажиллагаанд заасан зорилтууд дараагийн 5, 6 дахь шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

Шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх зорилтуудаараа дэмжигдээд иж бүрэн болох юм.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Х.Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Их Хурлын гишүүд танхимдаа байраа эзлээрэй. Санал хураалт явуулна.

Х.Булгантуяа: (23-р тойрог, Баянзүрх дүүрэг)

Ерөнхийгөөр бол орсон байна. Тэгэхдээ би зүгээр хэлээд байгаа нь нэгэнт ийм том баримт бичиг оруулж байгаа юм бол, дээрээс нь нэмээд байгууллагын эрх зүйн асуудлыг өчнөөн хуудсаар хэдүүлээ бичсэн юм чинь.

Ялангуяа энэ хүүхэд, гэр бүл энэ тэр гэдгийг зүгээр нэг зорилтот гээд нэг ерөнхий байдлаар бичээд битгий орхиоч ээ.

Яагаад гэвэл энэ хэсэг хүмүүсийн эрх хамгийн их зөрчигдөөд байдаг хэсэг байхгүй юу. Тэгэхээр

- хүүхдийн асуудлыг,
- гэр бүлийн асуудлыг,
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг

тусгайлсан бид бодлоготой болно гээд. Тэгээд түүн дээр нь бид Та бүхэнтэй хамтарч ажиллая.

Яг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дотроо “харааны бэрхшээлтэй хүн”-д зориулж шүүхийн үйл ажиллагаанд ороход эрх нь хэрхэн яаж зөрчигдөхгүй байгаа вэ, хангагдах вэ. Хүүхдийн хувьд, гэр бүлийн хувьд гэдгээр.

Тэгэхээр зорилтот бүлэг дотор бүгдээрээ орж байгаа юм.

Тэгэхээр энэ хангалттай юм гэдэг бол хангалтгүй шүү.

Манай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд, гэр бүлийн төрийн бус байгууллагууд үүн дээр сэтгэл хангалуун байхгүй.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Их Хурлын гишүүд санал хураалттай. Гишүүд ороорой.

Саяын тодруулгад хариулчихъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

Н.Отгончимэг: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Энэ дээр бид ер нь цаашдаа бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарч зайлшгүй ажиллах ёстой юм билээ.

Бид үнэн л дээ. Ерөнхий байдлаар тусгачихсан байгаа.

Та анзаарвал 6.1.1-ийг анзаарчхаарай. Энэ дээр бид “Стандартад нийцсэн шүүхийн байртай болно.” гэж оруулсан байгаа.

Энэ стандартыг одоо бид батлахдаа яг саяын дурдсан энэ зорилтот бүлгийн хүмүүсийн тэр жаргал, зовлонг илүү мэддэг, энэ рүү гүн рүү нь орж ажиллаж байгаа энэ салбарын мэргэжилтнүүдийн үгийг, дуу хоолойг сонсчхоод.

Жишээлбэл, Хүний эрхийн комисс, тус яам. Ингэж байж бид яг стандарт гэдэг зүйлийг гаргаад авчихвал маш боломжтой болох байгаа юм.

Түүнээс гадна “Гэр бүлийн дагнасан шүүх”-ийг бол асуусан. Энэ энэ гэр бүлийн дагнасан шүүхийн асуудлыг бид 2.2.2 дээр оруулчихсан байгаа.

Ер нь цаашдаа бид энэ шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтыг өөрчилнө.

Гэхдээ ямар үндэслэл зарчим барих юм бэ гэхээр шүүхийн үйлчилгээ өөрөө

- чанартай байх ёстой,
- шуурхай байх, ёстой,
- үр дүнд хүрч байх ёстой.

Тэгээд энэ эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа хүмүүс нь, субъект нь өөрөө хариуцлагатай байх ёстой гэдэг энэ хэдэн

зарчмыг барьж байгаа бид тогтолцоогоо өөрчилнө шүү, судалж байж өөрчилнө шүү гэдэг ийм арга хэмжээ оруулчихсан байгаа юм.

Тэгээд үүнтэй уялдаад бидний найдаж байгаа зүйл бол хөгжлийн бодлогын дараа яг энэ бодлогод үндэслээд Шүүх байгуулах хууль бас орж ирнэ гэж найдаж байгаа.

Бид Засгийн газарт саналаа өгчихсөн байгаа.

Бид энэ “Гэр бүлийн шүүх”-ийг дэмжиж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл дэмжиж саналаа өгсөн.

Засгийн газар Их Хуралд өргөн мэдүүлчихсэн байгаа. Мөн манай саналыг дэмжсэн байгаа.

Тэгээд яг энэ хуулийг хэлэлцүүлэх явцад хэзээнээс хэрэгжих вэ гэдэг. Энэ дээр бас санал хэлэлцээд явах боломжтой гэж харж байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирье. Гишүүдийг орж ирж байх хооронд би бас Монгол Улсын шүүх эрх мэдлийн бодлогын баримт бичиг батлагдаж байгаатай холбогдуулаад үг хэлье.

Сүүлийн жилүүдэд шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлыг хангах бодлогын эрх зүйн үндсийг энэ удаагийн Улсын Их Хурал хийж байгаа.

Өнөөдрийн баталсан Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын

баримт бичиг ч гэсэн үүний нэг хэсэг байгаа юм.

2019 онд Үндсэн хуульд томоохон өөрчлөлтүүдийг хийсэн.

Энэ өөрчлөлтийн хүрээнд шүүхийн чиглэлээр томоохон бодлогын арга хэмжээнүүд энд тусгагдсан байгаа.

Энэ дотор шүүгчийг шилж олох, давтан сургах, хараат бус бие даасан байдлыг нь хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн орон тооны Үндсэн хуулийн байгууллага болгон хуульчилсан.

Мөн шүүгчийн сахилга, хариуцлагыг чангатгах, шүүгч хүн зөвхөн хуульд захирагдан ажиллах, өргөсөн тангарагтаа үнэнч байх, зөрчсөн бол хариуцлага гарцаагүй байх зарчмын хүрээнд Шүүхийн сахилгын хороог мөн Үндсэн хуулийн байгууллага болгон хуульчилсан байгаа.

Түүнчлэн Үндсэн хуулийн өөрчлөлтийг нэг мөр хэрэгжүүлэх, шүүхийн шинэчлэлийг улам гүнзгийрүүлэх, шүүхэд мэдүүлэх эрхийг хангах зорилгоор Монгол Улсын шүүхийн тухай хуулийг мөн шинэчлэн баталсан.

Өнөөдрийн баталсан бидний энэ бодлогын баримт бичгийн зорилт ч гэсэн хараат бус, шударга, мэдлэгтэй, ур чадвартай, иргэдийн итгэлийг хүлээсэн, нээлттэй шүүх, шүүгчтэй байхад чиглэж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол шүүх засаглалын ирэх 10 жилийн замын зураглал, түүнд хүрэхийн тулд бүхий л байгууллагын оролцоо, хүчин чармайлтыг илэрхийлсэн ийм томоохон баримт бичиг боллоо.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд шүүх эрх мэдлийн хууль, эрх зүйн орчин, шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт шинэчлэгдэн өөрчлөгдөж ирсэн боловч шүүхийн бие даасан хараат бус байдлын суурь нөхцөл болсон шүүхийн эдийн засгийн баталгааг хангах ажил үндсэндээ орхигдож ирснийг энд бас хэлье.

Би нэг жишээг хэлье. Анхан болон давж заалдах шатын **116 шүүх** зориулалтын бус байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ хэрээр иргэд шүүхийн үйлчилгээг шуурхай, чанартай авах эрх мөн хөндөгдөж байгаа юм.

Шүүх хуралдааны танхимын хүрэлцээгүй байдлаас хамаараад шүүх хуралдаан хойшлох үндсэн шалтгааны нэг болж байна.

Энэ нь хэрэг маргааныг цаг хугацаанд нь шийдвэрлэхэд зарим талаар сөргөөр нөлөөлж байна.

Шүүхийн тээврийн хэрэгсэл **73 хувь** нь ашиглалтын хугацаа нь дууссан байна.

Компьютер, техник хэрэгсэл шинэчлэлийн шаардлагын түвшинд хийгддэггүй. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны орон тоо олноор дутуу явж ирсэн байгаа.

Шүүхийн асуудал нь зөвхөн шүүгчийн асуудал бус нөгөө талдаа шүүхээс үйлчилгээ авч байгаа иргэдийн эрх ашиг ямагт хамт явж байдаг гэдгийг санах ёстой.

Бид шүүхээс хууль дээдлэхийг шаардаж шударга ёсыг нэхэх нь зүйн хэрэг боловч ажиллах нөхцөл, ажлын ачаалал,

мэргэшил, мэдлэгээ дээшлүүлэх, эдийн засаг, нийгмийн баталгааг хангах төрийн үүргээ ч мөн биелүүлэх учиртай.

Ийм учраас шүүхийн байгууллагад учирч байгаа эдийн засгийн баталгааны асуудал болон шүүгч хариуцлагатай, мэргэшсэн, чадварлаг байх, шүүхийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор нь авч үзэж, шүүх эрх мэдлийн цаашдын 10 жилийн хугацааны хөгжлийн бодлогыг одоо ийнхүү баталж байна.

Хариуцлагатай, нээлттэй, иргэн төвтэй, шүүхтэй байх зорилгод үндэслэн цаашид шүүгч төвтэй бус иргэн төвтэй шүүх байгуулахыг гол зорилгоо болгож байгаа. Энэ бол концепцын томоохон өөрчлөлт гэдгийг хэлье.

Төсөв, санхүүгийн хувьд хүрэлцээгүй байдал нь шүүхийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулаад зогсохгүй хамгийн гол нь иргэд олон нийтэд хүрэх шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашигтай байдалд сөргөөр нөлөөлж байна.

Тарчиг төсөвтэй, бусдыг царайчлан түрээсийн байранд ажилладаг шүүх Монгол Улсад байх ёсгүй.

Энэ оноос эхлээд ирэх 10 жилийн хугацаанд Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын хүрээнд шүүхийн хөрөнгө оруулалтыг шаардлагатай хэмжээнд улсын төсөвт тусган хэрэгжүүлэх эрх зүйн суурь орчин бүрэн бүрдэж байгааг энд бас тэмдэглэн хэлье.

Шүүхийн үйлчилгээний чанар, шуурхай байдалд ахиц дэвшил гарах ёстой гэдгийг мөн тухайлан хэлье.

Шүүхийн үйлчилгээ авахаар ирсэн иргэддээ олон дахин явуулдаг, чирэгдүүлдэг, хэрэг маргааныг хэдэн жилээр шийдэлгүй залхаадаг гажуудал арилж, шүүхэд мэдүүлэх эрхийн хэрэгжилтэд чанарын ахиц гарна гэж бид үзэж байна.

Ийм ч учраас шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг сайжруулах нэг арга зам бол **“цахимжилт”** гэж үзэн шүүх эрх мэдлийн салбарт аюулгүй байдал хангагдсан мэдээллийн технологийн дэвшлийг өргөн хүрээнд үе шаттайгаар нэвтрүүлэхээр бодлогын энэ баримт бичигт мөн тусгасан байгаа.

Ингэснээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг шинэ шатанд гаргах, цахим хавтаст хэрэг бий болж, хэргийн оролцогчид хэрэгтэйгээ танилцахад цаг алдахгүй, зардал хэмнэх зэрэг олон эерэг үр дагавар гарна гэж найдаж байна.

Эцэст нь хэлэхэд бодлогын баримт бичгийг дэмжин баталсан Улсын Их Хурлын эрхэм гишүүд, хэлэлцүүлэгт бэлтгэсэн ажлын хэсгийн гишүүд, дэд ажлын хэсгүүдэд мөн тал жаргал илэрхийлье.

Шүүх ерөнхий зөвлөл шүүх эрх мэдлийн бусад байгууллага энэхүү бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, бодит үр дүн гаргана гэдэгт итгэж байна.

Ингээд энэ бодлогын баримт бичгийг боловсруулсан Шүүх ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Улсын дээд шүүх, Монголын хуульчдын холбоо, Хууль зүй, дотоод хэргийн яамны болоод Улсын Их Хурлын Тамгын газрын нийт

ажилтан албан хаагч Та бүгдэд талархаж байгаагаа илэрхийлье.

Санал хураалтыг явуулъя. Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураая.

Санал хураалт. /алх цохив/

54.1 хувиар санал дэмжигдлээ. /алга ташив/

Тогтоолын төсөл батлагдлаа. /алх цохив/

Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийнхаа асуудалд оръё. **17:07**

Долоо. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Б.Энхбаяр: (22-р тойрог, Баянзүрх дүүрэг)

Улсын Их Хурлын эрхэм дэд дарга, гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч хүчин зүйл болсон авлигатай тэмцэх, түүний шалтгаан нөхцөлийг арилгах нь Та бидний хамтын эрхэм зорилго билээ.

Тийм ч учраас Засгийн газраас 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласан.

Энэ хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг арилгаж, бүх шатад авлигатай тэмцэн, хүний эрхийг хангаж, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Засгийн газраас хууль, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлж, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгон, иргэд олон нийтийн оролцоо, хяналт тавих боломжийг өргөжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас нэн тэргүүнд авлига албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах өөрчлөлтийг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Та бүхэн бид хамтдаа баталж, өнөөдөр хэрэгжиж эхлээд байна.

Авлигатай тэмцэх гол арга замын нэг бол төрийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал бөгөөд энэ хүрээнд Улсын Их Хурлаас бүртгэлийн багц хууль,

цахимын багц хууль болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, эдгээр хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан амжилттай хэрэгжүүлж ажиллаж байна.

Үүний үр дүнд Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргадаг цахим засаглалын индексээр 18 байраар урагшлаад байна.

Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2023 онд дууссантай холбогдуулан авлигатай тэмцэх цогц арга хэмжээг агуулсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг өнгөрсөн онд Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газраас боловсруулсан бөгөөд төлөвлөгөөний төсөлд Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т заасан 11 зорилго, 48 зорилтыг хангах чиглэлээр 2023-2030 онд 295 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан ба төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлэлдэх болно.

Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлснээр авлигагүй төр, нийгмийг цогцлоож, шударга ёсыг тогтоон, ард түмнийхээ алдагдсан боломж, эрхийг сэргээхэд жинтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Тогтоолын төслийг хэлэлцэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Б.Энхбаяр сайдад баярлалаа.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэн танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Ц.Сэргэлэн: (7-р тойрог, Дорнод аймаг)

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан.

Уг тогтоолын 2 дахь хэсэгт Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж Улсын Их Хуралд өргөн

мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасны дагуу “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг D-Parliament.mn сайтад байрлуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед

- Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар **“Transparency International”** байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигалын төсөөллийн индексийн үзүүлэлт өмнөх оныхоос буурсан. Энэ шалтгааныг арилгах арга хэмжээ тогтоолын төсөлд хэрхэн тусгасан болон Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааны талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг улс төрийн намын санхүүжилтийн талаар, мөн сонгуулийн зардлыг бууруулах арга хэмжээний талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хөтөлбөрөөс гарах эцсийн үр дүн, хэмжих шалгуурын талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар авлигад өртөж болзошгүй төрийн дунд шатын албан хаагчдад чиглэсэн бодлого, арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авсан болно.

- Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайжруулах, шинэ шатанд гаргах талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг сонгууль дахь мөнгөний нөлөөг бууруулах, албан тушаалтан, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх ач холбогдлын талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө зэрэг нь нийтийн албан тушаалтны дунд шатад орхигдолгүй хэрэгжиж, авлигалыг бүх талаар таслан зогсоох зарчмыг хэрэгжүүлэх гол хөшүүрэг болохыг анхаарах талаар үг хэлсэн болно.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ц.Сэргэлэн гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ганзоригийн Эрдэнэбулган, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Мягмарцэрэнгийн Давааотгох, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Лхагважавын Сүх-Очир, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Доржсүрэнгийн Дуламсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Мөнхжаргалын Ганбагана нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Хэн байна? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Б.Баярсайхан гишүүн, Б.Бат-Эрдэнэ гишүүн нарыг нэмье. Б.Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг асуултаа асууя.

Ц.Мөнхцэцэг: (24-р тойрог, Сүхбаатар дүүрэг)

Тэгэхээр авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг нэг бүрчлэн хэрэгжүүлэх төлөвлөгөө асар чухал байгаа.

Монгол Улсын хувьд авлигалын төсөөллийн индексээр хэдэн байр ухарсан дүн гарчихсан байгаа.

Хэдийгээр Улсын Их Хурал авлигалын эсрэг хатуу хуулиудыг баталж, авлигалын улмаас үндэслэлгүй хөрөнгөжсөн этгээдүүдийн хөрөнгийг хураах, авлигын гэмт хэрэгт ял хялбаршуулах журмаар шийдэхгүй байх зэрэг эрүүгийн томоохон шинэчлэлүүд хийгээд байгаа боловч яг олон нийтийн дунд, иргэдийн дунд авлигатай хийж байгаа Монгол төрийн энэ тэмцлийн талаарх мэдээлэл дутуу.

Ер нь авлигалын талаарх иргэд, олон нийт, хувь байгууллагуудын талаарх энэ тэмцэлд нэлээн ач холбогдол өгч, ер нь авлигалын эсрэг илүү хүчтэй тэмцэл, реформыг шаардсаар байгаа.

Тэгээд энэ жилийн 2023 оны Авлигалын төсөөллийн индексийн талаар Монгол Улс дахь нөхцөл байдалд “**Transparency International**” байгууллага тодорхой зөвлөмжүүд өгсөн байгаа.

Тэр зөвлөмжид яг энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт нэлээн сайн сууж өгсөн байгаа. Тухайлбал, “**Transparency International**” байгууллагын нэг гол зөвлөмж бол төрийн өндөр албан тушаалтнуудын орлого ба зарлагын мэдүүлгийг аль алийг нь хянадаг болох тогтолцоо байгаа.

Өөрөөр хэлбэл одоогоор ямар ч байсан орлогоо мэдүүлдэг. Зарлагыг мэдүүлэхгүй байгаа. Зарлага дээр хяналт тавихгүй байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг энэ төлөвлөгөөн дээр оруулсан байгаа. Энэ их чухал.

Дараагийн бас нэг олон улсын байгууллагаас өгч байгаа зөвлөмж бол нөгөө ковидын үеэс хойш ер нь иргэдийн мэдэх эрхийг хангах чиглэлээр ер нь Монголын төр хангалтгүй ажиллаж байна.

Иргэдийн мэдэх хэрэг хангалтгүй байгаа учраас нөгөө авлигалын эсрэг хийж байгаа энэ тэмцэл, үйл ажиллагаа маань ерөөсөө олон нийтэд хүрэхгүй байгаа юм.

Тэгэхээр энэ чиглэл дээр төлөвлөгөөн дээр оруулсан шинэ зүйлийг ер нь хэлэх шаардлагатай байх.

Дээр нь манай төрийн бүх шатдаа, ялангуяа төрийн албан хаагчдын хүний эрхийн болон авлигын эсрэг шударга ёсны талаарх мэдлэг, мэдээлэл дутуу байгаа. Энэ нь авлигалын төсөөллийн индексийг бууруулах бас нэг чухал зүйл гэж олон улсын экспертүүд зөвлөсөн байгаа.

Тэгэхээр төрийн албан хаагчийн дундах авлигалын болон шударга ёсны мэдлэг, мэдээллийн чиглэлээр хэр ажил хийхээр төлөвлөж байгаа вэ гэдгийг нэгдүгээрт асууя.

Мөн тодорхой нэг анхаарах зөвлөмж бол энэ төрийн зарим албан тушаалтнууд авлигалын гэмт хэрэг, авлигалын нөхцөл байдалд халдашгүй дархан байдал гэдгээр нэрийдэн гэмт хэрэг, ял завших явдал байсаар байна. Энэ чиглэлээр ажиллах шаардлагатай гэдэг ийм зөвлөмжийг өгсөн байгаа.

Мөн олон улсын зээл, тусламж, хандивлагчдын талаарх мэдээллийг бас олон нийтэд ил болгох шаардлагатай гэдэг энэ зөвлөмжийг өгсөн байна.

Тэгээд мөн бас нэг анхаарал хандуулах зүйл нь нөгөө төрийн компаниудын шударга ёсны болон

авлигалын талаарх олон кэйст нэр холбогдсон төрийн өмчит компаниудын засаглалыг ил тод болгох асуудал дээр ихээхэн анхаарал тавьж, үүнийг бид хийж чадахгүй бол энэ авлигалын талаарх олон нийтийн үнэлэмж буусаар байна гэдгийг хэлсэн байгаа.

Тэгэхээр саяын “Transparency International” байгууллагын нэр дурдсан эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх тухайд яг төлөвлөгөө дээр тухайлан ямар ямар асуудлууд орж байгаа вэ гэдгийг ажлын хэсгээс асууя.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Хэн хариулах вэ? М.Даваатогтох дарга хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

М.Даваатогтох: Гишүүний асуултад хариулъя.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030 оны хооронд 8 жилийн хугацаанд хэрэгжинэ.

Энэ хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг бүхэлд нь төлөвлөж оруулж ирж Та бүхэнд танилцуулж байгаа.

Авлигын төсөөллийн индексийг бууруулах чиглэлээр бүх шатандаа ажиллахаар төлөвлөгөөнд тусгагдсан байгаа.

Нэг зүйлийг тодруулж хэлэх ёстой гэж бодож байна. Авлигалын төсөөллийн индекс гэдэг энэ өөрөө нэршил нь ийм нэртэй. Энэ бол яг бодитой 100 хувийн үнэлэлт биш. Өөрөө энэ чинь “төсөөллийн индекс” гэдэг ийм зүйл байгаа.

Авлигалын төсөөллийн индекс дээр дурдагдсан байгаа иргэдийн мэдэх эрхийн

тухай асуудал дээр хэд хэдэн чиглэлийн асуудал энэ дээр байгаа. Энэ хууль тогтоомжийг батлах явцад оролцох иргэдийн оролцооны асуудлыг төлөвлөгөөнд тусгасан.

Монгол Улс өөрөө Хууль тогтоомжийн тухай хуулиараа нэлээн сайн зохицуулалттай. Гэхдээ үүний хэрэгжилт дээр анхаарч ажиллахаар ингэж тусгасан байгаа.

Мөн түүнчлэн **e-mongolia** гээд манай цахим платформ байгаа. Сая бид энэ 2 сарын сүүлээр авлигалын чиглэлээр ажиллаж байгаа Зүүн Өмнөд Ази болон Номхон далайн орнуудын уулзалтад оролцоод ирлээ.

Энд Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон **e-mongolia** гэдэг энэ платформ сайн жишээ болоод саяын бүс нутгийн хэмжээнд ирэх 3 жилд бусад орнуудад хэрэгжигдэхээр уриалагдсан байгаа. Энэ ажлуудыг сайжруулахаар энэ төлөвлөгөөнд тусгагдсан байгаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 8 дугаар зорилго бүхэлдээ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн засаглалыг сайжруулах, зардлыг багасгах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр тусгасан бүхэл бүтэн ийм зорилго байгаа.

Энэ зорилгын хүрээнд саяын авлигалын төсөөллийн индексийг үнэлэх үед гарсан зөвлөмжийн энэ хамаарах заалтууд тусгагдаад явна.

Мөн төрийн өндөр албан тушаалтнууд болон нийт төрийн албан хаагчдын зарлагыг хянах тухай асуудал төлөвлөгөөнд тусгагдсан байгаа.

Хариулж дууслаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Тодорхой хариулчихлаа.

Б.Энхбаяр сайд аа, М.Даваатогтох дарга аа, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө бид хэлэлцээд байгаа юм.

Монгол Улсын Их Хурлаас баталсан их олон хөтөлбөрүүд байдаг.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг өнгөрсөн жил батлан гаргасан. Гайгүй сайн хөтөлбөр болсон.

Төлөвлөгөөг нь одоо ингээд Улсын Их Хурал батлаад ирэхээр цаашдаа ч гэсэн олон хөтөлбөрүүдийн бүх төлөвлөгөөг нь Их Хурал баталдаг ийм жишиг рүү явах гээд байна л даа.

Авлигын эсрэг хуульд ийм заалт байгаа учраас энэ заавал Их Хурлаас батлахаас аргагүй гэж байх шиг байна.

Тэгэхээр цаашдаа Б.Энхбаяр сайд аа, Засгийн газар үүнийгээ баталдаг. Засгийн газрын хүрээний байгууллагууд нь.

Их Хурлын дэргэдэх байгууллагууд буюу Төрийн албаны зөвлөл байдаг юм уу, Статистик байдаг юм уу, Монголбанк, бусад байгууллагууд энэ авлигатай тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлуудыг нь Их Хурлын дарга баталчихдаг ч юм уу. Тийм ээ. Ийм байдалтайгаар ер нь зохицуулалт хийх нь зүйтэй байх. Зүйтэй байх.

Үүнийг холбогдох эрх зүйн үндсийг нь Та бүхэн Авлигын эсрэг хуульд

өөрчлөлт оруулах төслийг оруулж өгөх нь зүйтэй байх гэдгийг энд хэлбэ.

Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн дарга үг хэлбэ.

Д.Тогтохсүрэн: (10-р тойрог, Өвөрхангай аймаг)

Баярлалаа. Өнгөрсөн жил Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан.

Өнөөдөр энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө орж ирж байна.

Тэгээд Хууль зүйн хороогоор хэлэлцээд орж ирж байна.

Би үүнтэй холбогдуулаад хоёр зүйл дээр хариулт авъя гэж бодож байна. Ажлын хэсгээс.

Нэг дэх асуудал. Энэ авлигын индексийн асуудал байгаа юм. Одоо энэ хэвлэл мэдээллээр явж байгаа мэдээллийг хараад байхаар, олон улсын судалгааны байгууллагаас гаргасан мэдээллийг хараад байхаар Монгол Улсын авлигын индекс буурчихсан. 20-оос 40 байр ухарчихсан л гэж яриад байгаа байхгүй юу.

Гэтэл саяын Байнгын хорооны юун дээр 20 байраар буурсан юм орж ирж байгаа байхгүй юу. Ярьж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр яг нэг албан ёсны. Манайх өнгөрсөн жил хэдэд байсан юм, одоо хэдэд орсон юм гэдгийг яг тодорхой олон түмэнд тайлбарлаад хэлээдхээч. Авлигын индексийг.

Хоёр дахь асуудал нь, энэ эрүүгийн хэргийн, тэр дотроо авлига албан

тушаалын гэмт хэргийн улмаас нийгэмд бий болсон хохирлыг барагдуулж байх асуудал их чухал байгаа юм.

Өнөөдөр олон түмэн биднээс юу хүсэж байна вэ гэхээр авлига, албан тушаалын гэмт хэрэг дээр хамгийн их хүсэж байгаа юм хөрөнгийг нь хураах, авлига албан тушаалын гэмт хэргийн улмаас олсон орлогыг нь хураах л асуудлыг хамгийн түрүүнд тавьж байгаа байхгүй юу.

Бид энэ дээр нэг тодорхой тоотой баймаар байгаа юм.

Түрүүн манай М.Оюунчимэг гишүүн хэлээд байна лээ. Хэн. Уучлаарай. Ц.Мөнхцэцэг гишүүн.

Ер нь Улсын Их Хурал **хангалттай эрх зүйн орчныг бүрдүүлж өгч байгаа.**

- Эрүүгийн хуулийг нь өөрчилж, ялын бодлогыг нь чангатгаж өгсөн.
- Авлигын эсрэг хуульд нь өөрчлөлт оруулж, тодорхой албан тушаалтнууддаа хүртэл хориг тавьж өгсөн.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль гээд олон хуулиудад нь бид өөрчлөлт оруулж өгсөн.

Гэтэл нөгөө том үр дүн гарч байна уу, үгүй юу гээд ард түмний хүсэн хүлээж байгаа үр дүнд бид хүрч чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбогдуулаад хамгийн гол тэдний хүсэж байгаа юм юу байна вэ гэхээр үүнийг яриад байгаа юм.

Хамгийн гол нь тэр авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг нь хурааж байна уу, орлогыг нь хурааж байна уу гэдэг асуудал байгаа.

Тэгээд би одоо юу гэж асуух гэж байна гэхээр Авлигатай тэмцэх газраас хэрэв тоо статистик байвал 2022, 2023 онд хоёр оныг харьцуулаад, энэ шинэ хууль гарснаас хойш ийм хөрөнгийг хураалаа. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оролцсон ийм орлогыг хураалаа, ийм торгуулийн ял орж ирлээ.

Ингэснээрээ улсын төсөвт ийм хэмжээний юм орж байна гэдэг энэ тоог нэг албан ёсоор хэлээдхээч.

Бидэнд яах вэ, Сангийн яамнаас авсан тоо бий.

Ер нь танай гаргасан тоог би нэг сонсьё гэж бодож байгаа юм.

Хамгийн чухал юм бол ард иргэдийн хүсээд байгаа юм энэ хөрөнгийг нь хураах ёстой. Тэгээд ялын бодлогыг нь чангатгах ёстой гэдэг ийм л асуудал байгаад байгаа юм.

Ийм хоёр зүйлийг тодруулъя.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Асуултад хариулъя. М.Даваатогтох дарга хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

М.Даваатогтох: Гишүүний асуултад хариулъя.

Энэ хохирол нөхөн төлөлтийн мэдээг эхлээд хариулчих уу.

Энэ дээр Монгол Улсын Авлигатай тэмцэх газар 2022 онд **2.3 их наяд** төгрөгийн хохирлыг төр, нийтийн эрх ашигт учирсан хохирол, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд учирсан хохирол, иргэн, аж ахуйн нэгжүүдэд учирсан

хохирол гэдэг. Өөрөөр хэлбэл нийт мөрдөн шалгах ажиллагааны явцад учирсан хохирогчдыг оролцуулаад **2.3 их наяд** гэдэг төгрөгийг барагдуулсан.

Энэ дээр Авлигатай тэмцэх газрын удирдлагын зүгээс сая гишүүний асуусан тэр гэмт хэргийн улмаас, авлигын улмаас учраад байгаа тэр иргэд, нийтийн эрх ашгийг сэргээх чиглэлд онцгой ач холбогдол өгч ажилласан.

Энэ 2.3 их наяд гэдэг төгрөг тоо бүгд ардаа санхүүгийн анхан шатын баримтаар нотлогдож байгаа ийм тоо. Ийм байхыг бас шаардлага тавьж ажилласан.

Энэ дээр тодорхой Төрийн өмчит компаниуд хууль бус замаар бусдын эрх мэдэлд, эзэмшилд шилжсэн байсныг буцааж авсан ийм хохирлууд орсон.

Дээр нь Монгол Улсын Хөгжлийн банкны гэх хэрэг дээр бас нэлээдгүй өндөр ач холбогдол өгч, прокурорын байгууллагатай хамтарч ажилласны үр дүнд **880.0 тэрбум** төгрөгийг барагдуулж, бас Хөгжлийн банк нэлээн санхүүгийн хүндрэлд орчихсон байсан хэрэг дээр ач холбогдол өгч, үр дүн гаргаж ажилласан гэдэг юм уу.

Ингээд нийт 2002 онд **2.3 их наяд** байгаа.

2023 онд **238.0 тэрбум** төгрөгийн хохирлыг холбогдох этгээдүүдэд барагдуулсан ийм тоон үзүүлэлттэй ажиллаж байгаа.

Тэр эхний асуулт. Авлигын төсөөллийн индексийг бууруулах чиглэлээр.

Авлигын төсөөллийн индекс гэдгийг түрүүн хэлсэн байгаа. Энэ бол

өөрөө төсөөллийн индекс. “Transparency International” гэж төрийн бус олон улсын байгууллагаас нэгтгэдэг ийм тоон үзүүлэлт.

Монгол Улсын хувьд оноо өөрөө 100 хувь байж хамгийн цэвэр гэдэг ийм үнэлэгддэг. “Тэг” бол хамгийн муу гэдэг үнэлэгддэг ийм хэмжигдэхүүнээр хэмжигддэг байгаа. Монгол Улсын тухайд

- 2021 онд 35 оноотой,
- 2022 онд 33 оноотой,
- 2023 онд 33 оноотой гээд

ингээд явж байгаа.

2022 онд 33 оноотой 116-д үнэлэгдсэн, 2023 онд адилхан 33 оноотой хэрнээ 121 дүгээр байранд гээд орчихсон байгаа.

Учир нь 33 оноотой үнэлэгдсэн улсууд давхацсантай холбогдуулаад энэ тоо ингэж доошоо бууж 21 гэдэг 5-аар нэмэгдчихсэн тоон үзүүлэлт харагдаж байгаа боловч ерөнхий тухайлсан үнэлгээ 33 гэдэг үнэлгээ хэвээрээ байгаа гэж ойлгохоор байгаа. Тийм. Оноо бол яг ижил.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ойлголоо. Оноо нь бол хэвээрээ. Гэхдээ байр нь өөрчлөгдсөн талаар сая тодорхой тайлбарлачихлаа.

2022 он, 2023 оныхоо нөхөн төлүүлсэн юуг хэлчихсэн. Тийм ээ. Хариулчихсан байгаа.

Дараагийн гишүүн асууя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг асууя.

М.Оюунчимэг: (25-р тойрог, Чингэлтэй дүүрэг)

Яагаад энэ авлигал, албан тушаалын хэрэг өөрөө ноцтой үр дүнтэй юм бэ гэхээр энэ нь өөрөө ард иргэдийн маш их боломжийг хулгайлж байгаа зүйл гэж тодорхой харагдаж байна шүү дээ.

Өнөөдрийн энэ утаа униар, түгжрэл, энэ газрын наймаа, энэ бүхэн чинь яаж байна. Дахиад л нөгөө хүмүүсийн эрүүл саруул амьдрах энэ орчинд хүртэл сөрөг нөлөө үзүүлж байна.

Бид “Нүүрсний сонсгол”-оос юу олж харав. Сая “Эмийн сонсгол”-оос иргэд монгол хүний эрүүл мэндээр хэд нугалсан бизнес хийж байна. Хийх хийхдээ бүр стандартын бус, чанаргүй, гарал үүсэл нь тодорхойгүй хэдэн мянгаар нь эм оруулж ирээд шахаж байна гээд асуудал нэлээд ноцтой байсан.

М.Даваатогтох комиссар маань өөрөө бас оролцсон.

Ер нь эндээс дүгнэлт хийж, хүмүүс одоо харж байна л даа. Тэгээд хариуцлага тооцох юм уу?

Эрүүл мэндийн яамны яг нөлөө бүхий зарим албан тушаалтнууд нь өөрөө компанийн ашиг сонирхлын төвлөрөл нь болчихсон.

Хэдхэн эмийн компани монопол үүсгээд 800 гаруй тэрбум төгрөг эргэлдэг. Энд нөгөө ард иргэдийн ачааллыг бууруулах биш харин ч стандартын бус, чанар шаардлага нь хангасан, хангаагүй нь мэдэгдэхгүй зүйлүүдийг оруулж ирж байна гээд.

Одоо тэгээд хүлээлт үүсэж байна л даа. Хариуцлага тооцох уу? М.Даваатогтох комиссар аа, та бас орсон хүний хувьд эмийн сонсголоос ямар дүгнэлт хийж

болохоор байна? Зөвхөн сүүлийн жишээн дээр харахад.

Та болон ер нь шинжээч, хянан шалгагч нар хэлж байсан л даа.

Нийтийн албан тушаалтан нь зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ гэж энд бичсэн байна л даа. Зорилт гэж.

Энэ нь хэрэгжих гэдэг бол нэлээд хугацаа шаардагдана.

Сая жишээлбэл тэр **“Эмийн сонсгол”** дээр харахад тухайн өндөр алба албан тушаалд очихдоо хөрөнгө орлогын мэдүүлэг дээрээ тусгаагүй. Тэр албан тушаалд очсоны дараа нөгөө хамааралтай болчихсон зүйлүүд хүртэл нэлээд их гарлаа шүү дээ. Тийм ээ.

Иймэрхүү зүйл дээр одоо яах вэ? Жишээ нь, энэ “Эмийн сонсгол”-ын үр дүнгээс асуудлыг бас энэ түр хорооны дарга, түр хорооноос тодорхой зүйлүүд дээр үүнийг шалгаж үзээч ээ гэж Та бүхэнд хандаж байгаа.

Тэгэхээр энэ дээр Та нэг хариулт өгөөч. Яах вэ?

Бид иргэдийг эрүүл байгаасай, нийгмээ эрүүл болгоё, чанартай эм, эмийн үйлчилгээг дэлхийн зах зээлийнх нь үнээр нь авчирья гээд бараг 800-аад тэрбум төгрөг энэ зах зээлд нь эргэлдэж байна.

Салбарынх нь төсвийг нь хэд дахин нэмж өглөө. Эмийн салбарын санхүүжилтийг нь 40 тэрбумаас 137 тэрбум болгож нэмж.

Энэ нь өөрөө иргэд чанартай эрүүл мэндийн үйлчилгээ аваасай, эмээс хамааралтай битгий болоосой, үнэ нь тодорхой хэмжээндээ буураасай. Дээрээс нь чанартай байгаасай гэж зорьж байсан.

Тэгээд сая асуудал нэлээд хүнд түвшинд ирж байна шүү дээ.

Тэгэхээр хүмүүс харж байна.

Б.Энхбаяр сайд өчигдөр Байнгын хорооны хурал дээр “Нүүрсний сонсгол”-ын үр дүнгийн талаар яриад л байсан.

Тэгээд сүүлдээ энэ олон сонсгол, энэ төр, Улсын Их Хурал, Хянан шалгах хороо гээд л байдаг. Тэнд нь хууль, хүчний байгууллагууд нь ороод байдаг. Тэгээд яг цаашдаа энд үр дүн гарсан юм уу, гараагүй юм уу. Тайлагнах, мэдээлэх нь хаалттай.

Сая энэ зорилт дээр та нар оруулж ирсэн байна л даа. Цахимаар мэдээлэхэд тэр системийг бүрдүүлнэ гээд.

Тэгээд энэ маань хэзээ ч болох юм. Энэ болтол жишээлбэл сүүлийн хоёр сонсголын үр дүнг иргэд хүлээж байна.

Яагаад гэвэл энд бид хүний муу үзэх гээд байгаадаа биш. Иргэдийн боломжийг хулгайлсан, ялангуяа эрүүл мэндэд нь энэ бол ноцтой нөлөө үзүүлж байгаа асуудал шүү дээ. Иргэдийн эрүүл мэнд, амь насанд нь. Тийм ээ. Энэ бол байж боломгүй зүйл.

Тэгэхээр ийм зүйлүүд дээр яах вэ? Ихэнх нь хамаарал бүхий өндөр албан тушаалтнууд байж болох тэр магадлалыг баримт нотолгоон дээр шинжээч, хянан шалгагч нар гаргаж ирж тавьж байна лээ.

Одоо тэр хүмүүс тодорхой нотлох баримт л гэж ярьж байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн минь нэг хариулт өгөөч ээ.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Авлигатай тэмцэх газрын хэлтсийн дарга М.Даваатогтох хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг.

М.Даваатогтох: Таны асуултад хариулъя.

Гэмт хэргийн шинжтэй процессын харилцааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байгаа.

Мөрдөх алба гэдэг юм уу, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага иргэн, хуулийн этгээдээс ирсэн өргөдөл, гомдлыг хүлээж аваад 5 хоногийн дотор эхний шалгалтыг хийж байгаа.

Шаардлагатай гэж үзвэл тухайн албаны дарга 14 хоног хүртэл сунгана. Үүний дараа хэрэг нээх эсэх асуудлыг прокурорын байгууллагад танилцуулаад, ингээд шийдээд хэрэг бүртгэлтийн хэрэг нээгээд, дараа нь хэрэг бүртгэлтийн шатад гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал тогтоогдвол яллагдагчаар татаад, ингээд процедур явдаг. Хуулийн процедурын хувьд.

Бид Эмийн хянан шалгах хорооноос ирсэн гэмт хэргийн шинжтэй энэ мэдээллийг яг саяын хуульд заасан чиг үүргийнхээ дагуу энэ бол манай үүрэг, байгууллагын үүрэг.

Энэ үүргийнхээ дагуу бид мөрдөн шалгах ажиллагаа явуулна. Энэ дээр ямар нэгэн өөр явуулна, явуулахгүй гэсэн юм

байхгүй. Энэ бол хуулиар хүлээсэн байгууллагын үндсэн үүрэг. Нэг талдаа.

Дараагийн асуудал бол манай дээр хэд хэдэн ийм эмтэй холбоотой асуудал шалгагдаад явж байгаа.

Бид Хянан шалгах хорооны хүмүүстээ зүгээр нээлттэй байж болох мэдээллийн талаар манай Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн мэдээллүүдийг тухайн үед байж болох хэмжээнд нь хамтраад. Энэ нь яах вэ, манай байгууллагын зорилго.

Удирдлагаас барьж байгаа зорилго бол энэ эмийн асуудал дээр монгол хүн хохирох ёсгүй.

Эмийн энэ хууль бус бизнесээс болж монгол хүн хохирох ёсгүй гэдэг ийм л байр сууриас Хянан шалгах хороотой хамтарч ажиллаж байсан.

Тэгэхээр бид хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээд ажиллана.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Одоо Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Энэ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа.

Энэ бүрэн эрхийн хугацаанд Улсын Их Хурал, Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлээр олон хууль, эрх зүйн орчныг бий болгох, энэ хөтөлбөр, олон

арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа юм.

Тухайлах юм бол Засгийн газар энэ 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгож зарласан. Энэ сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд анх удаа.

Ерөөсөө улс орон урагшаа хөгжихгүй байгаа, ард түмний амьдрал ядуу зүдүү байгаа, энэ нийгэмд баян хоосны ялгаа гарсан, энэ эх орныхоо үндэсний баялагт эзэн байж чадахгүй байгаа, энэ төрийн төсвийн хөрөнгө мөнгө ямар замаар үрэгдэж, үр ашиггүй хулгай зэлгийд алдаж ингэж байгаагийн цаад шалтгаан ерөөсөө л авлигал, ашиг сонирхолтой холбоотой л асуудал.

Үүнийг хэн хэлсэн. Дээрээсээ л эхлэх ёстой. Дээрээсээ л эхлэх ёстой.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг эхэлж баталж авсан шүү дээ. Бид нар.

Нөхдүүд маань ер нь төрийн албан хаагчдынхаа ёс зүйн тухай хуулийг баталъя гэсэн ийм санал байр суурьтай. Бид бол тэгж болохгүй.

Ерөөсөө шатны гишүүрийг дээрээс нь шүүрдэнэ. Доороос нь шүүрдээд хэзээ ч цэвэрлэгдэхгүй.

Тэгээд ийм байр суурьтай байж Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм. Энэ олон асуудлыг дотор нь тусгаж өгсөн, зохицуулж өгсөн, хааж хорьж өгсөн ийм хууль байгаа.

Дээрээс нь үүнтэй холбогдуулаад Эрүүгийн хууль, нөгөө 40 сая төгрөгөөр

- ял наймаалцдаг,
- магадланд ордог,

- хөөн хэлэлцэх хугацаа дуусдаг,
- хөнгөрүүлдэг энэ бүх юмыг хааж өгсөн.

Ялын бодлого нь 12-оос 20 жил болж яс цоожин цагаан захтнууд суухаар ингэж хуульчлагдаж өгсөн.

Тэгээд цаашлах юм бол энэ ашиг сонирхлын хууль байгаа.

Ашиг сонирхлын хууль дээр одоо тэр 201.1, 201.2 гээд энэ хоёр заалт дээр “хүүхэд” гэдэг ангилалд ерөөсөө эх, эцэгтэйгээ хамтарч амьдарч байгаа хүүхдүүд хамаарахаар ингээд оруулчихсан.

Үгүй ээ, энэ чинь одоо аавтайгаа, ижийтэйгээ адилхан дарга болоод явж байгаа хүүхэд чинь 18 нас хүртэл хүүхэд байна гэж байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ хуулийн заалтыг засах ёстой.

Үүний цаад талд нь ямар хууль гаргах ёстой вэ гэхээр хүлээгдэж байгаа юм бол энэ орлогоо, хөрөнгө орлогоо нотолж чадаагүй төрийн өндөр дээд ажил, албан тушаалтнууд үг дуугүй хариуцлагаа хүлээж, орлогоо нотолж чадаагүй тэр хөрөнгөө улсад хураалгадаг ийм хууль эрх зүйн, бусад улс орнуудын жишгээр ийм хууль эрх зүйн орчныг бий болгох шаардлагууд байгаа.

Тийм учраас хуулийнхаа юмнуудыг ер нь бүрэн хэмжээнд хийж явах ёстой.

Байнгын хороонд хороон дээр хэлэлцэгдсэн энэ дүгнэлтээс харах юм бол ер нь төрийн дунд шат гээд ингээд өөрсдөөсөө доош нь чихээд байгаа юм.

Ингэж чихэж болохгүй.

Өнөөдөр ч гэсэн хэрэг асуудалтай холбоотой энэ хэвлэл мэдээллээр асуудал гарч байгаа энэ хүмүүстээ ямар хариуцлага тооцох юм бэ? Хууль зүйн сайдаас би асуугаад байгаа юм.

Одоо нүүрсний хулгайтай холбоотой, Хөгжлийн банктэй холбоотой энэ олон асуудлууд байна шүү дээ.

Тэгээд хамт сууж байдаг. Тэгээд мань мэтийн хэдэн юмнууд ингээд бараг 20-иод жил үе үеийн парламентаас энэ авлига, ашиг сонирхлоос ангид байгаач ээ. Энэ төрийн албыг төрлийн алба болгох хууль бус юмнаас Та нөхөд минь ангид байгаач ээ гээд ингээд шаардаад явсаар байгаад харин өнөөдрийн энэ цагтаа залгуулж байгаа юм.

Тэгээд үүнийгээ бодитой болгох хэрэгтэй байгаа юм.

Бид өөрсдөөсөө л эхлэх хэрэгтэй байгаа юм. Энэ хамт байгаа.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр хариулъя. Б.Энхбаяр сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Энхбаяр: (22-р тойрог, Баянзүрх дүүрэг)

Үнэхээр парламент манлайлж ажиллаж байгаа. Авлигатай тэмцэх дээр.

Жил хагасын өмнө Засгийн газраас өргөн барьсан авлига, албан тушаалын гэмт хэрэгт улс төрд нөлөө бүхий этгээд хээл хахууль авбал бүх насаар хорих ялтай болсон.

Эрүүгийн хуульд байгаа ялын хамгийн дээд хэмжээ.

Парламентаас “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг өнгөрсөн онд баталсан.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Энэ өөрчлөлтөөр цаашид төрийн өндөр албан тушаалтан улс төрд нөлөө бүхий этгээд хоёр замыг л сонгоно.

Та улс төр хийж ард түмний төлөөлөгч болох гэж байгаа бол бизнесээ нэг мөр хая. Яагаад гэвэл энэ боломжгүй.

Таны гэр бүл, ойр дотнын хүүхдүүд аливаа төрийн тендер, худалдан авалтын үйл ажиллагаанд оролцохгүй. Хориотой. Эсвэл та бизнес хийх гэж байгаа бол бизнесээ сонго.

Мөнгөнд дуртай хүн байвал улс төрд битгий ор л гэсэн үг.

Энэ хоёр замыг хослуулж хийх боломжийг хаасан байгаа.

Энэ бол таны хэлсэн өнгөрсөн 30 жилийн үүр уурхайд дүгнэсэн дүгнэлт байгаа юм.

Нэг үе манай парламентын гишүүдийн 90 орчим хувь нь Монголын топ бизнесменүүд болчихсон байдаг нь аргагүй.

Ийм том хэмжээний зардлыг ямар аавын хүү, охин даах вэ. Ямар залуу хүн даах вэ. Тэгээд үүнийг мөнгөтэй хүн л даана.

Тийм учраас Улс төрийн намын хуулийг шинэчилсэн.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан. Хувь тэнцүүлсэн тогтолцоог оруулж ирж.

Нийгмийн орж чадахгүй байсан тэр төлөөллүүдийг, жижиг гэж хэлнэ үү тэр намуудын дуу хоолойг ч гэсэн парламентад орох асуудлыг эрх барьж байгаа манай нам өөрөө хийж байгаа.

Тийм учраас парламентын манлайлал өндөр байгаа.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цаашид олон асуудлууд хийгдэнэ.

Нийгмийн даатгалын, боловсролын багц хуулиудыг баталсан. Улс төрийн намын тухай хуулийг шинэчилсэн.

Авлигын үүр уурхай болсон тэр их ундаргууд дээр **“ТОГТОЛЦООНЫ РЕФОРМ”**-уудыг хийж байна.

Энэ үр дүнгүүд одоо юунаас хамаарах вэ, улс төрчдийн өөрсдийн хувийн манлайллаас хамаарна. Одоо хүнээс хамаарна.

Парламент гурав дахь удаагийн сонголоо хийлээ.

Энэ огт үр дүнгүй ажил болоогүй.

30 жилийн хугацаанд энэ луйварын схем ямар гинжин урвал, оролцоотойгоор хийгдэж байсан бэ гэдгийг илчилж байгаа.

Ард түмнээ сэргээж байгаа. Ард түмнийхээ нүдийг нээж байгаа.

Тэгж байж ард түмнийхээ үүнийг үл тэвчих, хамт тэмцэх хүсэл зоригийг бадрааж байгаа.

Нүглийн нүдийг гурилаар аргалдаг гэж ярьдаг. Гурилаар аргалагдахгүй. Нүгэл бол.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Тодруулах уу? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Тийм.

Тэгэхээр би асуугаад байгаа нь энэ Их Хурлыг цэвэр тунгалаг байлгах ёстой.

Тэгээд энэ дээр том бизнесменүүдийн өөрсдөө болоод төлөөллүүд нь орж ирээд суучихсан гэж.

Тэгэхээр энэ байдал чинь одоо энэ Их Хурлын сонгуулийн хууль, энэ сонгуулийн зардалтай холбоотой бол ер нь бахь байдгаараа байхаар л ийм л хэмжээнд байна шүү дээ.

Тэгээд цаашдаа энэ улс төрийн намын санхүүжилт, энэ сонгуулийн зардлыг бууруулахтай холбоотой цогц арга хэмжээ авахгүй бол энэ бид нарын дэвшүүлж байгаа энэ том бодлого чинь хэрэгжихэд үнэхээр хүнд шүү.

Үнэхээр одоо энэ олон түмний дунд яригдаж байгаа, хэвлэл мэдээллээр тодорхой байгаа энэ асуудалтай холбоотой улсуудын асуудлыг яах юм бэ?

Бид үе үеийн парламентаас аливаа хэрэг асуудалтай холбоотой байх юм бол өөрөө хуулийн байгууллагад очоод шалгуулаа, хариуцлагаа хүлээ гэдэг ийм үлгэр манлайллын.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Үг хэлсэн. Тийм ээ.

Улсын Их Хурлын гишүүн
Балжиннямын Баярсайхан гишүүн
асуултаа асууя.

Б.Баярсайхан: (9-р тойрог, Завхан аймаг)

Авлигатай тэмцэх үндэсний
хөтөлбөрийн тогтоолын төслийг дэмжиж
байна.

Тэгээд би Авлигатай тэмцэх
газрынхнаас нэг асуулт асууя.

Ер нь манай Монгол Улсад
авлигагүй байгууллага гэж байна уу? Энэ
нийслэл, 9 дүүрэг, 21 аймаг, 330 сум, баг,
хороо. Авлигагүй газар гэж ер нь байгаа
юу. Тэрийг асууя.

Авлига шингээгүй, авлигагүй, ёс,
суртахуунтай ажиллаж байгаа ийм
байгууллага байна уу гэж асууя.

Б.Энхбаяр сайдаас хоёр дахь
асуултыг асууя.

Таныг Хууль зүйн сайдаар
томилогдсоноос хойш хууль, шүүхийн
байгууллагад итгэх иргэдийн итгэл хэр
нэмэгдэж байна.

Таны хариуцаж байгаа салбарт
авлига байгаа юу?

Хууль, хяналтын байгууллага маань
энэ авлигын асуудалд шударга хандаж
чадаж байгаа юу гэдэг асуултыг асууя.

Өнөөдөр дандаа өндөр албан
тушаалтнуудын авлигын асуудлыг ярьж
байгаа. Энэ зөв.

Гэхдээ миний байнга хэлдэг зүйл
яагаад төрийн албаны шат шатад авлигатай
холбогдсон, янз бүрийн байдлаар ёс зүйн
асуудал гаргасан хүмүүст Авлигатай
тэмцэх газар дараа дараагийн шатанд нь
зөвшөөрсөн дүгнэлт гаргаж өгдөг юм бэ.

Яагаад манай Монгол Улсад нэг
яаманд ажиллаад авлигын асуудалд
холбогдсон ийм хүмүүс дараагийн шатдаа
тушаал дэвшээд, дараа дараагийнхаа
салбарт ингээд ажиллаад яваад байдаг юм
бэ гэдэг асуудлыг би Авлигатай тэмцэх
газраас удаа дараа асууж байгаа.

Мөн ямар нөхцөл байдлаас болоод
танайд өгсөн хэргүүд чив чимээгүй,
шийдэгдэхгүй, ямар нэгэн байдлаар
өргөдөл гаргасан хүндээ эргээд хариу ч
байхгүй алга болчихдог юм бэ?

Танай байгууллагад авлига байгаа
юу? Авлигатай тэмцэх газар.

Энэ асуултуудад хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Авлигатай тэмцэх газрын хэлтсийн
дарга М.Даваатогтох хариулъя. Дараа нь
Б.Энхбаяр сайд нэмж хариулъя. Хэн нь
хариулах юм? Та хоёрын. Д.Дуламсүрэн
хариулах уу. Д.Дуламсүрэн хариулъя.
Авлигатай тэмцэх газрын албаны дарга
Д.Дуламсүрэн хариулъя. Ажлын хэсгийн 5
дугаар микрофоныг өгье.

Дараа нь нэг асуудал байгаа. Санал
хураалт явагдана шүү.

Д.Дуламсүрэн: Баярлалаа.
Б.Баярсайхан гишүүний асуултад
хариулъя.

“Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ” гэдэг судалгааг Авлигатай тэмцэх газар хийдэг.

Энэ судалгааны дүнгээр ер нь дунджаар 74.2 гэсэн ийм хувьтай үнэлэгдсэн байгаа.

Өөрөөр хэлбэл нийт иргэд, төрийн албан хаагч, бодлого, оролцогчдын хувьд Монгол Улсад авлига ихээхэн түгээмэл байна гэдэг ийм тоо баримт 74.2 хувьтай тэнцэж байгаа.

Энэ үзүүлэлт 2021 оноос хойш ерөөсөө тасралтгүй нэмэгдэж байгаа.

Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээнд бүх яам, агентлаг, тэгээд бүх аймгуудын Засаг даргын Тамгын газар бүгдээрээ хамрагдаж байгаа.

Гэхдээ энэ үзүүлэлт бодитойгоор ерөөсөө өөрчлөгдөхгүй байгаа буюу энэ авлигын нөхцөл байдал төрийн байгууллагуудын түвшинд эрс шинэчлэлт хийж, тийм ээ сайжрах тийм төлөв байдал харагдахгүй байна гэсэн ийм прогнозыг судалгааны дүн харуулаад байгаа.

Тийм учраас энэ шударга байдлын үнэлгээг өөрчлөх. Ялангуяа 76.6 гэсэн ийм оноотой байгааг аль болох энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд доор хаяж 30 хувиар үүнийг нэмэгдүүлэх. Одоогийн авсан байгаа оноо 2.7 хувиар л нэмэгдсэн байгаа юм л даа. Оноогоор.

Тэгэхээр энэ 2.7 гэсэн оноог доор хаяж 30 хувиар нэмэгдүүлэх ийм зорилтыг тавьж хөтөлбөрт тусгасан байгаа.

Тэгээд төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээгээс гадна улс төр, хууль хяналтын хүрээний буюу улс төрийн хүрээн дэх авлигын төсөөлөл, мөн

шүүх эрх мэдлийн байгууллагуудын хүрээний төсөөллийн судалгаануудыг хийж байгаа.

Үүгээр ч гэсэн нөхцөл байдалд төдийлөн сайн биш байгааг судалгааны дүн харуулж байгаа.

Тэгэхээр судалгааны дүн ер нь ийм л байдлыг илэрхийлж байна.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Нэмж хариулах уу? Тийм ээ.

Б.Баярсайхан гишүүн Авлигатай тэмцэх газар өргөдөл өгсөн юм уу? Тэр нь тодорхойгүй, хариу өгөхгүй алга болсон байна гэсэн зүйлийг хэлээд байна. Тийм ээ. Хуулийн хугацаатай байдаг байгаа байх. Тэр юугаа тайлбарлаад хэлчихье.

М.Даваатогтох хэлтсийн дарга хариулья.

М.Даваатогтох: Гишүүний асуултад хариулья.

Авлигатай тэмцэх газарт жилдээ 1600 орчим хэрэг шалгагддаг юм.

Мөн бас төдий тооны гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгагддаг юм. Зөвхөн гэмт хэргийн шинжтэй асуудлыг ярьж байгаа шүү дээ.

Үүнийг Монгол Улсын хэмжээнд нийт 56 мөрдөгч шалгаж шийдвэрлэдэг.

Эдгээр мөрдөгчдөөс одоо 12 мөрдөгч нь орон нутгуудад суурин ажиллаж байна. Бүсчилсэн байдлаар.

Жишээлбэл, Говь-Алтай аймгийн суурин мөрдөгч Завхан аймгийг хариуцдаг байх жишээний.

Энэ хэмжээний хүн хүчээр энэ 3 мянга орчим гомдол, мэдээллийг шалгахад хугацаа ордог. Зарим гомдол, мэдээллүүд дээр их хэмжээний хүн хүч, хугацаа зарцуулах ийм зайлшгүй шаардлагууд үүсдэг юм.

Үүнийг төр төлөөлөөд сууж байгаа Та маш сайн ойлгох болов уу гэж бодож байна. Жишээлбэл, Хөгжлийн банкны хэрэг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гүйцээгээд хариулчихъя М.Даваатогтох даргын микрофоныг өгчих.

М.Даваатогтох: Энэ томоохон хэргүүд дээр мөрдөгч нар ажлын хэсэг болоод татагддаг. Цагтай нартай уралдаад ингээд маш өндөр ачаалалтай ажилладаг.

Энэ хугацаанд бодит амьдрал дээр тодорхой тооны хэргүүдийг хойш нь тавихаас өөр арга байхгүй.

Хүн ажиллаж байгаа учраас ингэж явж байгаа. Зарим хэрэг тодорхой шалтгааны улмаас удааширсан байхыг үгүйсгэхгүй.

Танд яг тодорхой хэрэг байгаа бол тодорхой хариулж болж байна.

Дараагийн асуудал дээр танай байгууллагад авлига байгаа юу гэж асууж байна.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар 2007 онд үүсгэн байгуулагдсан.

Одоо 17 дахь жилдээ ажиллаж байгаа байгууллага.

Энэ хугацаанд Авлигатай тэмцэх газрын албан хаагчдаас авлигын гэмт хэрэгт холбогдсон хүн одоогоор байхгүй. Ийм байна.

Тэр хууль бус томилгооны асуудал ярьж байна. Энд та тодорхой асуувал тодорхой хариулж болно.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Б.Энхбаяр сайд нэмээд хариулчихъя. Б.Энхбаяр сайдад хаяглаж асуусан учраас тэрэнд нь хариулчихъя.

Б.Энхбаяр: (22-р тойрог, Баянзүрх дүүрэг)

Авлига бүх салбарт байна. Үндэсний бөхөд ч байна, цэцэрлэгт оруулахад ч байна, хүүхдээ төрүүлэхэд ч байна, хуулийн салбарт ч байна.

1 дүгээр сургуульд орсон манай найзын 7 настай хүүхэд аав, ээждээ ирээд хэлсэн байгаа юм.

Аав та манай багшид хонины мах өгөөч ээ гэж.

Тэгээд жоохон хүүхэд юу ярих вэ. Миний хүү юу яриад байгаа юм бэ гээд.

Манай ангийн хүүхдүүд хонины мах хөөгөөд урдуур суугаад байна. Эцэг, эхүүд нь гэж. Ангийн багшдаа.

Хүүхдийг багаас нь ийм болгож байна. Авлигач сэтгэхүйтэй. Жоохон хүүхдийг.

Асуудал хэнд байна вэ.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Болсон уу? Тийм ээ. Хариулт хангалттай юу? Тодруулах юм уу?

Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Баярсайхан: (9-р тойрог, Завхан аймаг)

Б.Энхбаяр сайдын ярьж байгаа асуудлыг бүр 2008 онд “Ийгл” телевизийн цуврал нэвтрүүлгээр “Монгол Улсад хэзээнээс эхэлж хүн авлига өгч эхэлдэг вэ? Эхийн хэвлийд байсан цагаасаа” гээд цуврал нэвтрүүлэг хийж байсан.

Энэ нэвтрүүлгийг хийж Авлигатай тэмцэх газраас “Шударга үнэний дуу хоолой” гэдэг шагналыг авч байлаа.

Гэхдээ юун тэр 16 жилийн өмнөх үеийн асуудал өнөөдөр бүр муудаж байна уу гэхээс биш дээрдсэн юм алга.

Тэгээд энэ үндэсний хөтөлбөрийг одоо бид бий болгоод ямар үр дүн хүлээж байгаа юм? Ямар үр дүн хүлээж байгаа юм бэ? Ямар үр дүн гарах юм? Энэ тогтоолын төслийг бид батлаад.

Энэ асуултад бидэнд одоо найдвар байна уу? Бид авлигаасаа салах найдвар байна уу? Энэ 21 аймаг, 330 сум, нийслэл, 9 дүүрэг, бүх байгууллагад авлига байна гэж байна шүү дээ. Тэгээд яах вэ?

Үүнийг л та нар надад хариулаад өгөөч. Энэ үндэсний хөтөлбөр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Б.Энхбаяр сайд хариулах нь зохимжтой байх даа. Энэ асуудлыг шийдэх гэж “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” гарсан.

Одоо тэр хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг нь бид хэлэлцээд сууж байгаа шүү дээ.

Б.Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: (22-р тойрог, Баянзүрх дүүрэг)

Би урам зоригтой хүн.
Би итгэл найдвартай хүн.
Би ирээдүйдээ итгэлтэй байдаг.
Би өнгөрсөн цагаа бодож ажилладаггүй.

Сайн цаг ирж байгаа гэдэгт би итгэж байгаа.

Сайн цагийг авчрахын тулд өнөөдрийн бид өөрсдөө энэ асуудал дээр зоригтой манлайлал үзүүлэх шаардлагатай.

Улс төрд хуулийнхан орж ирж төмсөгддөг, барьцаалагддаг явдал байсан.

Би үүнийг арилчихсан гэж ярьж байгаа биш шүү.

Б.Хурц нар Улсын Их Хурлын хоёр намын 8 гишүүнд нөлөөлж, өөрсдийгөө хянадаг прокурорын мөрдөнг татан буулгаж байсан.

Өөрөөр хэлбэл тэр хуулийнхны хянадаг бүтцийг нь аваад хаячихсан. Тэгж байгаад дээрэм хийсэн.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Одоо Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат асуултаа асууя.

Д.Ганбат: (3-р тойрог, Баянхонгор аймаг)

Авлигатай тэмцэх газар маань 20-иод жил болж байна. Байгуулагдаад.

Ингээд мөрийн хөтөлбөр оруулж ирж байна. Өмнө нь хэрэгжүүлсэн ажлууд чинь юу болсон бэ?

Миний мэдэхийн 2014 онд энэ “Transparency International”-ийн элссэн байраар 72-т л байсан шүү дээ. Одоо ингээд 121-д байгаа.

Авлига, албан тушаалын хэрэгтэй тэмцэнэ гэдэг бол амь өрссөн асуудал. Энэ бол тийм амар биш ээ.

Энэ авлига ийм байдалд хүрснээс болоод гаднын хөрөнгө оруулалтууд алга. Баян, ядуугийн ялгаа гээд зөндөө асуудлууд бий.

2016 онд улсын төсөв 6 их наяд байсан. Одоо 27.5 их наяд. Энэ бараг 6 дахин ихэссэн байгаа.

Төрийн өмчтэй компаниудын өмч хөрөнгө 55 их наяд.

Тэгээд ерөөсөө ашигтай ажилладаг компани байхгүй. Ийм л байдалтай байгаа юм л даа.

Тэгээд энэ учир шалтгааныг Та бүхэн маань юу гэж бодож байна вэ?

Анхны Авлигатай тэмцэх газрын дарга нар учир битүүлэг байдлаар янз янзын байдалд орж байсан л даа.

Хугацаагаа гүйцээж ажилласан дарга хэд байдаг билээ?

Энэ авлигатай тэмцэх талаар бид ажиллах гэж оролдож байна.

Үүний төлөө тэмцсэн хүмүүсийг үнэхээр энэ хоёр том нам, энэ дотор байгаа хүмүүс бүр дараагийн сонгуульд нэр дэвшүүлэхгүй гэж байна шүү дээ.

Энэ манай хуулийн илд болоод байгаа манай Б.Энхбаяр гишүүн бас тийм юм ярьсан байгаа.

Манай нам дотор ч гэсэн тийм нөхдүүд байна. Үүнийг юу гэж бодож байгаа юм. Тийм.

Битгий сааруулаад байгаарай. Ярьж байгаа юмыг. Авлигыг дэмжээд байж болохгүй шүү.

Б.Энхбаяр гишүүн ээ, та энэ талаар юу гэж бодож байна? Үүнийг сонсмоор байгаа юм.

Энэ авлигын мөнгө төгрөг зарим хүмүүсийн сейфт багтахгүй, тэр өрөөнд нь багтахгүй, гэрт нь багтахгүй болчихсон. Алтан гулдмай, алтан морь болоод байж байна л гэсэн шүү дээ.

Би яах вэ, хариуцлагатай Ардын намын гишүүдийн амнаас л сонссон л доо. Тийм.

Ер нь тэр алтан гулдмай энэ тэрийг нь олж хурааж барьж байгаа юу? Ямар байгаа юм?

2030 он хүртэл энэ хэрэгжих юм байна. Авлига ахиад энэ маягаараа цаашдаа гаарна.

Манай Улсын Их Хуралд олон хар хэрээн дотор нэг цөөхөн цагаан шувуу шиг хүмүүс л сууж байгаа юм л даа.

Тэгээд үнэн ч байдаг юм уу, худлаа ч байдаг юм уу Авлигатай тэмцэх газраас Улсын Их Хурлын 17 гишүүнийг та нар чинь зарласан шүү дээ. Тэгсэн байх аа. Тэр юм чинь юу болсон юм?

Үнэхээр гүтгэж барьсан юм бол одоо тэр хүмүүсийнхээ нэрийг цэвэрлэ.

Хөгжлийн банкны, энэ нүүрсний асуудлыг Б.Энхбаяр гишүүн бид хоёр.

Эхлээд Ж.Сүхбаатар гишүүн байсан байх. Манайхаас би оролцоод нэлээн ингээд ажилласан.

Үүний үр дүн гэж хаана байна? Юу болсон бэ? Танай дээр ямар байдалтай, үр дүн нь ямар байна?

Тэгээд авлигаар олсон хөрөнгийг хурааж байгаа, орлого оруулж байгаа ийм зүйл байгаа юу?

Хэд хэдэн онд ямар ямар үр дүнтэй хөрөнгө хураагдаад, ямар байдалтай байгаа юм бэ?

Нэлээн хэдэн гишүүд асуух шиг боллоо. Түүнд нь яг тов тодорхой хариулаадхаач.

Ийм ийм байна. Дараагийн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Д.Ганбат гишүүний асуултад тодорхой эрүүгийн хэрэг, маргаантай холбоотой асуудлууд яригдаж байгаа. Тэр асуудалд хариулах эрх бүхий хүмүүс эд нар биш байгаа.

Яагаад гэвэл “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хэлтсийнх нь албан хаагчид байгаад байгаа шүү дээ. Энд.

Тийм учраас авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлынхаа төлөвлөгөөг

танилцуулаад, батлуулах гээд явж байгаа хүмүүс байгаа юм.

Тийм учраас тэдгээрээс бусад зүйлд нь хариулах нь зохимжтой байх гэж бодож байна.

Авлигатай тэмцэх газраас хэн хариулах юм? Д.Дуламсүрэн хариулах юм уу, хэн хариулах юм?

Б.Энхбаяр сайд хариулах юм уу? Б.Энхбаяр сайд хариулья.

Б.Энхбаяр: (22-р тойрог, Баянзүрх дүүрэг)

Д.Ганбат гишүүн бид хоёр 2 жил “хаа ч явсан цуг гэж мэдээрэй” гэдэг шиг хамтдаа хэлхэлдэж 2 удаагийн сонсголын ард гарсан.

Эхлээд Д.Ганбат гишүүн маань өмнө нь гишүүн байсан, бизнес хийдэг. Одоо яадаг бол доо гээд санаа зовж л байсан. Тийм.

Шинжээчид шударга ажилласан. Олон л гишүүдээс асуудал, янз бүрийн юмнууд илэрсэн. Д.Ганбат гишүүнээс юу ч илрээгүй ээ.

Хөгжлийн банкн дээр ч юм гараагүй, нүүрсэн дээр ч юм гараагүй.

Тийм учраас ч өөрөө нүүр бардам үг хэл нь хурц байдаг юм байна гэж би зүгээр өнөөдрийн байр сууриас хэлэхэд тийм байна.

Тэгээд энэ сонсголуудын үр дүн өөрөө юу болчихсон бэ гээд байгаа юм.

Энэ их олон юм өөрчилж байгаа.

Би нүдэнд харагдахгүй байгаа юмнуудаас нь хэлье.

Хөгжлийн банкны сонголын ард төрийн сайд нараасаа эхлээд ер нь дураараа авирлаж, дур зоргоороо шийдвэр гаргадаг энэ байдал ихээхэн хумигдсан.

Ер нь энэ чинь хууль номтой юм байна. 10 жилийн дараа, бүр 20 жилийн өмнөх юмыг ч гаргаад ирэх юм байна гэдэг энэ зүйл төрийн шийдвэр гаргах түвшинд их тийм хүчтэй өөр болсон шүү.

Үүнийг би Засгийн газрын гишүүний хувьд, одоо Засгийн газрын олон удаагийн хурал дээр ч гэсэн анзаарч байгаа. Ер нь сайд нарын зүгээс.

Бид тэр сонсголууд дээр тэр үеийн бүр аудио, видео сонсгож байсан шүү дээ.

Дураараа ярьдаг. За за...
Х.Баттулгад 56.0 сая доллар өгчихье.
Шууд. Одоо юу яриад байгаа юм.

Ингээд ...тэр сайдад тэдэн сая доллар өгчихье. Ийм юм яриад сууж байсан протоколыг гаргаж байгаа шүү.

Энэ 10 жилийн өмнөх хурлын протокол.

Одоо ийм юм ярьдаг сайд дарга байхгүй болсон.

Ямарваа нэгэн ийм задгай, төлөвлөгөөгүй, бялуу хуваадаг энэ асуудал цэгцэрсэн.

Ерөнхий сайд өөрөө хатуу байгаа. Хатуу.

Хуулийн сайдын зүгээс хүсэж байгаа асуудал дээр өндөр шаардлага тавьж байгаа.

Ямарваа нэгэн байдлаар хууль зөрчсөн ийм шийдвэр гаргуулахгүй тал дээр хичээж ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гишүүд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Уг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Санал хураалтыг явуулъя. Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Санал хураалт. /алх цохив/

Авлигатай тэмцэх асуудлыг хэн эсэргүүцэж байна? Ямар хүн эсэргүүцээд үүнийг унагаагаад байна.

Д.Ганбат гишүүн горимын санал гаргая.

Д.Ганбат: (3-р тойрог, Баянхонгор аймаг)

Би дэмжиж байгаа юм. Төхөөрөмж ажиллаагүй байна. Тийм.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

52.6 хувиар санал дэмжигдлээ. Хүчингүйд тооцлоо.

Үндсэн саналын томъёоллийг уншиж танилцуулсан.

Санал хураалт. Гишүүд анхааралтай. /алх цохив/

52.6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийнхаа асуудалд оръё. Одоо хоёр асуудал байгаа. Товчхон хоёр асуудал байна.

Дараагийн асуудал.

18:07

Найм. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулья.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Ж.Сүхбаатар: (25-р тойрог, Чингэлтэй дүүрэг)

Улс Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримтлан явуулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны

танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Ж.Сүхбаатар гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Санал хураалтыг явуулъя.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураая.

Санал хураалт. /алх цохив/

Тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийнхаа асуудалд орёе. **18:10**

**Ес.Биеийн тамир, спортын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ танилцуулна.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 12 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тусгасан.

Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 12 сарын 19-ний өдрийн хурлаар “Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 08 дугаар тогтоол батлагдсан.

Би ингээд товчхон Та бүхэндээ танилцуулъя.

Товчхон танилцуулна.

Монгол Улсын сайд, Олимп, биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын шийдвэрээр Улсын Их Хурлын ажилтан Монгол үндэсний олимпын болон паралимпын хороод, спортын салбарын төрийн болон төрийн бус байгууллага, судлаач, эрдэмтэд болон хувийн хэвшлийн төлөөлөл бүхий 16 гишүүний бүрэлдэхүүнтэй Биеийн тамир, спортын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.

Энэ нэг жил гарны хугацаанд ажлын хэсэг нийтдээ 8, удаа ажлын дэд хэсгүүд 20 гаруй удаа хуралдаж, гадаад улс орнуудын биеийн тамир, спортын салбарын хууль тогтоомжийн судалгаа, төсөв санхүүгийн асуудал, допингийн олон улсын хууль эрх зүйн зохицуулалт, биеийн тамир, спортын салбарын дотоодын хууль тогтоомж, иргэд, мэргэжлийн байгууллагуудын санал зэрэг чиглэлээр ажиллаж, хуулийн шинэчилсэн найруулгыг төслийг боловсруулсан.

Хуулийн төсөл Монгол Улсын нийтийн биеийн тамирын салбарт гарч буй шинэчлэл, өөрчлөлт, нийгмийн эрэлт хэрэгцээг даган зайлшгүй зохицуулах харилцааг тусгах шаардлагатай болсон тул хуулийн үйлчлэх цар хүрээг нэмэгдүүлж тэлж, 8 бүлэг, 41 зүйлтэйгээр боловсруулсан.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг өргөнөөр явуулж, нийт 68 спортын холбоод, 5 мэргэжил, судалгааны байгууллага, аймаг, дүүргийн биеийн тамир, спортын төрийн байгууллагын 30 гаруй удирдах ажилтан, 300 гаруй

тамирчин, дасгалжуулагч, шүүгч, 20 орчим хувийн хэвшлийн төлөөлөгч, хөрөнгө оруулагч, ивээн тэтгэгч нар оролцсон.

Хэлэлцүүлэг, зөвлөгөөнд оролцогч нарын дэвшүүлсэн саналуудын 72 хувийг хуулийн төсөлд оруулсан.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь хэд хэдэн байдлаар 2003 болоод 2017 онд баталж байсан спортын салбарын харилцааг зохицуулсан хуулиудаас ялгаатай байгаа.

Энэ хуулийн төсөл нь биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг **“Алсын хараа-2050”** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн идэвхтэй, амьдралын хэвшилтэй, иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлэх зорилтыг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн.

Тус эрх зүйн баримтад хуулийн зорилтыг тодорхойлсон байгаа.

Улс, үндэстний эрүүл, чийрэг байхын үндэс нь зөвхөн төрийн бодлого, дэмжлэгээс гадна хувь хүний өөрийн эрүүл мэндийг сахин хамгаалах үүрэг, оролцоо хамгаас чухал болохыг тодорхойлж, эрх үүргийг зохицуулж өгсөн учир хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэн, гэр бүлийн эрхэмлэх зүйл бүлэг шинээр нэмэгдүүлсэн.

Спортын салбарын тамирчид, дасгалжуулагч, шүүгч, ажилтан, арга зүйч нь оюун ухаан, бие бялдар, ёс суртахууны хувьд зөв хандлагатай бүтээлч иргэн, идэвхтэй амьдралын дадал хэвшилтэй гэр бүлийн орчныг төлөвшүүлэхийн төлөө ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин

мөрдөхөөр хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.

Байнгын хорооны 8 дугаар тогтоолоор өгсөн үүрэг чиглэлийн дагуу спортын холбоо бүр өөрийн Ёс зүйн зөвлөл зөвлөлтэй байх, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай гомдлыг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд Ёс зүйн зөвлөл хэлэлцэн шийдвэрлэх, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд мөнгөн шагнал урамшуулал олгохыг түр түдгэлзүүлэх, бусад арга хэмжээ авах зэрэг заалтыг оруулсан.

Монгол Улсын Засгийн газраас допингийн эсрэг үйл ажиллагаанд хуримтлагдсан асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах, холбогдох байгууллагуудын чиг үүрэг, ажлын уялдаа холбоо, хяналтын төслийг боловсронгуй болгох чиглэлээ өгсөн.

Хуулийн төсөлд допингийн эсрэг үйл ажиллагааг зохицуулах тусдаа бүлэг орсон бөгөөд тус бүлэгт орсон заалт бүрийг дэлхийн допингийн эсрэг байгууллага ВАДА-тай харилцан зөвшилцөн тусгасан байгаа.

Спортын салбарт хөрөнгө оруулж байгаа компаниудыг аж ахуйн нэгжийн орлогоор төлөх татвар, гаалийн тарифын хөнгөлөлт зэрэг хоёр төрлийн хөнгөлөлтийг төрөөс үзүүлж байсан бол энэ хуулийн шинэчилсэн найруулгаар түүнийг дагаад бусад хуульд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөлд төрөөс татварын 4 төрлийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх талаар тусгасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар энэ хуулийн төсөлд 8 заалтыг шинээр зохицуулсан байгаа.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд сум, дүүргийн хороонд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулна гэж туссан бөгөөд цаашид сум, дүүргийн хороодод ажиллах 400 гаруй спортын арга зүйч буюу хүний нөөцийн хэрэгцээ үүсэх бөгөөд эдгээр ажилтнууд засаг захиргааны нэгжийн хэмжээнд иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, дасгал хийх аргачлал, зааварчилгаа, зохион байгуулалтыг хариуцах, биеийн тамирын үйлчилгээ иргэн бүрт хүрэх боломж нээгдэж байгаа юм.

Мөн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 14.1.6-д аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага өөрийн албан ёсны орон тоон дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөллийг авч ажиллуулах заалтыг шинээр оруулсан.

Эрхэм гишүүд та бүхэн Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Б.Бат-Эрдэнэ сайдад баярлалаа.

Төслийн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Т.Аубакир: (2-р тойрог, Баян-Өлгий аймаг)

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар олимпын төрлийн спортыг хөгжүүлэхийн сацуу бүх нийтээрээ эрүүл чийрэг амьдралын зөв дадал хэвшилтэй болох, бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчныг бүрдүүлэх, хууль тогтоомжийг гардан хэрэгжүүлэх салбарын мэргэжилтэн, боловсон хүчин буюу хүний нөөцөө бэлтгэж чадавхжуулна гэж хууль санаачлагч үзжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч ажилласан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед

- Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хуульд заасан татварын дэмжлэгт ямар спортын төрөл хамрагдаж байгаа талаар, ерөнхий боловсролын сургуулиудын заал, техник, тоног төхөөрөмжийн дэмжлэгт хэрхэн анхаарч ажиллаж байгаа талаар, допинг болон тамирчны ёс зүйн асуудлыг хэрхэн зохицуулж байгаа, мөн урамшууллын асуудлыг үүнтэй хэрхэн уялдуулж байгаа талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам хөдөө орон нутгийн сургуулиудад спортын дугуйлан секц байгуулан хүүхдүүдийг хамруулах талаар, спортыг орчин үеийн зах зээлийн жишигт нийцүүлэн хөгжүүлэхийг хэрхэн дэмжиж зохицуулах талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан допингийн асуудлыг бие даасан бүлэг болгон тусгаснаар өнөөгийн үүсээд байгаа нөхцөл байдалд бүрэн шийдэгдэх боломжтой эсэх, улсын хэмжээнд нийт сургууль, цэцэрлэгийн хүүхдийн нас, биед тохирсон стандарт шаардлагад нийцсэн биеийн тамирын заал, хичээлийн хэрэгслээр хангах эсэх талаар асуулт асууж санал хэллээ.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Биеийн тамир, спортын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Т.Аубакир гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны дарга Эрдэнийн Тэмүүжин, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Осорын Баттулга, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын албаны хуульч Баярсайханы Өлзийбаяр нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Д.Тогтохсүрэнгээр тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин асуултаа асууя.

Г.Амартүвшин: (29-р тойрог, Хан-Уул дүүрэг)

Баярлалаа. Би Б.Бат-Эрдэнэ сайдаас ганц хоёр асуулт асууя.

Нэгдүгээрт, саяхан допингтой холбоотой асуудал гарсан. Манай тамирчид Парист болох олимпын тоглолтод цагаан туг доор оролцох тийм асуудал хөндөгдөж байсан. Энэ маань одоо юу болсон бэ? Энэ дээр тодорхой хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт, ер нь аливаа спортод, ялангуяа манай улсад спорт хөгжихийн тулд санхүүжилт аягүй чухал байдаг.

Одоо жишээ авах юм бол сагсны төрлийн спорт манайд маш сайн хөгжиж байгаа. Яагаад гэвэл санхүүжилт нь маш сайн. Хувийн хэвшлээс их хэмжээний тэтгэлэг, дэмжлэг орж ирсэн.

Бусад спортод бас тиймэрхүү хэмжээнд байгаа. Дийлэнх олонх спортууд үндсэндээ санхүүжилтээрээ дутаад ингээд л тойроод л хөөрхий хандив гуйгаад л явдаг.

Одоо олон улсын ийм тэмцээнд оролцох шаардлагатай байна. Тийзний мөнгийг гаргаж өгөөч. Ийм тамирчдын буудал, хоолны мөнгийг дааж өгөөч. Ингээд л байнга л явж байдаг.

Энэ асуудлыг энэ хуулийн төслөөр шийдэх үү? Яаж шийдэх вэ?

Гуравдугаарт, ер нь барууны орнууд спортоо яаж дэмждэг вэ гэхээр мэдээж хэрэг төрөөс шууд төсөвт мөнгө суулгахаас гадна архи, тамхи болон шатахуун бензиний маш өндөр татвараас бараг 100 хувь спортоо ивээн тэтгээд явдаг. Жишээлбэл, янз бүрийн хонжворт тоглоомын татвар ч байдаг юм уу, тийм эх үүсвэрээр спорт болон соёлын арга хэмжээ, соёлын салбараа, спортын салбараа ингээд дэмжээд явдаг юм.

Энэ хуулийн төсөлд ямар нэгэн тийм зохицуулалт орсон болов уу гэдгийг асууя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Г.Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Г.Амартүвшин гишүүний асуултад хариулъя.

Допингтой холбоотой асуудал үнэхээр хүндэрчихсэн ийм асуудал. 2008 оноос допингийн эсрэг үндэсний байгууллага байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан боловч энэ нь ил тод бус, нээлттэй бус, холбогдох дүрэм журам зөрчсөн олон асуудлууд байсан.

Ажил авснаас хойш 10 сарын 14-нөөр цаг хугацаа тавьчихсан. Энэ допингийн эсрэг үндэсний дүрмээ Засгийн газар **MONADA** /Mongolian National Anti-Doping Agency/ байгууллагатай хамтарч байгуулах ийм үүрэг чиглэлийг **WADA** /World Anti-Doping Agency/-гаас өгчихсөн. Тэгэхгүй бол цагаан тавагт орохоор ийм нөхцөл байдал үүссэн.

Ингээд цаг хугацаанд нь Засгийн газраар допингийн эсрэг үндэсний дүрмээ батлуулсан. Нэг шаардлагыг нь биелүүлсэн.

Гэтэл дараагийн асуудлууд гарсан. 2 олимпын лабораторийн шинжилгээг төлөөгүй. Дээрээс нь **MONADA** байгууллагын үйл ажиллагаатай холбоотой **WADA**-гаас 21 зүйл, заалттай зөрчил ирсэн.

Тэгээд энэ ер нь **MONADA** байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг нийгэмд, нийтэд мэдээлээд, цаашилбал Засгийн газарт энэ асуудлыг оруулаад, Засгийн газрын Хэрэг эрхлэхийн даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулаад, тэгээд бид шуурхай арга хэмжээнүүдийг авсан.

Энэ бүхний үр дүнд **WADA** байгууллагаас 2024 оны олимпод оролцоход Монголын баг ямар ч асуудал байхгүй. Бүх заагдсан зөрчлүүдийг арилгасан гэдэг үнэлгээ өгсөн байгаа.

Одоо ингээд нөгөө үндэсний дүрэм маань энэ батлагдсан хуулиар бүхэл бүтэн допингийн харилцааг зохицуулсан ийм бүлэг болж энэ хууль дээр орж байгаа.

Энэ дүрмийг батлахад ч адилхан, энэ хуулийн зүйл, заалтыг ч адилхан олон улсынхаа дүрэм, хуулийн дагуу **WADA** байгууллагатай нийцэл хийж, бүх зүйл дээр зөвшилцөж байж энэ зүйл заалтуудыг оруулсан.

Тийм учраас энэ допингтой холбоотой таны саяын асуусан ийм асуудал цаашдаа гарахгүй байх ийм нөхцөл бололцоо энэ хууль батлагдсанаар бий болно.

Санхүүжилтийн хувьд спортын тэмцээн, уралдааны зардал байна. Улсаас оруулж байгаа хөрөнгө санхүүтэй холбоотой юмыг бууруулахгүй байх. Биеийн тамир, спортын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотой улсын төсвөөс санхүүжих хөрөнгийн хэмжээг багасгахыг хориглохоор энд оруулчихсан.

Дээр нь хуучин хуулийн заалтаар 10 сая төгрөгийн хэмжээ бага байгаа учраас энэ хэмжээг 100 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн.

Аж ахуйн нэгж, байгууллагаас биеийн тамир, спортын салбар, таны хэлдэг энэ тэмцээн, уралдаан, баг дэмжих энэ дэмжлэгийг татварт ногдох орлогоос нь хасдаг хэмжээг 10 сая төгрөг байсныг нэмэгдүүлээд 100 сая болсон.

Байнгын хороон дээр энэ хэмжээг илүү нэмэгдүүлж өгөх хэрэгтэй гэсэн ийм саналыг гишүүдээс гаргасан.

Тэгээд үүнийг хэлэлцүүлгийн явцад зохицуулах байх.

Нөгөө талынх нь юм бол таны хэлж байгаа санал зөв өө. Дэлхийн бусад улс орнууд спорт лото, бооцоот морин уралдаан, бусад ийм хэлбэрээр санхүүжүүлдэг.

Манай дээр энэ хуулийн төслүүд нь батлагдаагүй байгаа учраас энэ тухай заалтыг оруулж өгөөгүй.

Ер нь цаашдаа энэ хэлбэрээр явуулах ёстой.

Энэ хуулийн үндсэн санаа бол төсөвт өндөр ачаалал үзүүлэхээсээ илүү энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн байгууллагуудаас одоо бид нарын сайн мэддэг **“STEPPE ARENA”**, **“UG Arena”** гэх зэргээр олон улсын стандартад нийцсэн энэ барилга, цогцолбор, орднуудыг барьж байгуулж байгаа компаниудад дэмжлэг үзүүлэх чиглэлийн.

Монгол Улсад үйлдвэрлэгддэггүй гадаадын стандартад нийцсэн тэр тоног төхөөрөмж, хэрэглэл материалыг оруулахад хил гаалийн татвар зохицуулалтаас өгсүүлээд ийм дэмжлэг үзүүлэхээр.

Хуучин хоёрхон төрлийн гаалийн албан татвартай холбоотой. Нөгөөдөх нь миний түрүүний хэлдэг энэ зүйл, заалттай зохицуулалт байсан.

Одоо дахиад 4-өөр нэмэгдүүлээд ингээд 6 зүйл, заалтаар ийм хөнгөлөлт оруулах ажлыг Хууль зүйн яам, Засгийн

газар дээр Сангийн яам, гол Эдийн засаг, хөгжлийн яамдаас бид ажлын хэсэг дээр ажиллаж байгаад ингээд зөвшөөрлийг нь аваад энэ хуулийн төсөлд болоруулсан байгаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: (10-р тойрог, Өвөрхангай аймаг)

Энэ Биеийн тамир, спортын хуулийг шинэчлэн найруулж орж ирсэн байна. Энэ их чухал. Нийгэмд тулгамдаж байгаа олон асуудал, шинэ харилцааг зохицуулах зорилгоор нэлээн тодорхой биш байдаг юмнуудыг оруулж байгаа юм.

Ер нь Биеийн тамир, спортын хууль гарч энэ спортын асуудлууд, нийтийн биеийн тамирын асуудлууд нэг ингэж зохицуулах шаардлага бий болчхоод байгаа юм. Аль ч шатдаа.

Би ингээд гурван зүйлийг асууя гэж бодож байна.

Нэг дэх нь, сая манай Г.Амартүвшин гишүүн асуулаа. Энэ допингтой холбоотой асуудал.

Тэгэхээр би энэ “Допингийн эсрэг үндэсний төв” гэдэг байгууллага дампуурчихсан. Үүнээс болж балрах гэж байгаа гээд байсан. Энэ нэг юм гайгүй чиглэлтэй орж байгаа юм байна гэж бодож байна.

Гэхдээ энэ байгууллагыг цаашдаа болдог бол Олимпын хороондоо авах юм уу, яах юм. Бүтцийн хувьд нэг бодох ёстой юм. Ингээд төрийн бус байгууллагаас

цаашдаа дамжиж яваад байх юм уу, яах юм.

Ер нь болдог үүнийг Олимпын хорооныхоо харьяандаа авч энэ байгууллагыг нэг янзалж цэгцэлж, хараат бус болгохгүй бол энэ байгууллагаас болж ер нь нэлээн асуудал үүсээд үүсээд байгаа шүү. Нэг дэх асуудал нь.

Хоёр дахь нь, орон нутгийн спортын байгууллагын материаллаг ба санхүүжилтийг нэмэгдүүлэх асуудал туйлын чухал байгаа юм.

Ялангуяа санхүүжилтийн асуудал байгаа юм. Уралдаан тэмцээн байнга явагдаж байдаг. Энэ нь ч зүйтэй. Гэтэл нөгөө санхүүжилт байхгүй.

Тэгэхээр энэ орон нутгийн спортын байгууллагын материаллаг бааз, санхүүжилтийг бэхжүүлэх чиглэлээр яг энэ хуульд орсон тодорхой заалт байна уу?

Гүрвэ дахь нь, спортыг дэмжиж байгуулах гэдэг асуудал байгаа юм. Одоо спортод маш элэгтэй спортын төлөө хөрөнгөө зарж байгаа маш олон хүн байна шүү дээ. Сайхан ордон барьж байгаа хүн байна, тоног төхөөрөмжөөр хангаж байгаа хүмүүс байна. Маш сайхан холбоодуудыг. Хамгийн хэцүү энэ холбоод байдаг байхгүй юу. Энэ спортын холбоодуудыг өөрийнхөө болон бизнесийнхээ олсон бүх юмаар ингээд аваад явж байгаа хүмүүс байна.

Эдгээр хүмүүсийг ер нь яаж дэмжих юм бэ? Энэ спортод оруулсан хөрөнгө оруулалтыг гэдэг асуудал байгаа байхгүй юу.

Энэ дээр энэ хуульд бодвол шинэлэг заалт тусгагдаж байгаа байх.

Цаашдаа энэ спортыг дэмжигч байгууллага, хувь хүмүүсийг төрөөс тодорхой хугацаанд дэмждэг байж байж наад хүн хүнийг чинь олширч байж цаашдаа спортын төлөө амжилт гаргана гэж бодож байгаа. Спортын материаллаг бааз сайжирна.

Тийм учраас энэ чиглэлээр хуульд тусгасан асуудал байна уу гэсэн ийм 3 зүйл асууя.

Тэр допингтой холбоотой асуудал дээр нэг ийм юм байгаа юм. Манай үндэсний бөх гэхэд дампуурчихсан юм байгаа юм. Тэр одоо яаж цэгцлэх юм бэ? Б.Бат-Эрдэнэ сайд аа.

Зарим дээр нь 8 жилийг хаслаа л гэдэг юм.

Зарим нь 4 жил хаслаа л гэдэг юм.

Зарим нь 2 жил хаслаа л гэдэг юм.

Зарим нь огт шийтгэлгүй бүр цолоо нэмээд л яваад байдаг юм.

Заримынх нь цолыг хасаад л байдаг юм.

Заримынх нь огт хасдаггүй бүр нэмээд яваад байдаг байхгүй юу.

Тэгээд энэ нэг дампуу юмыг одоо энэ хуулиар нь цэгцэлж чадаж байгаа юу? Бид нар. Цаашдаа үүнийг нэг цэгцэд оруулахгүй бол үзэмжээрээ хандаад байгаа байхгүй юу. Хүн хүнээс, хувь хүний үзэмжээр нь.

Заримд нь 8 жилээр хасаж хаяад л, заримд нь 4 жил хасаж хаяад л, заримыг нь цолыг хураагаад л, заримыг нь хураахгүй үлдээгээд л ингээд байгаа байхгүй юу.

Дээр нь манайхан сүүлийн үед нэг моод гарчихсан юм шиг байгаа юм. Нөгөө шүүхээр явдаг, арбитраар явдаг гээд л. Ингээд нэг сонин.

Үүнийг бүгдийг нь таслан зогсоож энэ хуульд орсон юм байна уу гэдэг ийм зүйлийг асууж байгаа юм.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Асуултад хариулъя. Б.Бат-Эрдэнэ сайд хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: (18-р тойрог, Хэнтий аймаг)

Баярлалаа. Д.Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя.

Энэ 5 дугаар бүлэг дээр допингийн эсрэг үйл ажиллагаа гээд бүхэл бүтэн бүлэг оруулсан байгаа.

Энд гарын үсэг зурагч талууд гээд энэ Олон улсын допингийн эсрэг байгууллагын ийм дүрэмд заагдсаны дагуу Монголын Үндэсний Олимпийн Хороо, Монголын үндэсний паралимпын хороо, Допингийн үндэсний байгууллагууд, тэгээд Засгийн газрын оролцоотой ийм гарын үсэг зурагч талууд орно.

Спортод сэргээш эрхлэхийн эсрэг олон улсын конвенц, “Копенхагений тунхаглал”, Дэлхийн болон допингийн эсрэг үндэсний дүрмийн хэрэгжилт зохион байгуулах ийм чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэхээр энэ хуулийн төсөл дээр орсон байгаа.

Энэ допингийн эсрэг MONADA буюу энэ байгууллага маань Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу ил тод байдлыг хангаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах, сайн засаглалыг хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, тамирчны эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрүүл мэндийг хамгаалах, допингтой холбоотой аливаа маргааныг олон улс, үндэсний спортын арбитрын

чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөх байгууллага хэрэгжүүлэхээр.

Ингээд энэ хуульд Спортын арбитрын шүүх гэж Спортын холбоодтой аливаа хэрэг маргааныг шийдвэрлэдэг ийм олон улсын байгууллага бий.

Яг MONADA-той адилхан WADA-гийн гишүүнчлэлтэй MONADA байгууллагатай адилхан энэ арбитрын олон улсын арбитрын байгууллагын төлөөлөл Монголд үйл ажиллагаа явуулж байгаа.

Энэ байгууллагын үйл ажиллагааг хэрхэн хангах талаар энэ хуулийн төсөлд тодорхой оруулсан байгаа.

Тийм учраас энэ Допингийн эсрэг үндэсний байгууллагын үйл ажиллагаа өмнөх энэ алдаа дутагдал, завхралыг бүрэн хэмжээгээр засахаар олон улсын WADA байгууллагын дүрмийн хүрээнд нийцэл хийсэн. Энэ бүхэл бүтэн бүлэг, зүйлийг оруулж өгсөн.

Тийм учраас дахиж ийм асуудлууд гарахааргүй болно.

Дотоодын энэ маргаантай ийм асуудлууд нь шийдэгдэнэ. Өмнө нь тэр банд болох цагаан тугийн доор Монголын баг олимпод оролцох ийм нөхцөл байдал үүссэн байх үед тэр MONADA байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр дүрмийн өөрчлөлтүүдийг хийсэн. Эхний ээлжийн WADA-гаас тавьсан шаардлагуудыг биелүүлээд ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ бол яг одоо энэ хуульд батлагдсанаар энэ допингтой холбоотой допингийн эсрэг үндэсний байгууллагын тэр бүтэц, тогтолцоо, үйл ажиллагаатай

холбоотой юмнууд нь бүрэн хэмжээнд шийдэгдээд явна.

Биеийн тамирын салбарын санхүүжилттэй холбоотой асуудал. Үнэхээр энэ хөрөнгө мөнгө нь дутуу дулимаг.

Ялангуяа орон нутгийн биеийн тамирын байгууллагын төсөв, хөрөнгө, материаллаг бааз, энэ бүх юм бол үндсэндээ үе үеийн парламентын гишүүдийн санаачилгаар хийгдэж төсөвт тавигдаж ингэж ирсэн.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд 330 сумаас 119 сум бие даасан ийм биеийн тамирын цогцолбор сургуулийн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хорооны саналаар Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Санал хураалт. /алх цохив/

57.9 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Дараагийнхаа асуудалд орёе. **18:33**

Арав.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг ажлын хэсгийн ахлагчийн саналаар маргаашийн буюу Баасан гаргийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ.

Дараагийнхаа асуудалд орёе.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирт танилцуулна.

Таныг индэрт урьж байна. 18.00 цаг болсон байна. Чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлэн явуулахаар шийдлээ. /алх цохив/

Ц.Сандаг-Очир: (21-р тойрог, Налайх, Багануур,
Багахангай дүүрэг)

Улсын Их Хурлын дэд дарга, Эрхэм
гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас
2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр
Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн
Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай
хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг
Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 04
дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн
хуралдаанаар хэлэлцэж анхны
хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн
байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны
04 дүгээр сарын 24-ний өдрийн
хуралдаанаараа хуулийн төслийн анхны
хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу
явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь
хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар
хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг
явуулах үед Улсын Их Хурлын гишүүн
Г.Тэмүүлэн төслийн 2 дугаар зүйлийг
хасах санал гаргасныг хуралдаанд
оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Гаалийн албан татвараас чөлөөлөх
тухай хуулийн төслийн анхны
хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын
хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй
саналын томьёололыг Та бүхэнд
хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх
тухай

хуулийн төслийн анхны
хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн
байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын
зөрүүтэй саналын томьёоллийг хэлэлцэн
шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Байнгын хорооны санал, дүгнэлттэй
холбогдуулан асуулт асуух гишүүн байна
уу? Байхгүй байна. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан
зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор
санал хураая. Зарчмын зөрүүтэй нэг санал
байна.

Гишүүд байраа эзэлье. Гаалийн
албан татвараас чөлөөлөх тухай хуулийн
төслийн талаарх зарчмын зөрүүтэй
саналын томьёололыг танилцуулъя.
Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал
байна.

Төслийн 2 дугаар зүйлийг хасаж, 3
дугаар зүйлийн дугаарыг 2 гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын
гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Санал хураалт. /алх цохив/

51.4 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын
томьёоллоор санал хурааж дууслаа. /алх
цохив/

Гаалийн албан татвараас чөлөөлөх
тухай хуулийн төслийг эцсийн
хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн
байнгын хороонд шилжүүлээ.

Дараагийнхаа асуудал оръё. **18:40**

Арван нэг.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.04.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир: (21-р тойрог, Налайх, Багануур,

Багахангай дүүрэг)

Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төслийн 2 дугаар зүйлийг

хасах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёолойг Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллийг хэлэлцэн шийдвэрлэхийг Та бүхнээс хүсье.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёололыг танилцуулъя.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийг хасаж, 3 дугаар зүйлийн дугаарыг 2 гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Санал хураалт. /алх цохив/

54.1 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийнхаа асуудалд оръё. [18:42](#)

**Арван хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн
2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/**

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хороон дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна.

Г.Тэмүүлэн: (1-р тойрог, Архангай аймаг)

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд нэмж тусган, төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: (17-р тойрог, Хөвсгөл аймаг)

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Санал хураалт. /алх цохив/

51.4 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлөж. /алх цохив/

Хуралдаан 5 цаг 43 минут үргэлжилж, 18 цаг 45 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД